



МОНГОЛБАНК

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2010 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ

Улаанбаатар
2009 он

Төрийн мөнгөний бодлого нь инфляцийг дунд хугацаанд тогтвортой, нам түвшинд хүргэж бууруулах замаар нийгмийн амьжиргааны түвшинг хамгаалах, санхүүгийн зах зээл, банкны салбарын тогтвортой байдлыг хангах, мөнгөний бодлогын үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ. Санхүүгийн зах зээлийн бүтэц, дэд бүтцийг хөгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.

Монголбанк инфляцийг бууруулахад чиглэсэн шийдвэрээ бие даасан, мөнгөний болон сангийн бодлогын харилцан уялдааг хангасан хэлбэрээр хэрэгжүүлнэ. Энэхүү бодлого нь төрийн бодлогын уламжлалыг хадгалсан, зах зээлийн өөрчлөлтийг тухай бүр тусгасан, дунд хугацааны зорилготой нийцсэн байдалаар хэрэгжинэ.

ГАРЧИГ

I. ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2010 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ	5
II. ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2009 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ	18
1. МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД	18
2. САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ХҮРЭЭНД	35
3. ТӨВ БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД	45
III. ТӨСЛИЙН ТООЦОО СУДАЛГАА	49
1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ	49
1.1. Эдийн засгийн өсөлт	49
1.2. Инфляци, түүний өөрчлөлтийн шалтгаан	50
1.3. Гадаад худалдаа	55
1.4. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн хөдөлгөөн, гадаад төлбөр тооцоо	58
1.5. Гадаад эдийн засгийн орчин	62
2. ИНФЛЯЦИ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН 2009-2011 ОНЫ ЧИГ ХАНДЛАГА	66
2.1. Инфляци, эдийн засгийн өсөлтийн 2009-2011 оны чиг хандлага	66
2.2. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл	68
2.3. Инфляци, эдийн засгийн өсөлтийн төсөөллийн тодорхой бус байдал	70
3. МӨНГӨНИЙ БОДЛОГО	72
3.1. Мөнгөний нийлүүлэлт	72
3.2. Зээлийн хүү.	76
3.3. Мөнгөний зах	79
3.4. Урсгал дансны 2009 оны 2 дугаар улирлын гүйцэтгэл	82
3.5. Төлбөрийн тэнцлийн үзүүлэлтүүд	86
3.6. Гадаад валютын улсын албан нөөцийн эрсдлийн удирдлага	87
4. САНХҮҮГИЙН САЛБАР, БАНКНЫ ЗУУЧЛАЛЫН ТОЙМ	88
4.1. Банкны салбарын өнөөгийн байдал, учирч буй бэрхшээл	88
4.2. Банкны хяналт шалгалт	92
4.3. Төлбөр тооцооны систем	94
4.4. Банкны эрх зүйн шинэчлэл	96
5. СТАТИСТИКИЙН ХАВСРАЛТУУД	98
5.1. Мөнгөний үзүүлэлтүүд	98

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

**Төрөөс мөнгөний бодлогын талаар 2010
онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2010 онд баримтлах үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.
2. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг улирал тутам Улсын Их Хуралд танилцуулж байхыг Монголбанк /Л.Пүрэвдорж/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН

ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

ТӨСӨЛ
Монгол Улсын Их Хурлын
2009 оны ... дугаар тогтоолын хавсралт.

I. ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2010 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Төрийн мөнгөний бодлогын үндсэн зорилт нь ойрын болон дунд хугацаанд инфляцийг нам түвшинд тогтвортжуулахад оршино. Энэхүү үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бий болгох, эдийн засгийн өсөлтийг сэргээж, тогтвортжуулахад чиглэсэн мөнгөний бодлогыг төсвийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.

1. Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд

- 1.1. 2010 онд хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг найман хувиас хэтрүүлэхгүй түвшинд байлгаж, цаашид тогтвортжуулах, эдийн засгийн мөчлөгийн сөрөг нөлөөг бууруулж, эдийн засгийн өсөлтийг сэргээх бодлого баримтална.
- 1.2. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш макро эдийн засгийн суурь нөхцлөөр тодорхойлогдон уян хатан тогтох байх зарчмыг баримтална. Дэлхийн санхүүгийн зах зээлийн болон гадаад худалдааны нөхцлийн огцом өөрчлөлтийг төгрөгийн гадаад валюттай харьцах уян хатан ханш, мөнгөний бодлогын арга хэрэгслээр дамжуулан зохицуулж, гадаад валютын албан нөөцийг хамгаална.
- 1.3. Гадаад валютын дотоод дахь зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлж, төгрөгийн ханш уян хатан тогтох нөхцлийг сайжруулна.
- 1.4. Банкны салбарт үүссэн зээлийн тасалдлыг зогсоож, банкны салбараас зээл олгох, зээл авах идэвхийг сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2. Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, цаашид өөрчлөн сайжруулах хүрээнд

- 2.1. Банкны өөрийн хөрөнгийн хүндрэлийг арилгах, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг бэхжүүлэх, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлогыг Засгийн газартай хамтран олон улсын санхүүгийн байгууллагын дэмжлэгтэйгээр боловсруулж, хэрэгжүүлнэ.

- 2.2. Иргэд, бизнес эрхлэгчид болон хөрөнгө оруулагчдаас банкны салбарт итгэх итгэлийг нэмэгдүүлэх, банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг тууштай хамгаалах зорилгоор банкны хяналт шалгалтын нэгдсэн тогтолцоог холбогдох байгууллагуудтай хамтран нэвтрүүлнэ.
- 2.3. Эрсдэлд сууринсан банкны зохистой харьцааны үзүүлэлтийг хангуулан, санхүүгийн сахилга батыг чангатгаж, банкны санхүүгийн тайлагнال болон өмчлөлийн байдлыг олон нийтэд нээлттэй, ил тод болгоно.
- 2.4. Банкны системд бүтцийн өөрчлөлт хийж, эрсдэл даах чадвартай, удирдлагын сайн засаглалын зарчимд тулгуурласан, санхүүгийн зуучлалыг үр өгөөжтэй явуулахуйц банкны тогтолцоог бий болгох дунд хугацааны хөтөлбөр Засгийн газартай хамтран боловсруулан хэрэгжүүлж эхэлнэ.

3. Төв банкны бусад үйл ажиллагааны хүрээнд

- 3.1. Монголбанкны үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх, мөнгөний бодлогын талаарх олон нийтийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор мөнгөний бодлогын зорилт, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүний хүлээгдэж буй үр дүнгийн талаар тогтмол тайлбарлан таниулж, мөнгөний бодлогын зорилтоо хангаж олон нийтийн мөнгөний бодлогод итгэх итгэлийг нэмэгдүүлнэ.
- 3.2. Монгол Улсын төлбөр тооцооны системийн тасралтгүй, найдвартай байдлыг хангаж, мэдээллийн технологид сууринсан бэлэн бус төлбөрийн хэрэгсэл (мобайл, интернет, карт гэх мэт)-ээр хийх төлбөр тооцооны эрх зүйн орчинг бүрдүүлэх эхлэлийг тавьж, картын гүйлгээг банк хооронд 24 цагаар тасралтгүй дамжуулдаг клирингийн үйлчилгээг нэвтрүүлнэ.
- 3.3. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль зүйн орчинг боловсронгуй болгож, банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдээс мэдээлэл авах үйл ажиллагааг эхлүүлж, хуулийн байгууллагатай хамтын ажиллагаагаа сайжруулна.

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2010 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1. Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд

Төв банк ойрын болон дунд хугацаанд тогтвортой нам түвшний инфляци бүхий эдийн засгийн орчинг бүрдүүлэх замаар бизнес эрхлэгчид, хэрэглэгчдийн шийдвэр гаргахад учирдаг тодорхой бус байдлыг багасгаж, санхүүгийн зуучлалын үнийг бууруулан, хэрэглээ болон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийг зорино. Ингэснээр санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал, ажил эрхлэлт, эдийн засгийн өсөлт нэмэгдэх суурь нөхцлийг бүрдүүлэх юм.

2009 оны эхний 8 сарын байдлаар улсын хэмжээнд жилийн инфляци 0.6 хувь болж буурав. Инфляци ийнхүү буурсан нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханш чангач харьцангуй тогтвожсон, хүнсний бүтээгдэхүүний үнэ алгуур буурч, эдийн засгийн уналтыг даган өрхийн хэрэглээ нэмэгдэхгүй байгаагаас эрэлтийн шалтгаантай инфляци бий болохгүй байгаагаар тайлбарлагдаж буй юм. Харин 2009 оны сүүлийн хагас жилийн таамаглалаас үзэхэд жилийн инфляци 2009 оны эцэст 2.3-5.2 хувь, харин 2010 оны эцэст 6.2-11.9 хувьд хүрч өсөхөөр байгаа нь бидний тооцоолсон зохицой түвшнээс давж болзошгүй байна. Эдийн засгийн өсөлт 2009 оны эцэст 0.8-2.1 хувь, харин 2010 оны эцэст 4.1-8.3 хувийн хооронд байх төлөвтэй байна.

Инфляци эргээд өсөх дээрх хандлага уул уурхайн салбарын өсөлтийг дагасан хөрөнгийн дотогшлох урсгал, түүнд тулгуурласан төсвийн тэлэлт, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн хэлбэлзэл, дэлхийн болон дотоодын зах зээл дээрх шатахуун, хүнсний бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт зэргээс хамааран бүрэлдэх боломжтой байна. Иймээс инфляцийг нэг оронтой тооноос хэтрүүлэхгүй байх зорилтын хүрээнд богино хугацаанд мөнгөний огцом тэлэх бодлого явулахаас зайлсхийж, төсөв мөнгөний хосолсон бодлогоор инфляцийг нам түвшинд тогтвортой байлгах замаар эдийн засгийн өсөлтийг сэргээх нь эн тэргүүний зорилт гэж Монголбанк үзэж байна. Инфляцийг нам түвшинд, тогтвортой байлгах нөхцөл хангагдахын хэрээр мөнгөний бодлогын хэрэгслүүдийг эдийн засгийг сэргээх, жигд тогтвортой өсөлтийг хангах зорилготой нийцтэй байдлаар зах зээлийн өөрчлөлтийн тухайн үеийн нөхцөл байдалд тохирсон хэлбэрээр цаг алдалгүй өөрчлөн тохируулах бодлого баримтлана. Ингэхдээ макро эдийн засгийн суурь үзүүлэлтүүдтэй бодлогын хүүг уялдуулан өөрчлөх, зээл олгох, авах идэвхийг сэргээх, банкны салбарт бүтцийн өөрчлөлт хийх, банкуудыг дахин хөрөнгөжүүлэх, нийт эрэлтийг дэмжих арга хэмжээг төсвийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ. Ингэснээр 2010 онд эдийн засгийн өсөлтийг сэргээн, 2008 оны түвшинд ойртуулах, 2011 оноос өмнөх онуудын түвшинд хүргэн нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

2009 оны 4 дүгээр сараас валютын ханш тогтвржин, банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар сайжирч эхэлмэгц Монголбанк эдийн засгийг сэргээх, зээлийн тасалдлыг зогсоох зорилгоор бодлогын хүүгээ 2.5 хувиар бууруулж, банкуудад Төв банкны санхүүжилтийн хэрэгслүүдээр дамжуулан эх үүсвэр олгосноор банкуудын илүүдэл нөөц¹ буюу зээл олгох боломжтой эх үүсвэр 5 дугаар сараас тогтмол өсч 8 дугаар сарын эцсийн байдлаар 295.7 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнө байгаагүй өндөр үзүүлэлт юм. Ийнхүү банкуудын зээл олгох боломжтой эх үүсвэр өсч байгаа ч зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны түвшнээсээ буурсаар байгаа нь санхүүгийн зуучлал хумигдан мөнгөний бодлогоор эрэлтийг урамшуулах уламжлалт арга хэрэглэхэд үр өгөөж муутай байгааг нотолж байна. Иймээс эдийн засгийн идэвх удаан сэргэж байгаа салбарыг дэмжихэд 2010 оны төсвийн бодлогыг чиглүүлэх нь илүү үр дүнтэй гэж үзэж байна.

Төгрөгийн гадаад валюттай харьцах бодит ханш, “тэнцвэрт”² түвшнээсээ хэт дээгүүр эсвэл доогуур үнэлэгдэх нь төгрөгийн нэрлэсэн ханшийн богино хугацааны хэлбэлзлийг нэмэгдүүлэх, урсгал тэнцлийг тогтвортгүй болгох, валютын ханшийн ашиг хонжооны довтолгоо үүсэх нөхцлийг бүрдүүлэх, улсын гадаад өрийг нэмэгдүүлэх болон эдийн засгийн өсөлтөнд сөргөөр нөлөөлдөг нь бусад орнуудын туршлагаар нотлогдсон билээ. Иймд Монголбанк дунд хугацаанд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш макро эдийн засгийн суурь нөхцлөөр тодорхойлогдон, уян хатан тогтох зарчмыг баримтлах нь зүйтэй гэж үзэж байна.

Гадаад валютын цэвэр албан нөөцийг нэмэгдүүлж, хамгаалах нь гүйлгээнд байгаа үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн баталгаа болох төдийгүй төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн тогтвортой байдлын талаарх олон нийтийн хүлээлтэнд эерэгээр нөлөөлөхийн зэрэгцээ валютын ханшийн ашиг хонжооны довтолгооноос сэргийлэхэд чухал ач холбогдолтой юм. Иймд дэлхийн санхүүгийн зах зээл, хөрөнгийн урсгал болон гадаад худалдааны нөхцөлд огцом өөрчлөлт гарах тохиолдолд Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн уян хатан дэглэм баримтлан гадаад валютын цэвэр албан нөөцөө хамгаалах нь зохистой бодлого гэж үзэж байна. Учир нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханш уян хатан тогтох байх нь экспортын эрэлтийг нэмэгдүүлэх замаар гадаад худалдааны алдагдлыг бууруулна. Энэ нь улмаар хөрөнгийн цэвэр дотогшлох урсгалыг өсгөж, дотоодын үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. Ингэснээр гадаад валютын дотоодын зах зээл дээрх цэвэр нийлүүлэлт болон гадаад валютын цэвэр албан нөөц нэмэгдэх боломж бий болохын зэрэгцээ дунд хугацаанд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тогтвржих, экспортод чиглэсэн үндэсний үйлдвэрлэл нэмэгдэх болно.

¹ Төв банкны санхүүжилтийг хасч, төв банкны үнэт цаасыг нэмж тооцсон илүүдэл нөөц (Анод банкинд олгосон санхүүжилтийг оруулаагүй)

² Үндэсний мөнгөн тэмдэгтийн гадаад валюттай харьцах ханш дунд болон урт хугацаанд макро эдийн засгийн суурь үзүүлэлтээр тодорхойлогдон уян хатан өөрчлөгддөг бөгөөд уг зарчмаар тогтох буй ханшийг “тэнцвэрт” ханш гэж нэрлэдэг.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн богино хугацааны хэлбэлзэлд олон нийтийн ханшийн талаарх хүлээлт, валютын зах зээлд оролцогчдын гадаад актив, пассивын зөрүү, гадаад худалдааны нөхцөл болон хөрөнгийн урсгалын огцом хэлбэлзэл, дотоодын банк хоорондын зах зээл дээрх гэнэтийн өөрчлөлт нөлөөлж байна. Алтны дэлхийн зах зээл дээрх үнэ 2009 оны 9 дүгээр сарын байдлаар харьцангуй өндөр түвшинд хүрч, зэсийн үнэ өсч байгаа хэдий ч импортын гол бүтээгдэхүүн болох шатахуун, зарим хүнсний бүтээгдэхүүний үнэ илүү хурдан өсөх хандлагатай байна. Энэ нь 2010 оны эхний хагас хүртэлх хугацаанд гадаад худалдааны нөхцлийг муутгаж болзошгүй байна. Иймд гадаад орчны тодорхой бус байдал өндөр хэвээр байгаа үед Монголбанк төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн богино хугацааны цочмог хэлбэлзлийг зөвлүүлэх чиглэлд банк хоорондын валютын зах зээл дээр оролцно. Үүний зэрэгцээ төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн хэлбэлзлээс хүлээж болох эрсдлийг бууруулах мөнгөний бодлогын хэрэгслийг ашиглан ажиллана.

Дэлхийн эдийн засгийн сэргэлтийг даган гадаад зах зээлийн таатай орчин бүрдэж, Оюу толгой зэрэг уул уурхайн томоохон ордуудыг ашигласнаар хөрөнгийн дотогшлох урсгал нэмэгдэхээр байгаа нь 2010 оны 2 дугаар хагасаас төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг чангариулж болзошгүй юм. Ийнхүү төгрөгийн ханш чангарвал гадаад валютын цэвэр албан нөөц өсөх, үүнийг даган бодит эдийн засагт инфляцийн дарамтгүйгээр төгрөгийн нийлүүлэлтийг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжих бололцоо үүсэх талтай юм. Гэхдээ төгрөгийн гадаад валюттай харьцах ханш эрчимтэй чангараах нь эргээд үндэсний үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг бууруулж, дотоодын хэрэглээ импортыг урамшуулж эдийн засгийн тогтвортой өсөлтөнд зарим сөрөг нөлөө үзүүлнэ. Хэрэв төгрөгийн гадаад валюттай харьцах ханш үргэлжлэн чангараах тохиолдолд Монголбанк эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлттэй нийцтэй байдлаар төгрөгийн гадаад валюттай харьцах ханшид зохицуулалт хийж ажиллах болно.

Дээрх бодлогуудыг хэрэгжүүлэх явцад төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн огцом хэлбэлзлийг бий болгохгүй байх³, Стэнд-бай хөтөлбөрийн хүрээнд тохирсон 2009 оны гадаад валютын цэвэр албан нөөцийн зорилтот түвшинг хангах, импортын үнийн өсөлтөөс үүдсэн инфляцийн дарамтыг бууруулахад чиглэсэн мөнгөний оновчтой бодлого (стерлизаци, интервенцийн нягт уялдсан бодлого)-ыг төгрөгийн гадаад валюттай харьцах уян хатан ханшийн бодлоготой зэрэгцүүлэн явуулна.

Макро эдийн засагт үүсээд байгаа өөр нэг хүндрэл нь банкны салбарын зээлийн тасалдал юм. 2009 оны эхний 8 сард банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар сэргэж, банкны системийн илүүдэл нөөц тогтмол өсч байсан хэдий ч банкнаас хувийн секторт олгосон зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт саарч, 6 дугаар сараас эхлэн

³ Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш огцом суларч эсвэл чангараах нь олон нийтийн ханшийн талаарх хүлээлтэнд нөлөөлөх, ирээдүйн ханшийн талаарх тодорхой бус байдлыг нэмэгдүүлэх зэргээр санхүүгийн хувьд үр ашиггүй хэлцэл хийхэд хүргэх эрсдэлтэй байдаг.

сөрөг болоод байна. Үүний зэрэгцээ сүүлийн 12 сард банкны чанаргүй зээл 4.8 дахин өсч, нийт зээлийн багцад эзлэх хувь нь 11 нэгж хувиар нэмэгдэн банкны системийн зээлийн чанар хурдан муудаж байна. Эдгээр нь зээлийн тасалдлын статистик тоон гол илэрхийлэл юм. Зээлийн тасалдал нь нэг талаас зээлийн эрсдэл нэмэгдсэнээс банкууд зээл олгох сонирхолгүй болж, зээлийн нийлүүлэлт буурсан, нөгөө талаас эдийн засгийн хямрал, зах зээлийн эрсдэл нэмэгдсэнээс хувийн хэвшил зээл авах чадвараа алдаж, зээлийн эрэлт багасч, эсвэл хэвийн ажиллаж байгаа компаниуд зах зээлийн эрэлт хомсдсон, тодорхой бус байдал нэмэгдсэн зэргээс хамааран бизнесээ өргөтгөх сонирхолгүй болж банкны зээлдэгч бус, хөрөнгө хадгалулагч болж хувирах хэлбэртэй байна. Банкны салбарт зээлийн тасалдал үүсэх болсон нь дараах үндсэн хоёр шалтгаантай гэж үзэж байна.

Нэгдүгээрт: Өмнөх жилүүдийн зээлийн өндөр өсөлт эдийн засгийн зээлжих потенциалаас давах болсон. Сүүлийн 5 жилд гадаад эдийн засгийн таатай орчин бүрдэн, эдийн засгийн өсөлт 7-11 хувьд хүрч, эдийн засаг хүчтэй тэлсэн. Үүний нөлөөгөөр банкууд зээл олголтоо тогтмол нэмэгдүүлж, зээлжүүлэх чадвараа шавхагдтал зээл олгож байсныг дээрх хугацаанд банкуудын зээлийн өрийн үлдэгдэл 2 дахин нэмэгдэж, татан төвлөрүүлсэн хөрөнгөөсөө 1.4 дахин их хэмжээний зээл олгосноос харж болно. Гэвч зээлийн энэхүү өсөлт нь тэр бүр үр ашигтай байгаагүй болохыг банкуудын зээлийн өсөлтөөр нэмэгдэх үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ сүүлийн жилүүдэд буурч байгаагаар баталж болно. Тухайлбал барилгын салбарт зээлжих чадвараас нь илүү их хэмжээтэй зээл олгогдсон байна.

Хоёрдугаарт: Гадаад эдийн засгийн орчин муудсан. Ялангуяа шатахуун, зарим хүнсний бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ өсч, зэсийн үнэ бууран, хөрөнгийн дотогшлох урсгал огцом татрах зэргээр эдийн засгийн гадаад орчин муудсан. 2007 онд дэлхийн зах зээл дээр шатахуун, зарим хүнсний бүтээгдэхүүний үнэ огцом өсч, төсвийн болон мөнгөний нийлүүлэлтийн тэлэлтийн улмаас дотоодод инфляци өсч хоёр оронтой тоогоор хэмжигдэх болсноос нэрлэсэн хүүнээс инфляцийг хасч тооцдог бодит хүү сөрөг түвшинд хүрч санхүүгийн зуучлалын хэмжээг бууруулсан. 2008 оны сүүлийн хагасаас дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал эрчимжиж, хөгжингүй орнуудын Монгол Улсад хийхээр төлөвлөж байсан хөрөнгө оруулалт хойшлогдоноос хөрөнгийн дотогшлох урсгал буурсан. Тухайлбал, ХААН банк олон улсын зах зээл дээр гаргахаар төлөвлөж байсан 300 сая ам.долларын бонд, Швейцарийн Кредит Свисс банкнаас Голомт банкинд хийхээр төлөвлөж байсан 10 сая ам.долларын хөрөнгө оруулалтууд зогссон. Мөн дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэ 2008 оны 3 дугаар улирлаас унах болсноор экспорт, улмаар төсвийн орлого багассан нь банкууд дээр байршиж байсан төсвийн болон том харилцагчдын харилцахыг богино хугацаанд бууруулсан. Эдгээр хүчин зүйлсийн сөрөг нөлөөгөөр банкуудын эх үүсвэр буурч, зээлийн нийлүүлэлтээ хумих нөхцөл бүрдсэн. Нөгөө талаар улсын төсөв багасч, айл өрх, аж ахуйн нэгж хямралын нөхцөлд тохируулан хэрэглээ, үйлдвэрлэл, үйлчилгээний зардлаа тооцож, хэмнэлтийн горимд шилжсэний дээр банкны зээлийн

нийлүүлэлт хумигдан, зээл олгох шалгуур чангарсан нь хэрэглээ, үйлдвэрлэлийг хязгаарлах болсон.

Ийнхүү зээлийн тасалдал гүнзгийрч, банкны салбарын санхүүгийн зуучлал хумигдах болсон нь мөнгөний бодлогын зээл, хүүний сувгийн нөлөөллийг сулруулж байгаагаас эдийн засгийн өсөлтийг сэргээх, банкны салбарын тогтвортой байдлыг хангахад төсвийн бодлого мөнгөний бодлогоос илүү үр нөлөөг үзүүлэхээр байна. Иймээс ч бусад улс орнууд эдийн засгийг сэргээх, өсөлтийг хангахад дараах хоёр төрлийн уламжлалт бус бодлогын арга хэмжээг төсвийн тэлэх бодлогоор цаг хугацааны хувьд харилцан уялдаатайгаар хэрэгжүүлж байна. Үүнд: **нэгдүгээрт:** Төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар өрхийн хэрэглээ, нийт эрэлтийг дэмжин үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудын борлуулалтыг нэмэгдүүлэн бодит эдийн засгийн хэвийн үйл ажиллагааг сэргээх хөрсийг бүрдүүлэхэд илүү анхаарал тавьж байна. Үүний үр дүнд бизнесийн орлого нэмэгдэж, зээл авах шалгуурыг хангаж, зээлийн эрэлт өсөхийн зэрэгцээ банкууд эдийн засгийн өгөөж харьцангуй өндөр, эрсдэл багатай салбарт зээл түлхүү олгож зээлийн багцын чанараа сайжруулах, санхүүгийн эх үүсвэрийг макро эдийн засгийн салбаруудад дахин хуваарилах боломжийг бүрдүүлэхийг чармайх болно, **хоёрдугаарт:** Банкуудыг дахин хөрөнгөжүүлэх, бүтцийн өөрчлөлтийг хийх, чанаргүй зээлийн дарамтыг бууруулах зэргээр хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх. Эхний арга хэмжээ нь хувийн секторт бизнесийн идэвхийг сэргээж, зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх хэдий ч банкуудын зээл олгох сонирхол болон чадавхид шууд нөлөө үзүүлэхгүй. Зээлийн чанар хурдан муудаж байгаагаас банкуудын шинээр зээл олгоходо болгоомжтой хандан, хуучин зээлээ төлүүлэхэд түлхүү анхаарч байна. Иймд банкуудын зээл олгох чадварыг нэмэгдүүлэхийн тулд банкуудын хөрөнгийн чадварыг дээшлүүлэх, чанаргүй зээлийн дарамтаас салгах арга хэмжээг Монголбанк Засгийн газартай хамтран банкны салбарын бүтцийн өөрчлөлтийн бодлоготой уялдуулан, олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Энэхүү хоёр арга хэмжээ нь зээлийн эрэлт, нийлүүлэлтийг нэгэн адил дэмжин, зээлийн тасалдлыг зогсооход зайлшгүй шаардлагатай байна.

2. Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, цаашид өөрчлөн сайжруулах хүрээнд

2009 оны эхний хагаст ДНБ 1.3 хувиар агшсан нь аж үйлдвэр, барилгын салбарын үйлдвэрлэл буурсантай холбоотой байна. Хэрэглээ, хөрөнгө оруулалт ихээр хумигдан, аж ахуйн нэгжүүдийн борлуулалт эрс буурч орлогын түвшин доошилсноор иргэд, бизнес эрхлэгчид банкнаас авсан зээлийн үндсэн өр, хүүгээ хугацаанд нь барагдуулж чадахгүй байх явдал газар авч байна. 2000 оноос хойш анх удаа 2008 оны 9 дүгээр сараас хадгаламж, харилцах их хэмжээгээр валют болон хувирч гадагшилснаас үүдэлтэй банкны эх үүсвэрийн хямралыг 2009 оны хавар гэхэд Монголын банкууд

зогсоож чадсан. Банкуудад харилцагчдын төлбөрийг саадгүй гүйцэтгэхэд зориулан төв банкнаас 267.2 тэрбум төгрөгийн зээлийг олгож, банкуудын зээл, эх үүсвэрийн харьцааг сайжруулах арга хэмжээ авч ажилласан.

Төр засгийн зүгээс хямралыг гэтлэн давах төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх, олон улсын санхүүгийн байгууллага болон бусад хандивлагч улс орноос зээл тусlamж авах, уул уурхайн томоохон төслийг эхлүүлэх, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, банкин дахь мөнгөн хадгаламж болон харилцахад баталгаа гаргах, системийн ач холбогдол бүхий банк санхүүгийн байгууллагад эрсдлийн сангаас хөрөнгө байршуулах зэрэг олон тооны арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь үр дүнгээ өгч байна. Мөн Монголбанк хямралын өнөөгийн орчинд зээлийг нэг удаа биш, хоёр удаа сунгах зөвшөөрлийг банкуудад олгон, эрсдлийн сангийн хувь хэмжээг түр хугацаагаар бууруулан тооцох зохицуулалтыг хийсэн. Арилжааны банкууд зээлийг төлүүлэхдээ анхны гэрээг харилцагчид тулгалгүйгээр үүссэн бодит нөхцөл байдалд тохируулан зээлийн нөхцөл, хугацаа, хүнд уян хатан хандан өөрчилж байна. Гэсэн хэдий ч бодит эдийн засгийн нөхцөл байдлаас үүдэн банкуудын хугацаа хэтэрсэн зээл 2009 оны 8 дугаар сарын 31-ний өдрийг жилийн өмнөхтэй харьцуулахад 22.6 хувиар, чанаргүй зээл 4.8 дахин тус тус өссөн нь банкны салбарын нийт өөрийн хөрөнгийг 178.6 тэрбум төгрөгөөр буурууллаа. Анод банкийг хасч тооцсон дүнгээр Монголын банкны салбарын эрсдлээр жигнэсэн активыг өөрийн хөрөнгөнд харьцуулсан харьцаа 13.1 хувь (12 хувь байх ёстой) байгаа ч цөөнгүй банк өөрийн хөрөнгийн дутагдалд ороод байна. Энэ хандлага цаашид лавширч дийлэнх банк өөрийн хөрөнгийн дутагдалд орж болзошгүй байна.

Монголбанкнаас энэ нөхцөлд дараах зарчмын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- ◆ Банкуудын богино хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг тогтмол хянан, банк хоорондын захын зээлийн урсгал, хэмжээ, хүүг ажиглан шаардлагатай тохиолдолд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын түр зуурын бэрхшээлийг даван туулах зориулалтын зээлийг Монголбанкнаас олгоно.
- ◆ Банкуудын зээлийн багцын байдлыг хянан зээлийг эргэн төлүүлэхэд тэргүүн зэргийн ач холбогдол өгч, зээл, эх үүсвэрийн харьцааг зохистой түвшинд барьж ажиллах чиглэлийг Монголбанкнаас өгч, банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээнд онцгой анхаарал тавьж ажиллана.
- ◆ Макро эдийн засгийн орчин тогтвортыхын хэрээр одоо банкны салбарт хуримтлагдаад буй илүүдэл эх үүсвэрийг зээл болгон гаргах мөнгөний бодлогыг хэрэгжүүлнэ.

2009 оны эцэс рүү гадаадын нэр хүнд бүхий аудитын компаниар гол арилжааны банкуудад зээлийн багц, тэнцлийн дотуур болон гадуур хүлээсэн үүргийн цогц аудитыг хийлгэж, банк тус бүрээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид, тэр дотроо олон улсын санхүү, банкны байгууллагын

хөрөнгө оруулалтыг татахын дээр шаардлагатай бусад арга хэмжээг авч банкны салбарыг өөрийн хөрөнгийн дутагдлаас гаргах нь нэн чухал зорилт болон тавигдаж байна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын эдийн засаг өргөжин тэлэхийн хэрээр дотоод, гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэнээр санхүүгийн нэгдэл, холдинг компани, группүүдийн тоо олширч байна. Одоо мөрдөгдөж байгаа Банкны тухай хуулиар банк, түүний холбогдох этгээдийг хязгаарлагдмал явцуу хүрээнд авч үздэг. Монголбанкнаас Банкны тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулан Сангийн яам, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг, Олон улсын валютын сан зэрэг байгууллагын саналыг авч тусган Засгийн газраар хэлэлцүүлж Улсын Их Хуралд өргөн бариад байна. Нэгдсэн хяналт шалгалтанд банкнаас гадна групп, холдингийн санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг болон холбогдох банк санхүүгийн бус этгээд хамрагдах юм. Нэгдсэн хяналт шалгалтын бэлтгэл ажлын чухал хэсэг болох мэдээлэл солилцоог бий болгох үүднээс Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран харилцан ойлголцлын санамж бичгийг ёсчилсон. Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль Улсын Их Хурлаар батлагдсаны дараа Санхүүгийн зохицуулах хороо болон Сангийн яамтай хамтран нэгдсэн хяналт шалгалтын журмыг боловсруулан батлуулж мөрдүүлэх юм.

Хууль эрх зүйн орчин бүрэлдэн тогтсоноор Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, шаардлагатай тохиолдолд Сангийн яамнаас хамтран банкны оролцоотой бизнесийн групп, холдингийн ажиллагаанд нэгдсэн хяналт шалгалтыг явуулж эхэлсэнээр эрсдлийг зөвхөн банкны салбарын хязгаарлагдмал хүрээнд бус, харин өргөн хүрээтэй, бизнесийн утгаар үнэлж дүгнэх боломжтой болно. Цаашид нэгдсэн хяналт шалгалт, санхүүгийн нэгдлийн нэгдсэн тайлан, холдинг компани, санхүүгийн нэгдэлтэй холбоотой хууль, журмыг боловсронгуй болгох ажлыг үргэлжлүүлэн хийхээр төлөвлөж байна.

Ул уурхайн том төслүүд хэрэгжиж эхлэхийн хэрээр Монгол Улс хөгжлийн хувьд чанаарын цоо шинэ түвшинд гарах ирээдүйн томоохон сорилтуудад Монголын банкны салбарыг одооноос бэлтгэх асуудал зүй ёсоор тавигдана. Байгаа цөөхөн харилцах, хадгаламжийг банкууд булаацалдан өндөр үнээр татаж авснаа өөрсдийн танил тал, холбогдох этгээдүүдэд зээл болгон өгч, хажуугаар нь баталгаагүй аккредитив гэсэн хууль бус ажиллагаанд зарим банкууд холбогдон тайлан мэдээг худлаа гаргах зэрэг зөрчил гаргаж байна. Эдгээр зөрчлүүд нь хямралын өнөөгийн нөхцөлд банкны үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна. Иймд одоо байгаа банкуудын тоог цөөрүүлэн, эрсдэл даах чадвартай, олон талт санхүүгийн зуучлалыг үр өгөөжтэй явуулах хэмжээнд банкны салбараа хүргэх бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдаж байна. АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн туслалцаатайгаар эхэлсэн банкны бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг хөгжлийн шаардлагад нийцүүлэн эрсдэл даах чадвартай, удирдлагын сайн засаглалын зарчимд тулгуурласан, санхүүгийн зуучлалыг үр

өгөөжтэй явуулахуйц банкны эрүүл тогтолцоог бий болгох дунд хугацааны хөтөлбөр болгон сайжруулж Монголбанк, Засгийн газартай хамтран хэрэгжүүлж эхэлнэ.

Энэ зорилгын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулна. Үүнд:

- ◆ Эдийн засаг өсч тэлэхийн хэрээр банкуудаас нэг зээлдэгчид олгох зээлийн хэмжээг томруулах, эрсдлээ даах чадамжийг нэмэгдүүлэх зорилгоор банкны дүрмийн сангийн доод хэмжээг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлнэ.
- ◆ Банкуудад төв банкнаас тавих хяналт шалгалтыг чангатган эрсдэлд суурилсан зохистой харьцааны биелэлтийг бүрэн гүйцэд, үнэн зөв ханггуулдаг болгон нэгдсэн хяналт шалгалтыг нэвтрүүлнэ.
- ◆ Банкуудын засаглалд тавих шаардлагыг өндөржүүлэн санхүүгийн тайлагнал, өмчлөлийг ил тод болгож гадаадын нэр хүнд бүхий банк санхүүгийн байгууллагын хөрөнгө оруулалтыг татах, зээлийг нэмэгдүүлэх хөрс суурийг бүрдүүлнэ.
- ◆ Бүс нутгийн эдийн засаг, санхүүгийн хамтын ажиллагаанд Монголын банкууд оролцож, дотооддоо аймаг, бүс нутгийн банкууд ажиллах эхлэлийг бий болгоно.
- ◆ Зээлийн мэдээллийн санг алсдаа иргэд, бизнес эрхлэгчдийн зээлийн түүхийн сан болгох чиглэлээр банкууд болон холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.
- ◆ Банкуудын шимтгэлээр бүрддэг хадгаламжийн даатгалын сонгодог тогтолцоог бий болгох замаар аажмаар хувийн секторт шилжүүлнэ.
- ◆ Банкны салбарын ажилтны ёс зүйд онцгой ач холбогдол өгч сайжруулах арга хэмжээ авна.
- ◆ Банкны тоог цөөрүүлж банкны системийн үйл ажиллагааны үр өгөөж, хүртээмжийг нэмэгдүүлж, эрсдэлийн удирдлагыг нь илүү өндөр түвшинд хүргэн санхүүгийн тогтвортой байдлыг дээшлүүлэх арга хэмжээ авна.

3. Төв банкны бусад үйл ажиллагааны хүрээнд

Олон нийтийн итгэлийг хүлээхгүйгээр Төв банк мөнгөний бодлогоо үр өгөөжтэй хэрэгжүүлэх боломжгүй нь дэлхийн олон орны туршлагаас харагдаж байна. Энэхүү итгэл нь Монголбанкны бие даасан, ил тод, нээлттэй байдалтай шууд холбоотой. Мөнгөний бодлогын ил тод байдал, бодлогын хэрэгслүүдийн хараат бус байдал нь инфляцийн хүлээлтийг, улмаар эдийн засаг дахь хүүний түвшинг бууруулахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх болно. Мөнгөний бодлогын уламжлалт арга хэрэгслүүдийн үр ашиг тодорхойгүй байгаа өнөө үед Төв банкнаас санхүүгийн захууд

болон олон нийттэй харилцах нь хэзээ хэзээнээс илүү чухал болж байна. Монголбанк олон нийттэй харилцахдаа ОУВС-гаас дэлхийн тэргүүлэх Төв банкуудын туршлагад үндэслэн боловсруулсан “Ил тод байдлын зарчмууд”-ыг иш үндэс болгон ажиллаж байна.

Монголбанкны нэр хүндийг өсгөн, бодлогын үр өгөөжийг нэмэгдүүлэн, олон нийтийн дунд түгээмэл байгаа буруу ташаа ойлголтыг засч залруулахад Монголбанкнаас онцгой анхааран ажиллах болно. Олон нийт болон хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, Засгийн газар, УИХ, санхүүгийн захын үндсэн оролцогчид, Төв банкны үйл ажиллагааг ажиглагчдад зориулан Монголбанкнаас нам тогтвортой инфляци, төгрөгийн тогтвортой байдлын ач холбогдол, мөнгөний бодлогыг тойрсон санал шүүмжлэл, түүнд хийх дүгнэлт, саналын талаар ил тодоор өргөн цар хүрээтэй тайлбарлан таниулах шаардлагатай болж байна. Мөнгөний бодлого хэрэгжих орчин өдөр хоногоор хурдацтай өөрчлөгдөж буй өнөө үед Монголбанк авсан арга хэмжээ болгоныхоо эерэг, сөрөг талыг олон нийтэд мэдээлэх зарчмыг тууштай баримтлан ажиллана.

Монгол Улсын төлбөр тооцооны систем, цахим шилжүүлэг, цахим төлбөрийн хэрэгсэл, цахим мөнгөний тухай хуулийн төслийг Монголбанкнаас боловсруулж, холбогдох газруудаас санал авахаар бэлтгэж байна. Ингэснээр төлбөрийн системийн оператор, оролцогч, цахим төлбөрийн хэрэгсэл гаргагчдын эрх, үүрэг, тэдгээрт тавигдах шаардлага тодорхой болно. Хууль батлагдсанаар Монголбанкнаас төлбөрийн системийн оператор, цахим төлбөрийн хэрэгсэл гаргагчдад зөвшөөрөл олгох, тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг хуульчлагдаж, улмаар Монгол Улсад гар утас, карт зэрэг мэдээллийн технологид сууриссан төлбөр тооцооны системд хувийн секторыг оролцуулах эрх зүйн орчин бүрдэх болно.

Монголбанк төлбөр тооцооны системийн хууль эрх зүйн орчин, дэд бүтэц, системийн оролцогчид (банкууд, банк бус санхүүгийн байгууллагууд, төлбөр тооцооны төвүүд), төлбөр гүйцэтгэх хэлбэрүүд, төлбөрийн хэрэгслүүдийн талаарх цогц мэдээллийг агуулсан “Улаан ном” төслийг боловсруулаад байгаа бөгөөд түүнийг англи хэлнээ хөрвүүлж, Олон улсын төлбөр тооцооны банктай хамтран гаргахаар төлөвлөж байна.

Монголбанк нь төлбөрийн картын нэгдсэн сүлжээ, үр дүнгийн тооцооны зохицуулалтыг бий болгох үүднээс 2009 оны 8 дугаар сарын 6-ны өдөр “Төлбөрийн картын журам”-ыг баталсан ба тус журмын дагуу Хаан, Хадгаламж, Худалдаа хөгжлийн банкууд картын төлбөр тооцоог Монголбанкны Төлбөр тооцооны төвөөр дамжуулах туршилтыг хийж эхлээд байна. Картын клирингийн үйлчилгээ нэвтэрснээр картын гүйлгээ 24 цагийн турш тасралтгүй хийгдэж, карт ашиглагчид нэг картаар аль ч ПОС, ПОБ, ATM-аар үйлчлүүлэх боломжтой болох бөгөөд цаашид бусад банкуудыг мөн уг системд нэгтгэх зорилт тавин ажиллаж байна.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай Монгол Улсын хуулийн дагуу банкууд болон бусад 7 төрлийн санхүүгийн байгууллага 20 сая төгрөг, түүнээс дээш дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээ болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлсэн байж болзошгүй гэж сэжиглэсэн гүйлгээний талаарх мэдээллийг Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албандаа мэдээлэх үүрэг одоогоор зөвхөн банкуудын хүрээнд хэрэгжиж байгааг өргөтгөх ажлыг Санхүүгийн зохицуулах хороотой хамтран хэрэгжүүлнэ.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн талаар мэдээлэл солилцох, түүнийг илрүүлэх, таслан зогсоох, шийтгэх, хууль бусаар олсон орлогыг битүүмжлэх, хураах гэх мэт энэ төрлийн гэмт хэрэгтэй оновчтой тэмцэхэд шүүх, цагдаа, прокурор, авилгал, татварын байгууллагын оролцоо чухал юм. Иймд, энэ төрлийн гэмт хэргээр дагнаж ажиллах чиг үүрэг бүхий алба нэгжийг дээрх байгууллагуудад байгуулах, тэдгээрийн хоорондын мэдээлэл солилцох үйл ажиллагаа болон хамтын ажиллагааг эрх зүйн хүрээнд дэмжих, сайжруулах, боловсон хүчнийг сургах, бэлтгэх шаардлагатай байна.

**Хүснэгт 1.1 Мөнгөний үзүүлэлтүүдийн таамаглал: 2009 оны 3 дугаар улирлаас 2012 оны
4 дүгээр улирал**

(өөрөөр заагаагүй бол тэрбум төгрөгөөр)

Мөнгөний тойм	2008-4	2009-1	2009-2	2009-3	2009-4	2010-4	2011-4	2012-4
	Гүйц	Гүйц	Гүйц	Төл	Төл	Төл	Төл	Төл
М2 мөнгө	2319	2413	2425	2572	2550	3163	3852	4630
Банкнаас гадуурх мөнгө	329	273	284	372	378	438	481	578
Харилцах, хадгаламж	1990	2141	2141	2200	2172	2725	3371	4052
Гадаад цэвэр актив	677	689	944	986	1012	1468	1707	1994
Гадаад цэвэр нөөц	747	780	1026	1069	1096	1434	1673	1960
Төв банкны	808	768	930	986	1076	1419	1548	1765
Арилжааны банкны	-60	12	96	83	20	15	125	195
Бусад цэвэр зүйл	-70	-91	-82	-83	-84	34	34	34
Дотоод цэвэр актив	1642	1724	1480	1586	1538	1694	2144	2636
Дотоодын цэвэр зээл	2113	2234	1940	2014	2148	2383	2755	3174
ЗГ-ын цэвэр зээл	-522	-437	-619	-584	-330	-412	-435	-100
ББ-аас авах авлага	2636	2672	2559	2598	2478	2795	3191	3274
Бусад цэвэр зүйл	-471	-510	-459	-428	-610	-689	-611	-538

Төв банк

Нөөц мөнгө	633	591	769	680	730	840	966	1140
Гадаад цэвэр актив	805	782	1011	982	1073	1419	1548	1765
Дотоод цэвэр актив	-172	-191	-243	-302	-343	-579	-582	-626
ЗГ-ын цэвэр зээл	-211	-106	-68	-22	64	-276	-276	-276
Банкинд олгосон зээл	243	235	154	145	20	20	18	16
Хасах нь: ТБҮЦ	120	154	144	240	225	130	127	173
Бусад цэвэр зүйл	-84	-166	-185	-185	-202	-193	-197	-193

Меморандум үзүүлэлтүүд:

М2 мөнгөний жилийн өөрчлөлт (%)	-3.4	-1.7	-5.5	1.9	10.0	24.0	21.8	20.2
Нөөц мөнгөний жилийн өөрчлөлт (%)	18.4	32.1	52.2	32.7	15.3	15.1	15.0	18.0
Зээлийн жилийн өөрчлөлт (%)	28.2	14.4	0.0	-4.4	-6.0	12.8	14.1	17.1
М2 мөнгөний үржүүлэгч (нэгжээр)	3.7	4.1	3.2	3.8	3.5	3.8	4.0	4.1
Мөнгөний хурдны өөрчлөлт (нэгжээр)	0.82				-0.14	-0.24	-0.04	0.00
Бодит ДНБ-ий жилийн өсөлт (%)	8.9	5.4	2.9	1.9	1.5	7.4	8.4	10.3
Гадаад цэвэр албан нөөц /сая ам.доллар/	637.2	503.9	651	632	690	1001	1092	1245
Жилийн инфляци (%)	23.3	17.3	4.7	-0.8	3.4	8.0	6.3	6.0

*Монгол Улсын Их Хурлын 2008 оны 31 дүгээр
тогтоолын хавсралтаас*

II. ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2009 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ /2009 оны эхний 8 сарын байдлаар/

1. МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

1.1. Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдэх инфляцийн түвшинг нэг оронтой тоонд барьж, эдийн засгийн бодит өсөлтийг дэмжих мөнгөний бодлогыг хэрэгжүүлнэ.

Монголбанкнаас төгрөгийн өгөөжийг өсгөн, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг тогтвортжуулах, санхүүгийн зах зээл, макро эдийн засгийн тогтвортгүй байдлаас урьдчилан сэргийлэх, 2009 онд инфляцийг төлөвлөсөн хэмжээнд барих, дунд болон урт хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийн үндсийг бий болгох зорилгоор цогц арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлж байна. Үүнд төв банкны хүүний бүтцийг шинэчилж, бодлогын шийдвэрийн нөлөөлөх чадварыг нэгэн чигт цэгтэй болгосон, бодлогын хүүг гадаад валютын дотоодын захын байдалтай уялдуулан 14 хувь хүртэл өсгөөд зах зээлийн байдал тогтвортжсоны дараа 1.25 хувиар 2 удаа 11.5 хувьд хүргэн бууруулсан. Төв банкны санхүүжилтийн хэрэгслүүдийн хүү бодлогын хүүний өсөлт, бууралтыг даган өөрчлөгдсөн бөгөөд 2009 оны 8 дугаар сарын 31-ний байдлаар репо санхүүжилтийн хүү 17.5 хувь, барьцаат зээлийн хүү 21.5 хувь, овернайт зээлийн хүү 20.5 хувь болж буураад байна. Мөн үүний зэрэгцээ Монголбанкнаас банкны өөрийн хөрөнгийн зохистой харьцааг өсгөсөн, зээлийн эрсдлийн сангийн хувийг бууруулсан, гадаад валютын арилжааг дуудлага худалдааны зарчмаар явуулсан, ил тод байдлыг сайжруулсан зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэв. Түүнчлэн ОУВС-ийн “Стэнд-бай” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд мөнгөний бодлогын хэлбэр, үйл ажиллагааны зорилт өөрчлөгдөх шаардлагатай болсон тул бодлогын хэрэгслүүдэд зохих өөрчлөлтийг оруулав.

Хүснэгт 2.1. Мөнгөний нийлүүлэлтийн үндсэн үзүүлэлтүүд

(хугацааны эцэст, өөрөөр заагаагүй бол тэрбум төгрөгөөр)

Үзүүлэлт	VIII.2008	XII.2008	VIII.2009	VIII.2009 VIII.2008	VIII.2009 XII.2008
Инфляци					
УБ хотын (12 сарын өөрчлөлт, %)	33,7	23,2	-0,9	99,1	103,9
Улсын (12 сарын өөрчлөлт, %)	34,2	22,1	0,6	100,6	102,2
Зээлийн дундаж хүү (%)					
Төгрөгийн зээлийн дундаж хүү	21,8	20,4	23,7	108,7	116,2
Валютын зээлийн дундаж хүү	15,2	16,8	15,9	104,6	94,6
Мөнгөний нийлүүлэлт	2576,8	2270,0	2564,0	99,5	113,0
Бага мөнгө	642,2	647,3	597,1	93,0	92,2
Бараг мөнгө	1934,6	1622,7	1966,9	101,7	121,2
Нөөц мөнгө	529,0	633,7	695,0	131,4	109,7

Үндэсний статистикийн хорооноос гаргасан статистик мэдээллээр улсын хэмжээнд тооцсон Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) 2009 оны 8 дугаар сард өмнөх сараас 0.6%-аар буурч, оны эхнээс 2.2%-аар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.6%-аар тус тус өсөв. Харин Улаанбаатар хотын хэмжээнд ХҮИ 2009 оны 8 дугаар сард өмнөх сараас 0.6%-аар буурч, оны эхнээс 3.9%-аар өсч, харин сүүлийн 12 сард 0.9%-аар буурсан дүн гарав.

Санхүүгийн салбарын нийт хөрөнгийн 95 орчим хувийг эзэлдэг банкны салбарын актив хөрөнгө өмнөх оны эцэстэй харьцуулахад 2009 оны 8 дугаар сарын 31-ний байдлаар 10.8 хувиар буюу 361.0 тэрбум төгрөгөөр өссөн нь өмнөх оны сүүлийн хагас жилд буураад байсан иргэд, байгууллагын банкинд итгэх итгэл сэргэж, нийт харилцах, хадгаламжийн хэмжээ 2009 оны 8 дугаар сарын 31-ний байдлаар 322.3 тэрбум төгрөгөөр өссөнтэй холбоотой. 2008 оны эцэст банкны систем мөнгөн хөрөнгийн дутагдалд орж, банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар ихээхэн доройтож байсан. Харин Засгийн газар болон Монголбанкны зүгээс 2009 оны эхний хагас жилд үүссэн эмзэг орчинд банкны хямралаас сэргийлэхийн тулд шат дараатай арга хэмжээ авсан нь банкны системийн тогтворталтыг нөхөн сэргээхэд чухал ач холбогдол үзүүлсэн:

- ◆ Монголбанк 2009 оны эхний улиралд нийт 91.6 тэрбум төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг банкуудад олгож, системийн хэвийн ажиллагааг хангаж ажилласан нь 2009 оны 1 дүгээр улирлын эцэст -42.0 тэрбум төгрөг байсан банкны системийн цэвэр бэлэн нөөц⁴ мөн оны 8 дугаар сард 150.9 тэрбум төгрөг болж өсөхөд нөлөөлсөн.

⁴ Банкны системийн илүүдэл нөөц болон ТБҮЦ-ны нийлбэрээс Төв банкны санхүүжилтийг хасч тооцов.

- ◆ Засгийн газраас банкуудад нийт 66.3 сая ам.долларын алтны зээл олгож үйлдвэрлэлийг дэмжив.
- ◆ 2009 оны эхний улиралд үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн сулралт, урсгал тэнцлийн алдагдал, мөнгөн хөрөнгийн гадагшлах урсгал зэрэгтэй холбоотойгоор гадаад валютын цэвэр албан нөөц буурч, төгрөгт итгэх итгэл суларсан нөхцөл байдалтай тэмцэх үүднээс Монголбанк 2009 оны 3 дугаар сард гадаад валютын дуудлага худалдааг нэвтрүүлж, банкуудад төв банктай гадаад валютын арилжаа хийх боломжийг бүрдүүлснээр төгрөгийн ам.доллартай харьцах ханш тогтвортаж, санхүүгийн салбарт учраад байсан “үндэсний мөнгөн тэмдэгт-урсгал тэнцэл-банкны салбар”-ын хосолсон хямралын эрсдлийг бууруулаа. Санхүүгийн салбарт учирсан хүндрэл саармагжиж, банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хүндрэл арилсан ч эдийн засгийн зээлжих боломж нөхөн сэргээгүй, зээлийн эрсдэл өндөр хэвээр байгаа нь бодит эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байна.

1.2. Мөнгөний бодлогын үр ашгийг нэмэгдүүлж, нээлттэй байдлыг хангаж ажиллахын зэрэгцээ мөнгө, сангийн бодлогын харилцаан уялдааг инфляцийг бууруулах, иргэдийн амьжиргааны түвшинг хамгаалах, эдийн засгийн бодит өсөлтийг дэмжихэд чиглүүлнэ.

Мөнгөний бодлогын үр ашгийг нэмэгдүүлж, бодлогын арга хэмжээг олон нийтэд нээлттэй хэрэгжүүлдэг олон улсын шилдэг туршлага нь инфляцийг онилох мөнгөний бодлогын арга хэлбэр юм. Мөнгөний бодлогын энэ дэвшилтэт арга хэлбэрийг хэвшүүлэхэд шаардагдах үндсэн нөхцлүүдийн нэг нь таамаглаж болохуйц санхүүгийн харилцаа билээ. Сүүлийн 3 жилийн туршид дэлхийн зах зээл дээр зарим гол нэрийн барааны үнэ урьд байгаагүй огцом өөрчлөгдөв: 2007 оноос хүнсний бүтээгдэхүүний үнэ өссөн, 2007, 2008 онуудад нефтийн бүтээгдэхүүний үнэ огцом өсч эргээд огцом буурсан, 2008 онд зэсийн үнэ маш богино хугацаанд их хэмжээгээр огцом буурсан зэрэг нь Монгол Улсын эдийн засагт хүчтэй нөлөөлж, макро эдийн засгийн өрөнхий үзүүлэлтүүд, ялангуяа санхүүгийн үзүүлэлтийн харилцаан хамаарлыг өөрчлөөд байна. Үүний нөлөөгөөр макро үзүүлэлтүүдийг таамаглах боломж ихээхэн суларч байна. Энд болон доор тайлбарлаж буй бусад өөрчлөлтүүд нь инфляцийг онилох мөнгөний бодлогыг хэрэгжүүлж эхлэх хугацааг хойшлуулж байна.

Нөгөөтэйгүүр, мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг боловсруулах үеийн төсөөлөл, дэлхийн эдийн засгийн өөрчлөлтийн байдал, манай эдийн засагт үзүүлэх нөлөөлөл нь бодит байдлаас ихээхэн ялгаатай байв. Ялангуяа дотоодын мөнгөний захын тогтвортгүй байдал, банкуудын алдагдал нэмэгдэж байгаа болон төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн өөрчлөлтийг таамаглахад хэцүү байв.

2009 онд Мөнгөний бодлогыг дараах шалтгааны улмаас өөрчлөх болсон. Үүнд:

- ◆ Дэлхийн эдийн засгийн хямрал гүнзгийрснээр Монгол Улсын төсөв, мөнгөний бодлогод ихээхэн өөрчлөлт орох зайлшгүй шаардлага тулгарсан. Өмнөх жилүүдийн эдийн засгийн хурдацтай өсөлтийг хангах боломж үлэмж хязгаарлагдлаа. Монгол Улсын гадаад худалдааны гол түнш болох БНХАУ-ын эрэлт буурсан нь экспортын орлогыг хумив. Олон улсын санхүүгийн зах зээлийн эх үүсвэрийн хомсдол, дэлхийн эдийн засгийн хямралт байдал үргэлжлэх магадлал өндөр байгаа тул эдийн засгийн өсөлтийн хүлээгдэж буй гүйцэтгэл 2009 онд 1-2 хувь, 2010 онд 4-6 хувьтай байхаар байна.
- ◆ Төлбөрийн урсгал тэнцлийн алдагдал 2008 оны эцэст түүхэндээ хамгийн өндөр түвшинд буюу 1 тэрбум ам.долларт хүрэв. Урсгал тэнцлийн өндөр хэмжээний энэхүү алдагдлын санхүүжилт Монгол Улсын гадаад валютын цэвэр албан нөөцийг 2008 оны 6 дугаар сараас 2008 оны 12 дугаар сарын хооронд 315.7 сая ам.доллараар, банкны системийн гадаад цэвэр активыг 522.1 сая ам.доллараар буурахад хүргэсэн.
- ◆ Банкны системд орох гадаад валютын урсгал татарч, гарах урсгал давамгайлснаар гадаад цэвэр актив буурсан нь банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварт сөргөөр нөлөөлж, зээлийн эх үүсвэрийн хомсдолд оруулсан. Банк хоорондын зах дээрх төгрөгийн цэвэр нөөцийн хэмжээг банкуудын илүүдэл нөөц болон ТБҮЦ-ны нийлбэрээс Төв банкнаас авсан санхүүжилтийг хасч тооцсон үзүүлэлт 2008 оны сүүлийн хагас жилд 147.5 тэрбум төгрөгөөр буурсан. Иймд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хүндрэлийг арилгах зорилгоор 2009 оны 8 дугаар сарын 31-ний байдлаар Монголбанкнаас 129.3 тэрбум төгрөгийн барьцаат зээлийг банкуудад олгосон. Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү 11,2 хувьд хүрээд байна.
- ◆ Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал төсөөлж байснаас өөр болсон тул 2009 оны 4 дүгээр сарын 1-нд Монгол Улсын Засгийн газар ОУВС-д хандан “Стэнд бай” хөтөлбөрийг хэлэлцэн тохирч, батлуулсан билээ. Тус хөтөлбөр нь төлбөрийн тэнцлийн болон төсвийн алдагдлыг нөхөх, макро эдийн засгийн тогтвортой байдлыг сэргээхэд чиглэгдэж байна. Хөтөлбөртэй холбогдуулан Монголбанкнаас баримтлах мөнгөний бодлогод ч томоохон тохиргоо хийгдэх шаардлага тулгарсан.


Тиймээс Монголбанкнаас төгрөгийн өгөөжийг өсгөн төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг тогтвожуулах, санхүүгийн зах зээл, макро эдийн засгийн тогтвортой байдлаас урьдчилан сэргийлэх, инфляцийг шат дараатай бууруулах, улмаар мөнгөний бодлогыг зөөлрүүлэх зорилгоор 2009 оны эхний 8 сард мөнгөний бодлогын шат дараалсан арга хэмжээ авсан. Үүнд:

1. 2009 оны эхэнд валютын хямрал үүсч болзошгүй нөхцөл байдал үүссэн тул Монголбанк мөнгөний бодлогын хүү буюу 7 хоногтой ТБҮЦ-ны хүүгээ 4.25 нэгж хувиар нэмэгдүүлсэн төдийгүй валютын дуудлага худалдааг 7 хоногт 2 удаа тогтмол зохион байгуулснаар валютын ханшийн хэт хөөрөгдлөөс зайлсхийх боломжийг бүрдүүлж, валютын захын тогтвортой байдлыг ханган ажиллав. Үүний зэрэгцээ банкуудын активын өгөөжийг нэмэгдүүлэх, мөнгөний зах дээрх төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор харьцангуй урт буюу 12 долоо хоногтой ТБҮЦ-ны хамгийн өндөр хүүг 20 хувь болгож нэмэгдүүлсэн. Инфляци тогтвортой бага түвшинд байгаа тул эдийн засгийн бодит секторын сүүлийн үеийн уналт, зээлийн эрэлт, мөнгөний нийлүүлэлтийн бууралт зэргээс шалтгаалан зээл олголтыг нэмэгдүүлэх зорилгоор бодлогын хүүг 5, 6 дугаар саруудад 1.25 нэгж хувиар тус тус бууруулсан.
2. Банкны системийн төлбөр тооцоо түргэн гүйцэтгэх чадварт үүссэн хүндрэлийг арилгах үүднээс Монголбанк 2008 оны 10 дугаар сараас эхлэн банкуудад барьцаат зээл болон барилгын салбарт дахин санхүүжилтийн зээл олгосон. 2008 оны 10 дугаар сараас хойш Монголбанкаас нийт 265 тэрбум төгрөгийн зээл олгосон бөгөөд зээлийн өрийн үлдэгдэл 129.3 тэрбум төгрөг байна.
3. Мөнгөний бодлогын хүүний бүтцийг 2009 оны 3 дугаар сард шинэчлэн боловсруулж хэрэгжүүлснээр Төв банкны мөнгөний бодлогын хүүний нөлөөлөх чадварыг дээшлүүлэв. Ингэснээр бодлогын хүүнээс репо санхүүжилтийн хүү болон ТБҮЦ-ны хамгийн өндөр хүүг 6 нэгж хувиар, байнгын бус санхүүжилтийн хүүг 9 нэгж хувиар, овернайт зээлийн хүүг 10 нэгж хувиар тус тус их байхаар тогтоов. Мөнгөний бодлогын хүүний шинэ бүтэц нь банк хоорондын захын хүүний хэлбэлзэх заагийг бий болгох бөгөөд банкуудын хувьд банк хоорондын зах дээрх хүүний тодорхой бус байдлыг бууруулж байна.
4. “Заавал байлгах нөөц тооцож, хяналт тавих журам”-д өөрчлөлт оруулан 2009 оны 3 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлснээр зээл, хадгаламжийн хүүний зөрүүг багасган, активын өгөөжийг нэмэгдүүлж, банк хоорондын захын нөөцийн хэлбэлзлийг бууруулан үйл ажиллагааг нь идэвхижүүлэв. Үүнд:
 - ◆ Монголбанкаас тогтоосон төгрөгийн ЗБН-ийн хэмжээнд бодлогын хүүний 1/4-тэй тэнцүү хэмжээгээр урамшуулалт олгов.
 - ◆ Төгрөг болон гадаад валютын ЗБН-ийн 50-иас доошгүй хувийг өдрөөр хангуулав.
 - ◆ ЗБН тооцох татан төвлөрүүлсэн хөрөнгийн жагсаалтаас дотоодын банк, санхүүгийн байгууллагаас татсан харилцах, хадгаламжийн дансдыг хасч тооцов.
5. Төв банкны урт хугацаатай үнэт цаасыг 2009 оны 6 дугаар сарын эцэст 3 сарын хугацаатай ТБҮЦ-нд төвлөрүүлөх зорилгоор 2009 оны 3 дугаар сараас 28 долоо

хоногтой ТБҮЦ-ны арилжааг зогсоож, 12 долоо хоног /ойролцоогоор 3 сар/-той үнэт цаасыг банкуудад арилжаалж байна. 2009 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 28 долоо хоногтой ТБҮЦ-ны үлдэгдэл 0.5 тэрбум төгрөг байгаа бол 12 долоо хоногт төлөгдөх ТБҮЦ 136.0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Ингэж төвлөрүүлснээр ТБҮЦ-ны хугацаа богиноч бандуудын эх үүсвэрийн дундаж хугацаатай ойртож, банкуудын хувьд актив, пассивын хугацааны зөрүүнээс үүсэх эрсдлийг бууруулах юм. 12 долоо хоногт төлөгдөх ТБҮЦ-ны арилжааг 14 хоног тутамд зохион байгуулах болсон нь өмнөх давтамжаас 2 дахин ихэссэн. Ингэснээр санхүүгийн зах зээл хэтэрхий хурдан өөрчлөгдөж байгаа үед банкуудад эх үүсвэрээ илүү уян хатан удирдах боломжийг олгож байна.

6. Үндэсний валютын ханшийн огцом судралт зогсож, валютын зах эмзэг боловч харьцангуй тогтвортожиж, банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар сайжирч, бодлогын хэрэгслүүдэд зохих өөрчлөлтүүд оруулснаар Монголбанк 2 дугаар улирлаас эхлэн **мөнгөний хатуу бодлогоо аажмаар зөөлрүүлж**, зээл олголтыг нэмэгдүүлэх зорилготой алхмуудыг хэрэгжүүлэв. Тухайлбал,
 - ◆ Бодлогын хүүг 2009 оны 5 дугаар сард 1.25 нэгж хувиар бууруулж 12.75 хувь, 6 дугаар сард дахин 1.25 нэгж хувиар бууруулж 11.5 хувьд хүргэнээр ТБҮЦ-ны хамгийн өндөр хүү болон репо санхүүжилтийн хүү 2.5 нэгжээр, барьцаат зээл болон овернайт зээлийн хүү тус тус 2.5 нэгжээр буурсан,
 - ◆ ТБҮЦ-ны хэмжээг хязгаарлан банк хоорондын зах дээрх илүүдэл нөөцийн хэмжээг нэмэгдүүлсэн,
 - ◆ Дээрх арга хэмжээний үр дүнд банк хоорондын захын хүүг бууруулсан,

Зураг 2.1. Банк хоорондын захын илүүдэл нөөц ба ам.долларын ханшийн өөрчлөлт



7. Монголбанк барилгын салбарт зээл олгосон арилжааны банкуудын үйл ажиллагааг эрсдэлд оруулахгүй байх, эдийн засгийн бодит салбарыг дэмжих үүднээс 2 банкинд нийт 55.7 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилт хийсэн. Гэвч барилгын зээлийн банкин дээр болон газар дээрх шалгалтаас харахад банкууд тухайн зээлийг зориулалтаар нь ашиглаагүй, зээл олгоод даруй 4 сар өнгөрсөн ч зээлийн 1/3 хувь нь л зээлдэгчдэд хүрсэн байв. Мөн тус санхүүжилтийг авсан цөөн хэдэн компани нь зээлээр барьж буй барилгаа дуусгахад бус харин өмнө авсан банкны зээлийн өрийг төлөх, бусдаас авсан барилгын материалын төлбөрийг барагдуулах зэрэгт ашигласан байна. Ийм учраас уг зээлийг эргүүлэн төлүүлээд байна. Банкуудаас барилгын зориулалтаар Монголбанкнаас зээл авах хүсэлт одоогоор ирээгүй байна.
8. Алт олборлох үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Сангийн яам бонд гаргаж 89.5 сая ам.долларын эх үүсвэр татаж арилжааны банкуудад дамжуулан олгохоор шийдвэрлэсэн. Дээрх зээлийн ашиглалтын талаар Сангийн яам, Монголбанк, арилжааны банкууд гурвалсан гэрээ байгуулж, 2009 оны 5, 6 дугаар сард эхний ээлжийн 66.25 сая ам.долларыг арилжааны банкуудад зээлдүүлсэн. 2009 оны 8 дугаар сарын 31-ний байдлаар банкууд уг эх үүсвэрийн 66.28 хувийг аж ахуйн нэгжид олгосон байна.

Монголбанкнаас эдгээр арга хэмжээг хэрэгжүүлснээр зарим зэрэг үр дүн ажиглагдаад байна. Үүнд: инфляцийн түвшин 2009 оны 8 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 0.6%, оны эхнээс 2.2% байгаа бөгөөд “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2009 онд баримтлах үндсэн чиглэл”-д заасан инфляцийн зорилтот түвшинг ханган ажиллаж байна.

Төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлж, төгрөгийн ханшийг тогтвортжуулснаар төгрөгт итгэх итгэлийг сэргээж, улмаар банкны системийн нийт төгрөгийн харилцах, хадгаламжийн үлдэгдэл оны эхнээс 8.8 хувиар нэмэгдэв.

- ◆ Шинээр олгосон зээлийн хэмжээ 1 дүгээр улиралд 451.6 тэрбум төгрөг, 2 дугаар улиралд 593.3 тэрбум төгрөг болон өссөн ч зээлийн эргэн төлөлттэй холбоотойгоор зээлийн өрийн үлдэгдэл өмнөх улирлаас 113.2 тэрбум төгрөгөөр буурсан байна.
- ◆ Монголбанк мөнгөний бодлогыг зөвлүүлснээр банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү 1 дүгээр улирлын эцэст 17.86 хувь байсан бол 2 дугаар улирлын эцэст 15.05 хувь, 8 дугаар сард 11.2 хувь болон тус тус буурав. Банкны системийн цэвэр бэлэн нөөц 1 дүгээр улирлын эцэст -42.0 тэрбум төгрөг байсан бол 2 дугаар улирлын эцэст +105.6 тэрбум төгрөг, 2009 оны 8 дугаар сарын 31-ний байдлаар +150.9 тэрбум төгрөг болж тус тус нэмэгдэв.

Эдийн засгийн өсөлт саарснаар санхүүгийн секторт хүндрэл учирч байна. Орлого буурахын хэрээр нэг талаас бизнесийн зээлийн эргэн төлөлт, зээлийн эрэлт муудаж

байгаа бол нөгөө талаас банкуудын зээл олгох сонирхол эрс багасч, зээлдэгчийн зээл авах идэвх сэргэхгүй байгаа нь зээлийн тасалдлыг үүсгэж, зээлийн эрсдлийг нэмэгдүүлэн, чанаргүй зээлийн хувь хэмжээг өсгөж байна. Банкны салбарын хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ 2009 оны 8 дугаар сарын байдлаар 6.7 хувь, үүнээс чанаргүй зээлийн хэмжээ 13.7 хувьд хүрснээр банкны салбарт өндөр эрсдэл нүүрлээд байна.

Эдийн засаг мөчлөгийн уналтанд байгаа үед Төв банк хүүг бууруулж, мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэн мөнгөний бодлогыг зөөлрүүлэх арга хэмжээ авдаг. Гэвч Монголбанк цаашид мөнгөний бодлогыг зөөлрүүлэх нь эдийн засгийн өсөлтийг дэмжих биш, харин ч валютын захын тогтвортгүй байдлыг дагуулах сөрөг үр дагаврыг авчрах нөхцөл байдал эдийн засагт бүрдчихээд байна. Тухайлбал, хүүг бууруулснаар төгрөгийн өгөөж үлэмж муудаж, төгрөгийн ханш эрс суларч болзошгүй. Улмаар инфляцийг хөөрөгдөх, банкны салбарын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөхөөр байна.

Бий болсон нөхцөл байдалд Монголбанк дангаар мөнгөний бодлогыг зөөлрүүлэх замаар цаашид эдийн засгийн өсөлтийг хангах боломжгүй байна. Банкуудад зээл олгох боломжийг бүрдүүлэхийн тулд юуны өмнө энэ салбарыг хүндрэл бэрхшээлээс гаргах нь чухал юм. Нэгэнт мөнгөний бодлогын боломж хязгаарлагдмал байгаа өнөөдрийн нөхцөлд төсвийн зарлагыг нэмэгдүүлж эдийн засгийн бодит секторыг дэмжих ганц сонголт үлдсэн байна.

1.3. Төгрөгийн ханш нь валютын захын эрэлт, нийлүүлэлтийн үндсэн дээр бодитой, чөлөөтэй тогтох зарчмыг баримтална.

Гадаад эдийн засаг, зах зээлийн хямрал 2008 оны сүүлийн хагасаас эхлэн Монгол Улсын эдийн засаг, бизнесийн орчинд хүчтэй нөлөөлөн, гадаад төлбөрийн тэнцэл, улсын төсөв аль аль нь алдагдалтай болж, банкны салбараас мөнгөн хөрөнгө, хадгаламж их хэмжээгээр гадагшлан, гадаад валютын орох урсгал үндсэндээ зогсонги байдалд орсон нь валютын захыг үлэмж хэмжээгээр тэнцвэргүй байдалд оруулсан. Иймд гадаад валютын улсын нөөцийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөх доод хэмжээнээс бууруулахгүй байх зарчмыг баримтлан, Төв банкнаас интервенц хийхдээ ханшийг тогтвортжуулах бодлогыг хэрэгжүүлэхийг зорьсон. Гэвч ОУВС, Засгийн газар хоорондын зээл, тусламжийн хэмжээ, хуваарь тодорхойгүй, гадаад валютын орох урсгалын улирлын онцлог, ханшийн талаарх олон нийтийн хүлээлтээс шалтгаалсан зохиомол хэт эрэлт бий болсон зэргээс төгрөгийг цаашид хамгаалах боломжгүй болж, улмаар ханшийн тохиргоог хийхээс өөр сонголтгүй болсон. Иймд гадаад валютын үлэмж хэмжээний хомсдолтой, банкны системийн зээлийн гуравны нэг нь гадаад валютаар олгогдсон үед төгрөгийн ханшийг хэт, огцом сулруулах нь чухал хэрэгцээт импортын бүтээгдэхүүний нийлүүлэлт тасалдаж, инфляцийг хөөрөгдөх, эдийн засаг

зогсонги байдалд орох, улмаар валютын хямрал, банкны системийн тогтвортгүй байдлыг ч өдөөж болзошгүй нөхцөл үүссэн байв.

Эдийн засагт олон жилийн турш байсан “зохиомол эрэлт”-ийн улмаас төгрөгийн ханш бодитой тогтоогдох боломжгүй нөхцөл байдал нэгэнт үүссэн үед зах зээл дэх богино хугацааны гажуудлыг хурдацтай арилгах, ОУВС-тай хөтөлбөр тохирох хүртэл хугацаанд банк хоорондын зах дээр үүссэн гадаад валютын хомсдлыг Монголбанкнаас тодорхой хэмжээгээр тэнцвэржүүлэх, ингэхдээ улсын хэмжээний ач холбогдол бүхий гадаад төлбөр тооцоог хугацаа хожимдуулахгүй хийх, стратегийн чухал барааны импортын тасалдлыг бий болгохгүй байх үүднээс Төвбанкны тухай хуульд заасан төгрөгийг тогтвортой байлгах, Валютын зохицуулалтын тухай хуульд заасан ханшийн хэлбэлзлийн хүрээнд валют арилжих ханшийг тогтоож, “валютын зохистой хуваарилалт”-ын зарчимд ОУВС-аас зохих зөвшөөрөл авсны үндсэн дээр шилжсэн (Ийм арга хэмжээг гадаад валютын хэт хомсдолд орсон Исланд, Украин зэрэг улс орнууд түр хугацааны арга хэмжээ болгон хэрэгжүүлсэн байна). Энэ бодлогын хүрээнд Монголбанкнаас арилжааны банкуудын захиалгыг үндэслэн, Монголбанкны арилжааны ханшийг таван төгрөгөөс илүү өсгөхгүй, зөвхөн зориулалтын дагуу ашиглах талаар хатуу гэрээ байгуулсны үндсэн дээр 2009 оны нэгдүгээр улиралд 107.1 сая ам.долларыг худалдсанаас 45.2 сая ам.доллар буюу 42.2 хувийг зөвхөн нефтийн бүтээгдэхүүний импортод зориулсан байна.

ОУВС-тай хөтөлбөр тохирон, хандивлагч улс орнуудаас өгөх зээл, тусламжийн хэмжээ, хуваарийг тодорхой болгож, мөнгөний бодлогыг хатууруулах замаар төгрөгийн илүүдэл эх үүсвэрийг буцаан татах, зохиомол эрэлтийг бууруулах арга хэмжээг Монголбанк үе шаттайгаар авч хэрэгжүүлсний зэрэгцээ Монголбанкны гадаад валютын арилжааг 3 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн зөвхөн дуудлага худалдаагаар хийхээр шийдвэрлэснээр төгрөгийн ханш чөлөөтэй тогтох байх зарчим үндсэндээ хангагдсан.

Анхны дуудлага худалдааг явуулснаас хойш 8 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд нийт 46 удаа дуудлага худалдаа зохион байгуулж, 107.1 сая ам.доллар худалдан авч, 49.2 сая ам.доллар худалдсан байна. Бодлогын энэхүү арга хэмжээ нь валютын захын тэнцвэрт байдлыг дэмжих замаар ханшийн хэт хэлбэлзлийг зөвлүүлэх зорилготой байв. Түүнчлэн төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкны албан ханш 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1429.05 төгрөг болсон нь 2009 оны хамгийн өндөр түвшингээс 10.2 хувиар буюу 161.65 төгрөгөөр, өмнөх улирлын эцсээс 0.45 хувиар буюу 6.44 төгрөгөөр тус тус чангартсан. Банк хоорондын зах дээр 1675, албан бус зах дээр 1740 хүрч суларч байсан ханш 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1422 орчимд тогтвортлоо.

Төгрөгийн ханш бодитой тогтох байх зарчмыг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байсан дараах хүчин зүйлсийн эсрэг Монголбанкнаас зохих арга хэмжээг хэрэгжүүлэн тодорхой үр дүнд хүрээд байна:

Гадаад валютын “Зохиомол эрэлт”- ийг бий болгосон хүчин зүйлс	Монголбанкнаас хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн
<p>Гаалийн ерөнхий газрын эмхэтгэдэг “Гадаад худалдааны тайлан” алдаатай гарсны улмаас 2008 оны эхний хагас жилийн гадаад худалдааны тэнцлийн алдагдал огцом өссөн мэтээр олон нийтэд мэдээлэгдсэн нь зах зээлийн хүлээлтийг өөрчилсөн.</p> <p>Аж ахуйн нэгж байгууллага, иргэд нь үнийн санал, тариф, зар сурталчилгааг гадаад валютаар илэрхийлж, төлбөр тооцоог гүйцэтгэж байна.</p> <p>Эрдэнэт зэрэг УҮГазрууд төсөвтэй хийх тооцоог ам.доллараар гүйцэтгэдэг.</p> <p>Татвар, гаалийн хураамж, шимтгэл ам.доллараар илэрхийлэгдэж төлөгддөг.</p> <p>Алтыг хууль бусаар хил дамнуулан худалдах, мөнгө угаах, богино хугацаанд ханшийн зөрүүнээс ашиголох үйл ажиллагаатай холбоотой их хэмжээний хөрөнгө албан бус зах дээр хяналтгүй, бүртгэлгүйгээр эргэлдэж байна.</p>	<p>ОУВС-гийн зөвлөхийг ажиллуулан бие даасан, мэргэжлийн дүгнэлт гаргуулж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Залруулга хийсэн төлбөрийн тэнцлийг цахим хуудсаар мэдээлсэн. Монголбанк, Сангийн яам, ГХЯам, YСХороо, ГЕГазрын төлөөлөлтэй ажлын хэсэг байгуулагдаж, аргачлалыг боловсруулж батлуулсан.</p> <p>Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”, “Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль”-ийн төслүүдийг боловсруулан УИХ-д хүргүүлсэн. УИХ-ын гишүүд уг хуулийн теслийг санаачилж, УИХ-аар хэлэлцүүлснээр 2009 оны 7 дугаар сарын 9-ний өдөр батлагдсан. Хуулийг хэрэгжүүлэх тусгай төлөвлөгөө гарган ажиллаж эхлээд байна.</p> <p>Хууль тогтоомжийг зөрчиж байгаа тухай олон нийтээс өгсөн мэдээллийн дагуу 170 аж ахуйн нэгж, байгууллагын (давхардсан тоогоор) нэр, хаягийг тодруулсны үндсэн дээр Монголбанк, Сангийн яам, МХГазар, НМХГазар, ТЕГазруудтай хамтран хууль тогтоомж зөрчсөн үйл ажиллагаанд газар дээрх шалгалтыг хоёр удаа зохион байгуулан, зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр ажилласан.</p> <p>Монголбанкны дуудлага худалдаа бүрийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлдэг болсон.</p> <p>Валютын ханшийн тухай олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Банкны сургалтын төвөөр дамжуулан сургалт хийсэн.</p> <p>Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр ажилладаг төрийн бусад байгууллагуудтай хамтын ажиллагаагаа сайжруулж байна.</p>	<p>Гадаад худалдааны статистикийн чанар, үнэн зөв байдлыг сайжруулах, төгрөгийн ханшийн талаарх захын оролцогчдын хүлээлтэд ээрэгээр нөлөөлж, төгрөгийн хадгаламжийг ам.долларт хөрвүүлэх явцыг сааруулахад чухал ач холбогдолтой болсон.</p> <p>Гадаад валютын зохиомол эрэлтийг хязгаарлах, Эрдэнэт зэрэг УҮГазрууд төсөвтэй хийх аливаа тооцоог зөвхөн төгрөгөөр гүйцэтгэх, татвар, гаалийн хураамж, шимтгэл зэргийг Монгол Улсын хуулинд зөвхөн төгрөгөөр илэрхийлж байх зэрэг эрх зүйн орчинг бүрдүүлэв. Мөн энэ талаарх хууль тогтоомжийг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагыг чангатгав. Ингэснээр гадаад валютын дотоодын зах дээрх эрэлт, нийлүүлэлт тэнцвэржих, төгрөгийн ханш нь Монгол Улсын эдийн засаг, гадаад худалдааны тэнцэлтэй уялдсан байдлаар бодитой тогтох боломжтой болсон.</p> <p>Шалгалтын үр дүнд 50 аж ахуйн нэгж, байгууллага бараа, үйлчилгээний үнэ, тарифыг төгрөгт шилжүүлсэн. Гаалийн татвар, хураамжийг ам.доллараар илэрхийлсэн байдаг бөгөөд түүнийг Монголбанкны албан ханшаар төгрөгт хөрвүүлэхдээ тухайн өдрийн албан ханшийг ашигладаггүй нь импортлогчдыг ихээхэн бухимдуулж байсныг тогтоож, энэ тухай Сангийн яам, ГЕГазар, ГХЯаманд албан бичиг хүргүүлсэн. Одоогоор ГЕГазар, Сангийн яам энэ талаар эсрэг байр суурьтай байгаагаа мэдэгдсэн.</p> <p>Гудамж, талбай, олон нийтийн хөдөлгөөн ихтэй газруудад байршуулсан зарлалын самбарт үнийн сурталчилгааг ам.доллараар илэрхийлсэн байгааг өөрчлөх, энэ тухай шаардлагыг хүлээж аваагүй байгууллагын сурталчилгааны самбарыг буулгах арга хэмжээг авахыг Хотын захиргаанд; Монгол улсад ажиллаж, амьдарч байгаа ажилтан, албан хаагч, ажилчдын цалинг төгрөгөөр тавьж олгож байгаа эсэхэд хяналт тавьж, хамтарч ажиллахыг НХХЯаманд; орон сууц, барилгын талбайн түрээсийн үнэ ам.доллараар илэрхийлэгдэж, төлбөрийг түүгээр гүйцэтгэхийг шаардаж байгааг таслан зогсоохыг ЗТБХЯаманд албан тоотоор шаардсан.</p> <p>Банк хоорондын гадаад валютын захын илүүдэл/дутагдал, Монголбанкны интервенцийн хэмжээ, дуудлага худалдааны хамгийн их, бага, хаалтын, дундаж ханш зэргийн талаарх мэдээллийг гадаад валютын заход аролцогч нар тухай бүр шуурхай авах боломжтой болсноор мэдээллийн тэгш бус байдаас хэт их ашиг олох үйл ажиллагааг бууруулж чадсан.</p>

Цашилбал, ханшийн бодлогын чиглэлээрх судалгааны ажлуудын цар хүрээг тэлж, гадаад худалдаа, төлбөрийн тэнцлийн улирлын төсөөллийг орчин үеийн аргачлалд үндэслэн гүйцэтгэж, импортын эрэлт, долларжилтын түвшинг эдийн засаг, статистикийн аргаар загварчилдаг болсноор ханшийн бодлогын оновчтой шийдвэр гаргалт, ханшийн тогтворжилтод чухал нөлөө үзүүлж байна.

1.4. Төлбөрийн тэнцэл гаргах, гадаад валютын урсгалын талаарх мэдээллийн хамрах хүрээ, хүртээмж, нээлттэй байдлыг сайжруулах, үр ашигтай ажиллах дэд бүтцийг бүрдүүлэх замаар валютын захын үр ашгийг нэмэгдүүлнэ.

Төлбөрийн тэнцлийг гаргах мэдээллийн хамрах хүрээ, хүртээмж, нээлттэй байдлыг сайжруулах чиглэлээр:

- ◆ Тайлант хугацаанд Мэдээлэл солилцох гэрээг 14 аж ахуйн нэгжтэй нэмж байгуулснаар төлбөрийн тэнцэлд мэдээлэл нь тусгагддаг аж ахуйн нэгжийн тоог 56 хувиар нэмэгдүүлсэн.
- ◆ Төлбөрийн тэнцлийн “Алдаа ба орхигдуулга” үзүүлэлт 2009 оны 2 дугаар улирлын хувьд 81.5 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 74.2 хувиар буурсан нь төлбөрийн тэнцлийн хамрах хүрээ сайжирсныг харуулж байна.
- ◆ Экспортлогч, импортлогчдын хоёрдугаар семинарыг “Гадаад зээл” онцлох сэдэвтэйгээр Сангийн яамтай хамтран энэ оны нэгдүгээр улиралд амжилттай зохион байгуулсны үр дүнд гадаад зээлийн мэдээллийн ач холбогдлын талаарх олон нийтийн ойлголт дээшилсэн нь хувийн хэвшлийн гадаад зээлийг бүртгэх, гадаад секторын статистикийг сайжруулах нөхцлийг бүрдүүлэв.
- ◆ Монголбанк, Сангийн яам, ГХЯам, YСХороо, ГЕГазрын төлөөлөлтэй ажлын хэсгийг Ерөнхий сайдын захирамжаар байгуулж, “Гадаад худалдааны барааны статистикийг тооцох аргачлал”-ыг боловсруулан батлуулсан нь төлбөрийн тэнцэл, гадаад худалдааны статистик мэдээллийн чанарыг сайжруулах аргачлал, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, гадаад худалдааны статистик мэдээлэлд гарсан зарим алдааг залруулахад чухал ач холбогдолтой боллоо. Гадаад худалдааны барааны статистик мэдээллийн 1995 оноос хойшхи динамикт залруулга хийснээр гадаад худалдааны тэнцлийн алдагдал 2007 оны хувьд 106.5 сая ам.доллараар буурч 114.4 сая ам.доллар, 2008 оны хувьд 306.9 сая ам.доллараар буурч 769.6 сая ам.доллар болов.
- ◆ Валютын зохицуулалтын тухай хуулийг шинэчлэн “Валютын тухай” Монгол Улсын хууль болгож өөрчлөн боловсруулж дуусгаад байна. Шинэ хуулийн төсөлд гадаад секторын статистикийн чанарыг сайжруулах, хамрах хүрээг тэлэх, чөлөөт бүсэд үйлчлэх валютын зохицуулалт, шаардлагатай мэдээлэл, тайланг авах эрх зүйн зохицуулалтыг бүрэн оруулсан.

- ♦ Монгол Улсын төлбөрийн тэнцлийг улирал, жилээр гарган Монголбанкны цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тогтмол мэдээлэхийн зэрэгцээ бодлогын шинжилгээ, судалгаанд ашиглагдах дэлгэрэнгүй мэдээллийг Сангийн яам, ҮХШХороо, ҮСХороо болон ОУВС, Дэлхийн банк, АХБанк зэрэг олон улсын санхүүгийн байгууллагуудад тогтмол хүргүүлж байна.

Гадаад валютын урсгалын талаарх мэдээллийг сайжруулах чиглэлээр:

- ♦ Банкуудын гадаад валютын урсгалын төсөөллийг сар тутам гаргуулан авч, төлбөрийн тэнцэл, гадаад валютын албан нөөцийн урсгалын төсөөллийг шинэчлэх, холбогдох бодлого боловсруулахад ашиглаж байна. Цаашид төсөөллийн үнэн зөв байдлыг сайжруулахын тулд банкуудын боловсон хүчний чадавхийг дээшлүүлэхээр ажиллаж байна.
- ♦ Банкуудаар дамжин хийгдсэн гадаад төлбөр тооцооны мэдээ, өндөр дүнтэй гүйлгээний дэлгэрэнгүй мэдээллийг өдөр тутам нэгтгэн, гадаад валютын урсгалын мэдээллийн санг баяжуулахын зэрэгцээ Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанд тухайн мэдээллийг хүргүүлснээр мөнгө угаалт, терроризмын санхүүжилтийн эсрэг хийгдэх хяналтын чанар, давтамжийг сайжруулах нөхцлийг бүрдүүлсэн.
- ♦ Монголбанк, ГЕГазрын хооронд 2008 онд байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу Монгол Улсын хилээр орж, гарч буй бэлэн валютын мэдээг 2009 оны 2 дугаар сараас авч эхэлсэн. Гэвч хилээр их хэмжээгээр нэвтэрч буй бэлэн мөнгийг шалгах, илрүүлэх техник, тоног төхөөрөмж гаалийн байгууллагад дутагдалтай, иргэд бэлэн валютаа мэдүүлж сураагүй зэргээс чанар, хамрах хүрээний хувьд учир дутагдалтай хэвээр байгааг Засгийн газрын энэ асуудлыг эрхэлсэн байгууллагууд анхаарч ажиллах талаар холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр бэлтгэж байна.

Гадаад валютын захын үр ашигтай ажиллах дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр:

- ♦ Блүүмбэрг (Bloomberg) компанийтай байгуулсан санамж бичгийн дагуу банк хоорондын валютын захын цахим хуудас (MGFX)-ыг 2009 оны 3 дугаар сараас туршиж эхэлсэн нь банк хоорондын захын мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдлыг сайжруулах, гадаад валютын арилжааны үр ашиг, давтамжийг нэмэгдүүлэх, төгрөгийн ханш бодитой, чөлөөтэй тогтоход чухал ач холбогдолтой. Банкуудтай мастер гэрээ байгуулж, гадаад валютын захад оролцогчдын ёс зүйн дүрмийг тодорхой болгосны үндсэн дээр уг цахим хуудсыг албан ёсоор нээх болно.
- ♦ “Валютын арилжааны мэргэжилтнүүдийн хоёрдугаар зөвлөгөөн”-ийг Монголын банкуудын холбоотой хамтран 2009 оны 2 дугаар сарын 23-ны өдөр амжилттай зохион байгуулсан. Үүний үр дүнд гадаад валютын захын үр ашигийг сайжруулах, төгрөгийн ханшийг тогтвортой байлгахад учирч буй хүндрэлүүдийг

шийдвэрлэх, валютын захын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, захын оролцогчдын ёс зүй, эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгон чангатгах, мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагааг үр өгөөжтэй болгох нөхцлийг бүрдүүлсэн. Энэхүү зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийг УИХ-ын ЭЗБХ, СЗХ, ЗГ, Сангийн яаманд хүргүүлсэн бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна.

1.5. Гадаад валютын улсын нөөцийг түүний найдвартай байдал, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангасны үндсэн дээр үр өгөөжийг нь нэмэгдүүлэх зарчмаар удирдаж, нөөцийг импортын 17.7-гоос доошгүй долоо хоногийн төлбөрийг гүйцэтгэх хэмжээнд байлгана.

Гадаад валютын улсын нөөцийг түүний найдвартай байдал, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангасны үндсэн дээр үр өгөөжийг нь нэмэгдүүлэх зарчмаар удирдах чиглэлээр:

Дэлхий нийтийг хамарсан эдийн засгийн уналт, санхүүгийн системийн тогтвортгүй байдал үргэлжилж байгаа өнөөгийн нөхцөлд Монголбанк нь гадаад валютын улсын нөөцийн удирдлагын хүрээнд 2009 онд баримтлах бодлого чиглэлийг тодорхойлоходоо нөөцийн найдвартай байдлыг хангах, хөрвөх чадварыг алдагдуулахгүй байх, үр өгөөжийг нэмэгдүүлэх (safety-liquidity-return) гэсэн зарчмыг үргэлжлүүлэн баримталсан. Тухайлбал, гадаад зах зээлд валютын ханшийн огцом хэлбэлзэл их, дотоодын зах зээлд ам долларын хэрэгцээ өндөр байсан зэрэгтэй уялдуулан гадаад валютын улсын нөөцийн голлох хэсгийг богино хугацааны, хөрвөх чадвар өндөртэй, ам доллараар илэрхийлэгдсэн хөрөнгө оруулалтуудад байршуулахаар шийдвэрлэсэн. Хөрөнгө оруулалтын эрсдлээс сэргийлэх үүднээс голчлон АНУ-ын Засгийн газрын үнэт цаас, АНУ, Герман, Япон, Их Британи зэрэг орнуудын төв банкуудын харилцах ба хадгаламж, Олон улсын төлбөр тооцооны банкны үнэт цаас ба хадгаламж, “АА”-аас дээш зэрэглэл бүхий дэлхийн банк, санхүүгийн байгууллагуудын хадгаламж гэсэн хөрөнгө оруулалтуудад байршуулав. Харилцагчийн эрсдлээс сэргийлэх зорилгоор Засгийн газар, Төв банк, ОУТТБанк, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зэрэглэл тогтоогч байгууллагаас баталсан зөвхөн “АА”-аас дээш зэрэглэл бүхий гадаадын банк, санхүүгийн байгууллагуудтай гадаад валютын нөөцийн удирдлагын хүрээнд хамтран ажилласан.

Монголбанк олон улсын санхүүгийн зах зээл дээр 137,624.12 унц буюу 4.4 тонн цэвэршүүлсэн алтыг худалджээ. Монголбанк гадаад валютын улсын нөөцийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах болон нөөцийн зохистой харьцааг бүрдүүлэх зорилгоор 2009 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 22 удаагийн гадаад валютын арилжааг хийв.

Түүнчлэн гадаадын банк санхүүгийн байгууллагуудад байршуулсан богино хугацаат валютын хадгаламж болон гадаадын үнэт цаасны хүүгээс нийт 7.6 тэрбум төгрөг

буюу 5.32 сая ам.долларын хүүгийн орлогыг гадаад валютын улсын нөөцөд оруулсан байна.

Гадаад валютын улсын нөөцийг импортын 17.7-гоос доошгүй долоо хоногийн төлбөрийг гүйцэтгэх хэмжээнд байлгах чиглэлээр:

Гадаад валютын улсын албан нөөц 2009 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 962.6 сая ам.доллар, цэвэр албан нөөц 827.6 сая ам.доллар байв. Гадаад валютын улсын нөөцийн хангалттай байдлыг цэвэр албан нөөцийн хувьд тооцож үзвэл импортын 18.8 долоо хоногийг хангахаар байв. Иймд импортын 17.7 долоо хоногийн хэрэгцээг хангасан хэмжээний нөөцтэй байх зорилтот үзүүлэлт бүрэн биелсэн байна.

Гадаад валютын улсын албан нөөцийг оны эхнээс 305.2 сая ам.доллараар нэмэгдүүлж, 2008 оны нөөцийн нийт бууралтыг 89 хувиар нөхсөн нь олон нийтийн сэтгэл зүйд эерэгээр нөлөөлөх, гадаад валютын захыг тогтвортжуулах, нөөцийн зорилтот үзүүлэлт хангагдахад чухал үр дүн үзүүлсэн. Үүнд:

- ◆ ОУВС-тай хамтран 18 сарын хугацаанд хэрэгжүүлэхээр тохирсон хөтөлбөрийн хүрээнд 229 сая ам.долларыг 0.75 хувийн хүүтэйгээр зээлэхээс 2009 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 115.5 сая ам.доллараар;
- ◆ Бусад хандивлагч болон хөрш орнуудын Засгийн газар, олон улсын байгууллагуудаас нийт 180 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусlamж олгохоор шийдвэрлэнээс АХБанк 5 дугаар сарын 25-ны өдөр 9.0 сая, Дэлхийн банк 7 дугаар сарын 24-ний өдөр 41.9 сая, АХБанк 8 дугаар сарын 3-ны өдөр 40 сая, Японы Засгийн газар 8 дугаар сарын 5-ны өдөр 2.9 тэрбум иен буюу 30 сая ам.долларын зээлийг олгосноор 122.1 сая ам.доллараар;
- ◆ Дотоодын захаас алт худалдан авч, түүнийг олон улсын жишигт хүргэн мөнгөжүүлсний үр дүнд тайлант хугацаанд 61.6 сая ам.доллараар;
- ◆ УИХ-ын ээлжит бус чуулганаар хэлэлцэн баталсан эдийн засгийн хямралтай тэмцэх төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу гадаадын харилцагч байгууллагуудаас алтны урьдчилгаа санхүүжилт авах асуудлаар Standard bank, Commerzbank, Samsung, Goldman Sachs, Mitsui зэрэг банк, санхүүгийн байгууллагуудаас ирүүлсэн саналыг Засгийн газартай хамтран судалсны үр дүнд Standard bank-аас авсан зээлийг банкуудад дамжуулан зээлдүүлээд үлдсэн 8.7 сая ам.доллараар тус тус нэмэгдүүллээ.

Цаашид зээл авсан 14 алт олборлогч аж ахуйн нэгжүүдийн олборлолт, тушаалт ямар байхаас уг арга хэмжээний гадаад валютын улсын нөөцөд үзүүлэх үр дүн хамаарна. Иймд зээлийн эх үүсвэрийг арилжааны банкууд зориулалтын дагуу ашигласан эсэх, зээл авсан аж ахуйн нэгжүүд алт олборлосон эсэх, олборлосон алтаа банкинд буюу Монголбанкинд тушааж байгаа эсэхийг газар дээр нь хянаж шалгах үүрэг бүхий тусгай ажлын хэсэгт Монголбанкны төлөөлөл оролцон ажиллаж байна.

Монголбанк нь БНХАУ, ОХУ, БНСҮ, Япон, АНУ-ын Төв банкуудтай үндэсний мөнгөн тэмдэгтийг солилцох (своп) хэлцэл хийх тухай асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, УИХ-ын ЭЗБХороо, Засгийн газарт танилцуулан холбогдох зөвшөөрөл, дэмжлэг, зөвлөмжийг авсан. Эхний ээлжинд, Хятадын Ардын Банктай 750 сая ам.доллартай тэнцэх нэг их наяд төгрөг болон таван тэрбум юанийн своп хэлцлийг гурван жилийн хугацаатай хийх гэрээг хэлэлцэж, үзэглэхэд бэлэн болгоод байна. ОУВС-тай тохирсон “Стэнд-Бай” хөтөлбөрөөр хүлээсэн үүргийн дагуу энэхүү своп хэлцлийг хийхээс өмнө холбогдох зөвшөөрлийг ОУВС-гаас авахаар хүлээж байна.

1.6. Экспортын алт, зэс, импортын нефть зэрэг гол нэрийн бараа, түүхий эдийн үнийн ирээдүйн хандлагыг тодорхойлж, урьдчилсан таамаглал хийх чадавхийг бий болгох замаар санхүүгийн үсмэл хэрэгслүүдээр үнийн эрсдлийн зохицуулалт хийдэг болно.

Экспортлогч, импортлогчдын 2 дугаар зөвлөгөөнийг Сангийн яамтай хамтран “Гадаад зээл” онцлох сэдэвтэйгээр 2009 оны 3 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан. Энэхүү зөвлөгөөнд гадаад худалдаа, үйлчилгээ, хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 42 компанийн 69 төлөөлөгч болон төрийн байгууллагын 23, арилжааны банкны 13 ажилтан тус тус оролцсон. Зөвлөгөөний үр дүнд оролцогч аж ахуйн нэгжүүд нь гадаад секторын статистик, ялангуяа гадаад зээлийн мэдээллийн макро эдийн засаг дахь ач холбогдол, экспорт, импортын гол бүтээгдэхүүнүүдийн дэлхийн зах зээл дээрх үнийн хандлага, тэдгээрийг шинжлэх арга зүйн талаарх мэдээллийг авч, Монголбанктай мэдээлэл солилцох гэрээ байгуулан гадаад зээлийн мэдээгээ өгч байхаар болсон. Ингэснээр нэг талаас Монгол Улсын төлбөрийн тэнцлийн үзүүлэлтийн чанарыг сайжруулах, гадаад хөрөнгө оруулалтын позицийн статистикийн иж бүрэн мэдээллийн санг бүрдүүлж, нөгөө талаас уг мэдээллийг үндэслэн экспортлогч, импортлогчид дэлхийн зах зээлийн үнэ, ханшийн эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах бололцоотой болох юм. Дараагийн зөвлөгөөнийг “Гадаадын шууд хөрөнгө оруулалт” онцлох сэдэвтэйгээр ЭБЭХЯам болон ГХОАгентлагтай хамтран 2009 оны 10 дугаар сарын 7-ны өдөр зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

1.7. Монголбанкинд тушаагдах алтны хэмжээ нь төлбөрийн тэнцэл, төсвийн орлого, валютын нөөцийн хэмжээнд нөлөөлж байгааг харгалzan тухайн жилд олборлосон алтыг Монголбанкинд бүрэн тушаадаг болгох арга хэмжээг хууль эрх зүйн хүрээнд холбогдох төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

- “Алтны санхүүжилтийн зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, алтны үйл ажиллагаа эрхэлдэг банкуудаас алт олборлогч 34 аж ахуйн нэгжийн мэдээллийг авч, алтны үйлдвэрлэлийн салбарын санхүүжилтийн бодит хэрэгцээ, шаардлагыг тооцож, Сангийн яаманд хүргүүлсэн.

- ◆ Монголбанкинд алтыг хүлээн авах, сорыцыг баталгаажуулах, савлах, хадгалах, алтны арилжааны хэлцлийг батлах, түүнд хяналт тавин ажиллах үйл ажиллагааг Монголбанкны Эрдэнэсийн санд төвлөрүүлж, харилцагч байгууллага, иргэдэд үзүүлэх үйлчилгээг түргэн шуурхай болгох арга хэмжээ авав.
- ◆ Алтны үйлдвэрлэлийг дэмжих, алт тушаалтыг нэмэгдүүлэх зорилгоор алтны үнийн бодлогод өөрчлөлт оруулж, дотоодын захаас цэвэршүүлээгүй алт худалдан авах үнийг алтны дэлхийн зах зээлийн үнээс 6-7 ам.доллараар доогуур тогтоож байсныг 2 ам.доллар болгон бууруулсан нь алтны салбарыг дэмжих замаар гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд авсан арга хэмжээ юм. Үүний үр дүнд дотоодын алт үйлдвэрлэгчдэд нийт 1.4 сая ам.доллартай тэнцэх хэмжээний хөнгөлөлтийг 2009 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр олгох төлөвтэй байна.
- ◆ Тайлант хугацаанд Монголбанкинд тушаасан алтны мэдээг СУХАлба, УТЕГазарт сар бүр хүргүүлж, олборлосон алтыг Монголбанкинд бүрэн тушаагдаж байгаа эсэхэд хяналт тавьсан. 2009 оны 8 дугаар сарын 31-ний байдлаар Монголбанк нь 3.3 тонн алт худалдан авсныг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1.3 тонноор бага байгаа. Гэвч олборлолтын үйл ажиллагаа нь зогссоны улмаас Алтандорнодмонгол компани 2009 онд Монголбанкинд алт тушаагаагүй харгалzan үзэх ёстой. Тус компани 2008 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монголбанкинд 1.86 тонн алт худалсаныг хасч тооцвол Монголбанк энэ оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 3.3 тонн алт худалдан авсан байгаа нь тус компанийн тушаасан алтыг хассанаарх өнгөрсөн оны мөн үед худалдан авсан алтны хэмжээтэй харьцуулахад 0.56 тонноор буюу 20.4 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Энэ нь худалдан авах алтны үнийг өсгөж алт олборлогчдыг дэмжих замаар гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээний үр дүн болно.
- ◆ “Тухайн жилд олборлосон алтыг Монголбанкинд бүрэн тушаадаг болгох арга хэмжээг хууль эрх зүйн хүрээнд холбогдох төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжсүүлнэ” гэсэн заалтын дагуу “Бороо Гоулд” компанийтай 5 удаагийн уулзалт, хэлэлцээрийг 2009 оны эхний хагаст зохион байгуулсан хэдий ч үр дүн хангалтгүй байна. Энэ нь тус компани Засгийн газартай тогтвортой байдлын гэрээ байгуулсантай холбоотойгоор НӨТ-аас чөлөөлөх, алтыг зөвхөн ам.доллараар худалдах, төгрөгөөр худалдсан нөхцөлд арилжааны банкуудаас илүү тааламжтай ханшаар тооцоог хийх зэрэг манай талын хүлээн авах боломжгүй нөхцөл, болзлыг тавьж байгаатай холбоотой байна. Иймд Монголбанкнаас энэхүү яриа хэлцлийн явц байдал, хууль, эрх зүйн орчинд өөрчлөлт оруулах талаарх саналыг Засгийн газарт хүргүүлж, УИХ-ын зарим гишүүдэд танилцуулсан.

- ◆ СҮХ Албаны болон алт цэвэршүүлэгч гадаадын компанийн хооронд тогтмол үүсч байсан алтны сорьцын зөрүүний шалтгааныг тодруулах зорилгоор хөндлөнгийн сорьцын хяналтын байгууллага болох “Алекс Стюарт” компаниар газар дээрх хяналтын ажлыг хоёр удаа гүйцэтгүүлсэн. Үүний үр дүнд Монгол Улсын СҮХ Албаны тогтоож буй сорьцын дүгнэлт нь Монгол улсын эрх ашигт хохиролтой байдлаар тогтоогдож байгааг баримтжууллаа. Уг асуудлыг шийдвэрлэх саналыг Монгол Улсын Тэргүүн шадар сайдад албан тоотоор хүргүүлэхийн зэрэгцээ биечлэн уулзаж дэлгэрэнгүй танилцуулга хийсэн.
- ◆ Монголоос олборлосон алтыг эдийн засгийн хямралын энэ үед зөвхөн гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор ашиглах асуудлыг хуульчлах зорилгоор “Ашигт малтмалын тухай”, “Эрдэнэсийн сангийн тухай” хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа хуулийн үзэл баримтлалын хамт боловсруулж УИХ-ын гишүүнд хүргүүлсэн.

Дээрх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн хэдий ч алт тушаалт өнгөрсөн оны мөн үеэс бага байгааг судалж үзэхэд Алтан дорнод монгол зэрэг томоохон алт олборлогч компаниуд үйл ажиллагаа явуулаагүй нь нөлөөлснөөс гадна “Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хууль”-д заасан “гэнэтийн ашгийн татвар”-ыг тэглэх хүлээлттэй холбоотой байж болзошгүй байгаа тул уг татварыг тэглэх саналыг УИХ-ын ЭЗБХороонд 2009 оны 8 дугаар сард хүргүүлсэн. Энэ саналыг өмнө нь ЭБЭХЯам болон УИХ-д хүргүүлж байсан болно. Үүний үр дүнд уг татварыг 2011 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн тэглэхээр болсон. Түүнчлэн, ой мод, голын ай сав газарт алт олборлохыг хориглох тухай УИХ-ын шийдвэртэй холбоотойгоор алт олборлолт цаашид буурч болзошгүй байна.

Хүснэгт 2.2. Гадаад валютын дотоод зах, улсын нөөцтэй холбоотой үндсэн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2008		2009			2009.VIII.31	2009.VIII.31	2009.VIII.31	2009.VIII.31
	VI.30	XII.31	III.31	VI.30	VIII.31	2008.VIII.31	2008.XII.31	2009.III.31	2009.VI.30
Монгол банкны албан ханш, ₮	1158,1	1267,5	1524,1	1435,5	1429,1	123,0	112,7	93,8	99,6
Банк хоорондын захын ханш, ₮	1157,6	1274,5	1487,2	1435,6	1422,0	122,8	111,6	95,6	99,1
Албан бус захын ханш, ₮	1160,5	1296,0	1480,0	1436,5	1422,0	122,5	109,7	96,1	99,0
Гадаад валютын нөөц, сая ам. \$	976,6	657,4	521,2	783,3	962,6	103,4	146,4	184,7	122,9

Эх сурвалж: Монголбанк

Гадаад валютын нийт нөөцийг 2009 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 962.6 сая ам.долларт хүргэн нэмэгдүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 31.4 сая ам.доллараар илүү байна.

2. САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ХҮРЭЭНД

2.1. Банкны салбарын тогтвортой байдлыг хамгаалсан бодлого явуулна.

Хяналт шалгалтын газраас арилжааны банкны үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу эхний 2 улирлын байдлаар нийт 8 банкинд газар дээр нь иж бүрэн шалгалт хийж, дүнг Монголбанкны Захирлуудын зөвлөлд танилцуулан шалгалтын мөрөөр хэрэгжүүлэх хугацаатай үүрэг, даалгаврыг тушаалаар батлан банкуудад хүргүүлж ажилласан. Мөн банкны санхүүгийн тайлан мэдээг сар, зарим мэдээллийг өдөр бүр хүлээн авч, банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн болон тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтэнд хяналт тавьж, банкны салбарын үзүүлэлтүүдийг нэгдсэн байдлаар гарган системийн шинж чанартай эрсдэлд үнэлэлт дүгнэлт өгч байна. Дэлхийн санхүү, эдийн засгийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан улсын эдийн засаг, санхүүгийн байдалд үүсч болзошгүй эрсдэлтэй нөхцөл байдлын эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг банк бүрээр гаргуулан, үнэлэлт дүгнэлт өгч, банкны системийн нэгдсэн төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Хүснэгт 2.3. Банкны салбарын эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

	2008.VI.30	2008.XII.31	2009.III.31	2009.VI.30	2009.VI.30 2008.VL.30	2009.VI.30 2008.XII.31	2009.VI.30 2009.III.31
1. Нийт актив	3760,3	3630,2	3858,3	3851,7	102,43	106,10	99,83
2. Зээлийн өрийн үлдэгдэл	2650	2715	2757,7	2641,5	99,68	97,29	95,79
3. Чанаргүй зээл	73,1	193,7	287,7	301	411,76	155,39	104,62
4. Нийт харилцах хадгаламж	2545,7	2412,5	2535,9	2555,3	100,38	105,92	100,77
5. Өөрийн хөрөнгө эрсдлээр жигнэсэн активын харьцаа	13.2%	11.6%	11.1%	9.4%			
6. Активын өгөөж	2.5%	-1.5%	0.0%	-2.4%			
7. Өөрийн хөрөнгийн өгөөж	27.6	-21.2%	-1.2%	34.6%			

2.2. Банкны байгууллагын үйлчилгээ нь бизнесийн үйл ажиллагааг дэмжин, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хэрэгцээнд оновчтой нийцсэн санхүүгийн бүтээгдэхүүнийг цогц хэлбэрээр үзүүлэхэд шаардлагатай эрх зүйн болон дэд бүтцийн орчныг сайжруулах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулна.

Санхүүгийн зохицуулах хороотой хамтран ажиллах, мэдээлэл солилцооор “Хамтын ажиллагааны гэрээ”-г 2008 онд байгуулсан. Гэвч байгуулсан гэрээний дагуу дагаж

мөрдөх журам, зааврыг батлах асуудал нэгдсэн хяналт шалгалтыг зохицуулсан хууль, эрх зүйн орчин бүрдээгүйгээс шалтгаалан хойшлогдоор байна. Иймээс Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд санхүүгийн зарим нэгдэлд Санхүүгийн зохицуулах хороотой хамтран шалгалт хийх, мэдээлэл солилцох чиглэлээр заалт нэмж тусгасан.

2.3. Банкны харилцагч, хадгаламж эзэмшигч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, банкны байгууллагын үйлчилгээний шударга, ил тод, ойлгомжтой байдлыг сайжруулах, банкны ажилтны ёс зүйн зарчмуудыг мөрдөн ажиллуулах чиглэлд Монголбанкны үйл ажиллагааг өргөжүүлнэ.

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас банкны бүтээгдэхүүн үйлчилгээний талаар ирүүлсэн санал гомдлын дагуу газар дээр нь шалгалт хийж, шаардлагатай үед Улсын байцаагчийн акт тогтоож, зөрчлийг залруулах арга хэмжээг тухай бүр авч байна. Тухайлбал: 2009 оны 1 дүгээр улиралд Хяналт шалгалтын газраас 42, 2 дугаар улиралд 107, 2009 оны 8 дугаар сарын 31-ний өдрийг хүртлэх хугацаанд 272, нийт 421 иргэд, аж ахуйн нэгж байгууллагын санал, гомдлыг хүлээн авч холбогдох арга хэмжээг авсан болно. Сүүлийн саруудад хүү, ханшийн огцом хэлбэлзэлтэй холбоотойгоор орон сууцны зээлийн талаар санал, гомдол олонтаа ирэх болсон. Үүний дагуу орон сууцны зээлийн нөхцлийг харилцагч, үйлчлүүлэгч нарт ойлгомжтой болгох талаар банкны холбогдох удирдлагад зөвлөмж өгсөн болно.

2.4. Олон Улсын Төлбөр Тооцооны Банкны дэргэдэх Базелийн Санхүүгийн Тогтвортой байдлын Хорооноос гаргасан банкны хяналт, шалгалтын үндсэн зарчмуудыг бүрэн хэрэгжүүлснээр монголын банк, санхүүгийн байгууллагууд олон улсын зах зээлд хүрч ажиллах, хямд, урт хугацаатай хөрөнгө татан төвлөрүүлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэх бололцоог бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, эрсдэлийг үнэлж, хязгаарлах ажлыг хэрэгжүүлнэ.

Монголбанк нь дотоодын банк, санхүүгийн байгууллагын олон улсын зах зээл дээр ажиллах санаачилга, эрмэлзлийг бүхий л талаар дэмжиж байгаа бөгөөд тайлант хугацаанд ХАС банкнаас Киргизийн “Мол булак” бичил санхүүгийн байгууллагад хөрөнгө оруулалт хийхэд туслалцаа үзүүлсэн болно. Үүнээс гадна Монголбанк 4 банкны олон улсын санхүүгийн зах зээл дээр ажиллах асуудлыг судалж байна. Одоогийн байдлаар олон улсын санхүүгийн зах зээл тогтвортгүй байгаа тул эдгээр 4 банкны асуудал түр хугацаагаар хойшлогдсон.

Мөн Дэлхийн банк (“Private Sector Development Project II”) болон Японы олон улсын хамтын ажиллагааны банк (“JBIC-Two Step Loan”)-наас жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийг банкуудаар дамжуулан хэрэгжүүлж байна. Монголбанкнаас эдгээр

төслийд оролцох санхүүгийн байгууллагыг сонгон шалгаруулахад туслалцаа үзүүлэн ажиллаж байгаагаас гадна шалгуур үзүүлэлтийн биелэлтийг сар бүр хүргүүлж байна.

Хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгоход чиглэгдсэн зээл, хүүгийн бодлогыг дэмжих үндсэн арга хэрэгслийн нэг болох Зээлийн мэдээллийн сан (ЗМС)-гийн үйл ажиллагааг боловсронгуй болгох асуудалд анхааран ажиллаж байна. Үүнд Монголбанкнаас ЗМС-гийн программ хангамжийг шинэчлэн боловсруулах ажлыг бие даан гүйцэтгэж, харин эрх зүйн орчинг боловсронгуй болгох асуудлаар Монголын банкуудын холбоотой хамтран ажиллаж байна.

2.5. Эрсдэлд суурилсан зохистой харьцааны үзүүлэлт ба санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх арга хэрэгслийг хослуулан хэрэглэх, түүнийг боловсронгуй болгох замаар санхүүгийн зах зээлийн ил тод байдлыг дээшлүүлнэ.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2009 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 154 дугаар тушаалаар “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, хяналт тавих журам”-д өөрчлөлт оруулан арилжааны банкуудын өөрийн хөрөнгийн зохистой харьцааг 12 хувь болгон нэмэгдүүлснээс гадна Банкны тухай хуулинд оруулахаар санал болгож буй нэмэлт, өөрчлөлтөд даатгалын зуучлагч болон итгэлцлийн үйл ажиллагааны талаар тусгасан болно. Мөн банкуудын зах зээлд оролцсоноор үнэт цаасны үйл ажиллагаатай холбоотой гарч болзошгүй эрсдэлд тавигдах хязгаарлалт, шаардлага, үүсч болзошгүй ашиг сонирхлын зөрчлийг бууруулах талаар тодорхой заалтыг хуулийн төсөлд оруулсан болно.

2.6. Хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаа эрхлэх бололцоо бүрдүүлэх, хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр банкны салбарын эрх зүйн шинэчлэлийг үргэлжлүүлнэ.

Чөлөөт бүсэд үйлчлэх валютын зохицуулалт, чөлөөт бүсэд хөрөнгө оруулалтын банк байгуулах тухай Монголбанкны баримтлах стратегийн бодлогыг тодорхойлох ажлыг бэлэн болгоод байна. Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулан Олон Улсын Санхүүгийн байгууллагууд, түүний дотор Олон Улсын Валютын Сангаас санал авсан бөгөөд өнөөгийн нөхцөлд хөрөнгийн зах зээлийн хөгжил компаниудын зохистой удирдлага суд, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын хэрэгжилт хангалтгүй байгаагаас шалтгаалан банкуудын эрсдэл эрс нэмэгдэж болзошгүй, хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцсоноор банкуудын одоогийн санхүүгийн хүндрэлтэй байгаа асуудлыг хүрдан хугацаанд даван туулахад саад учруулах магадлал өндөр гэж үзсэн тул нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслөөс хассан болно.

“Банкин дахь мөнгөн хадгаламжинд баталгаа гаргах тухай хууль”-ийг 2008 оны 11 дүгээр сард УИХ-аас баталснаар хадгаламжийн даатгалын шууд бус тогтолцоог Монгол Улсад нэвтрүүлсэн. Монголбанк, Сангийн яамны хамтарсан ажлын хэсэг ОУВС-гаас өгсөн зөвлөмжийн дагуу уг баталгааны тухай хуулинд орох нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулсныг 2009 оны 2 дугаар сард УИХ-аас баталсан. Үүнээс гадна Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн эрх зүйн байдлыг хуульчлан тогтоох үүднээс Төв банкны тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг тусган Засгийн газраар дамжуулан УИХ-д өргөн барьсан.

Арилжааны банкуудын эрсдэлийн удирдлагын дотоод загварыг баталгаажуулах зааврыг батлуулах үүднээс Basel-ын хяналт шалгалтын хорооноос гаргасан (IRB model validation Guideline) зааврыг судалж байна.

2.7. Ипотекийн анхдагч ба хоёрдогч зах зээлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үйл ажиллагааг нь эрчимжүүлнэ.

Монголбанкны зүгээс нийгмийн амьжиргааны түвшинг хамгаалах, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх эн тэргүүний зорилтыг ханган ажиллахын зэрэгцээ орон сууцны санхүүжилтийн анхдагч болон хоёрдогч захыг хөгжүүлэхэд идэвх санаачилгатай ажиллаж ирлээ.

Монголбанк, банкууд, Монголын Ипотекийн Корпорацитай хамтран орон сууцны ипотекийн зээлийн журам, технологийг бүрдүүлэх тал дээр анхаарал тавин ажиллаж, “Ипотекийн зээлийн үйл ажиллагааны журам”-ыг хамтран боловсруулж баталж 2009 оны эхнээс банкууд мөрдлөг болгон ажиллахаар болсон нь ипотекийн анхдагч зах зээлийн дэд бүтцийг сайжруулж, орон сууцны ипотекийн зээлийн чанарыг зохих түвшинд байлгах нөхцлийг бүрдүүлэхэд чухал шаардлагатай үндэс суурийг бий болголоо.

Орон сууцны ипотекийн зээлийн эрсдлийг ажиглаж байх, бодлого боловсруулагчдад мэдээлэл бэлтгэж өгөх зорилгоор банкны системийн ипотекийн зээлийн тайланг дэлгэрэнгүй хэлбэрээр нэгтгэн мэдээлж байна.

Манай улсад зээлийн хөрөнгийг багцлан худалдах, үнэт цаасжуулах үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн харилцаа бүрэлдээгүй байна. Ипотекийн зах зээлийг манай улсад цаашид хөгжүүлэхэд эн тэргүүнд шаардлагатай “Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай” хууль УИХ-аар батлагдан гарахад Монголбанк мэргэжлийн зөвлөгөө өгч ажиллалаа. Эрх зүйн зохистой тогтолцоо бүрдүүлэх үүднээс “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай” хуулийн төслийг боловсруулахад Монголбанкны зүгээс идэвхитэй хамтран ажиллаж байна.

Барилгын салбарыг дэмжих хамгийн үр ашигтай хэлбэр нь ипотекийн зээл олголтыг дэмжих явдал гэж Монголбанк үздэг билээ. Үүний тулд орон сууцны ипотекийн зээлийн эх үүсвэрийг МИК-иар дамжуулан нэмэгдүүлэх, орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах, арилжаанд оруулах чиглэлээр МИК-тай хамтран ажиллаж байна. Одоогоор Германы сэргээн босголт, хөгжлийн банкны эх үүсвэрээр нийт 4.8 сая европийн зээлийг МИК-иар дамжуулан орон сууцны ипотекийн зээлийг дахин санхүүжүүлэх төсөл УИХ-аар соёрхон батлагдах шатандаа байна. Харин МИК-ийн бондоор дамжуулан орон сууцны санхүүжилтийн хоёрдагч захыг эхлүүлэх ажил бэлтгэл хангагдаж дууссан бөгөөд 25 тэрбум төгрөгийн МИК-ийн бондын зөвшөөрөл хүссэн өргөдөл СЗХ-д хүргүүлсэн болно.

Дотоодын орон сууцны ипотекийн зээлийн эрсдэл бага, зээлдэгчдийн санхүүгийн хариуцлага өндөр зэрэг эрсдлийн үнэлгээний чухал үзүүлэлтүүдийг эрх зүйн зохицуулалтад зөв тусгах, эрсдэл багатай санхүүгийн бүтээгдэхүүнийг хөхүүлэн дэмжих үүднээс МИК-иас гаргасан үнэт цаасыг Монголбанкны репо санхүүжилтэд хүлээн зөвшөөрөгдөх активын тоонд оруулахаар шийдвэрлэсэн болон бусад төрлийн үнэт цааснаас бага буюу 35 хувийн эрсдлийн түвшинтэй байхаар тогтоож өгсөн нь ипотекийн хоёрдогч захыг эхлүүлэн хөгжүүлэхэд чухал алхам болсон гэж Монголбанкны зүгээс үзэж байна.

2.8. “Монгол Улсын төлбөр тооцооны системийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төлбөр тооцооны системийн үйл ажиллагаанд хяналт тавих, найдвартай, шуурхай байдлыг хангахад шаардлагатай дэвшилтэй технологийг нэвтрүүлэх болон бэлэн бус төлбөр тооцооны хэрэглээг нэмэгдүүлнэ” гэсэн ажлын хүрээнд дараах ажлууд хийгдээд байна. Үнд:

2.8.1 Монгол Улсад Бодит цагийн төлбөрийн систем /RTGS/-ийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах

Банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцоог бодит цагийн горимоор гүйцэтгэх систем /RTGS/-ийг нэвтрүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, програм хангамж хугацаандаа бүрэн нийлүүлэгдэж, төлөвлөсөн сургалт, уулзалтыг зохион байгуулсан.

Системийн эрх зүйн орчинг бүрдүүлэх ажлын хүрээнд:

- “Банк хоорондын их дүнтэй гүйлгээний журам”-ыг шинэчлэн 2009 оны 6 дугаар сараас эхлэн мөрдөж, “Банк хоорондын их дүнтэй гүйлгээний ажлын гэрээ”-г тус системийн оролцогчид болох банкууд, Сангийн яамны Төрийн сангийн газартай байгууллаа.

- ♦ Монголбанкнаас мөрдөж байгаа үйлчилгээний хүү, шимтгэлийг төвлөрүүлэн тодорхойлж, “Монголбанкны хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-ийг олон нийтэд цахим хуудсаар дамжуулан ил тод мэдээлдэг зарчмыг нэвтрүүллээ. Ингэснээр Монголбанк хүү, шимтгэлийн нэгдсэн бодлоготой болж, олон улсын нийтлэг жишигт хүрч ажиллав.

2.8.2 Монгол Улсад Бодит цагийн төлбөрийн систем /RTGS/-ийг нэвтрүүлэх

Банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцоог бодит цагийн төлбөр тооцооны системд 2009 оны 5 дугаар сарын 29-ний өдөр бүрэн шилжүүлж, “Банксүлжээ” систем гэж нэрлэн, 2009 оны 6 дугаар сарын 2-ны өдөр албан ёсны нээлтийг хийлээ.

Систем нэвтэрснээс хойш үйл ажиллагаа нь төсөл гүйцэтгэгч CMA Small Systems AB компани болон “Банксүлжээ” төслийн нэгжийн ажилтнуудын бүрэн хяналтад 1 сарын хугацаатай явагдаж, банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцоонд ноцтой нөлөөлөхүйц ямар нэгэн хүндрэл, доголдол системийн ажиллагаанд гараагүй, хэвийн ажиллаж байна.

“Банксүлжээ” систем нь түүний оролцогчдоос илгээсэн гүйлгээ бүрийг тухайн цаг мөчид хүлээн авагч банк руу дамжуулан, үр дүнг бодит цагаар тооцож, банкуудад төлбөр тооцооны эрсдлийг хянах, өөрийн активыг зохистой удирдах боломжийг олгохын зэрэгцээ төлбөрийн бүх төрлийн систем (үнэт цаас, валютын арилжаа, бага дүнтэй төлбөр тооцоо гэх мэт)-ийг холбох үндсэн системийн үүрэг гүйцэтгэх ач холбогдолтой.

2.8.3 “Монгол Улсын төлбөр тооцооны системийн хууль”-ийн төслийг боловсруулж, холбогдох газруудаас санал авах

Монгол Улсын төлбөр тооцооны систем, цахим төлбөрийн хэрэгсэл, цахим мөнгөний тухай хуулийн төслийг анхны хувилбараар боловсруулж дуусах шатанд явж байна.

2.8.4 Монгол Улсын төлбөр тооцооны системийн үйл ажиллагааг тодорхойлсон Монгол Улсын төлбөр тооцооны системийн “Улаан ном”-ыг боловсруулах

Монголбанк нь Монгол Улсын төлбөр тооцооны системийн “Улаан ном”-ын төслийг дараахь бүтэцтэйгээр боловсруулаад байна. Үүнд:

- ♦ Монгол Улсын төлбөр тооцооны системийн бүтэц, зохион байгуулалт;
- ♦ Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгж байгууллагын ашигладаг төлбөрийн хэрэгслүүдийн талаарх ерөнхий мэдээлэл;
- ♦ Банк хоорондын төлбөр тооцооны систем;
- ♦ Монгол Улсын төлбөр тооцооны системийн цаашдын зорилт.

Цаашид Монгол Улсын төлбөрийн системийн “Улаан ном”-ыг англи хэл дээр орчуулж, Олон улсын төлбөр тооцооны банктай хамтран гаргаснаар Монгол Улсын төлбөр тооцооны системийн талаарх мэдээллийг олон улсад нээлттэй, ил тод болгон, гадаадын хөрөнгө оруулагч, банкуудад сурталчлах ач холбогдолтой болно.

2.8.5 “Монголбанкнаас төлбөр тооцооны системд хяналт тавих бодлогын баримт бичиг”-ийг боловсруулж, мөрдөх

Олон улсын төлбөр тооцооны банкнаас гаргасан зөвлөмжийг удирдлага болгон “Монголбанкнаас төлбөр тооцооны системд хяналт тавих бодлогын баримт бичиг”-ийг боловсруулж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2009 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 431 дүгээр тушаалаар баталж, Монголбанкны цахим хуудсанд байршуулан мөрдөж эхлээд байна.

Энэхүү бодлогын баримт бичиг нь төлбөр тооцооны системд оролцогчдын төлбөр тооцооны найдвартай, тасралтгүй ажиллагааг хангахад Монголбанкнаас тавих хяналтыг нээлттэй, ил тод хэрэгжүүлэхэд баримтлах ач холбогдолтой юм.

Цаашид төлбөрийн системд хяналт тавих Монголбанкны эрх, үүргийг хуульчлан батлуулах шаардлагатай тул Монгол Улсын төлбөрийн системийн хуулийн төслийн анхны хувилбарыг боловсруулж байна.

2.8.6 Бэлэн мөнгийг багасгах, бэлэн бус төлбөр тооцооны хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд алслагдсан хөдөө орон нутгийн дүүргийн иргэдэд банкны үйлчилгээг гар утсаар (mobile-banking) хүргэх ажлыг нэвтрүүлж буй банкуудад (сургалт зохион байгуулах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэх мэт) дэмжлэг үзүүлэх

Монгол Улсын хэмжээнд бэлэн бус төлбөр тооцоо давамгайлсан нийгмийг бий болгох, ялангуяа бэлэн бус төлбөр тооцооны нэгэн хэлбэр болох хөдөлгөөнт (mobile) банкны үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор банк болон үүрэн телефоны үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад зориулсан “Мобайл банк” сэдэвт олон улсын зөвлөгөөнийг Дэлхийн банкны гишүүн байгууллага болох “Олон улсын санхүүгийн корпораци”-тай хамтран 2009 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулсан. Уг зөвлөгөөнд банк санхүүгийн болон үүрэн телефоны үйлчилгээ үзүүлэгч нийт 25 байгууллагын 114 төлөөлөгч оролцов. Мөн салбар зөвлөгөөнийг Говь-Алтай аймагт зохион байгуулав.

Энэхүү зөвлөгөөн нь манай улсын хөдөө орон нутгийн алслагдсан байршлын болон бага орлоготой иргэдэд банк, санхүүгийн үйлчилгээг хүргэх чиглэлд үүрэн телефоныг ашиглах талаарх олон улсын туршлагатай танилцах, манай улсын үүрэн телефоны үйлчилгээ үзүүлэгч байгууллага, банк, санхүүгийн байгууллагууд энэ талаар өөрт байгаа боломжийг бусдад танилцуулах, санал бодлоо хуваалцах, бэлэн бус төлбөр тооцооны энэ хэлбэрийг хөгжүүлэхэд цаашид баримтлах хөгжлийн бодлого, зорилт, арга замын асуудлаар санал бодлоо солилцсон чухал ач холбогдолтой арга хэмжээ боллоо.

Тус зөвлөгөөнөөс цаашид банк, санхүү, харилцаа холбооны дэд бүтцийг давхардалгүйгээр ашиглан иргэдэд үүрэн телефоны технологийн тусламжтайгаар банк санхүүгийн үйлчилгээг зардал багатай, түргэн шуурхай, найдвартай авах боломжийг олгох үүднээс ТТҮЗ, Монголбанк, СЗХ, Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар, Санхүүгийн мэдээллийн алба, банк, үүрэн телефоны үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад хандан зөвлөмж гарган холбогдох байгууллага, УИХ, Засгийн газарт хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Түүнчлэн Олон улсын санхүүгийн корпорацид хөдөлгөөнт банкны үйлчилгээний бодлого, зохицуулалтын баримт бичгийг боловсруулахад мэргэжлийн туслалцаа авч, хамтран ажиллахыг хүсч албан захидал илгээсэн.

Зөвлөгөөний үр дүн гарч байгааг зарим банкны жишээ харуулж байна. Тухайлбал, Хас банк нь Дэлхийн банкны технологийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр иргэдэд гар утсаа ашиглан банкны үйлчилгээг авах боломжийг олгосон “Амар” хэмээх үйлчилгээг нэвтрүүлээд байна. Хас банк нь иргэдэд тус банкны салбар нэгж байхгүй газарт банктай хамтран ажиллах түншлэлийн гэрээ байгуулсан байгууллагууд дээр очиж, банкны үйлчилгээг авах боломжийг олгох үүднээс Петровис ХХК, Монгол шуудан ХК-тай хамтран ажиллаж байна.

Түүнчлэн Голомт банк нь үүрэн телефоны операторуудтай хамтран бүх төрлийн дансны орлого, зарлагын мэдээллийг мессэжээр гар утсандaa хүлээн авах “Easy Info” хэмээх үйлчилгээг шинээр нэвтрүүлсэн.

2.9. “Төв банк, банкны салбарт мэдээллийн технологийн аудит, хяналт, шалгалтыг иж бүрнээр нь хэрэгжүүлж эхлэх, Төлбөр тооцооны төв, Төрийн сан, банкууд бизнесийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах нөөц төлөвлөгөө, нөөц төвтэй байх шаардлагыг ханган ажиллуулахад тавих хяналтыг сайжруулна” гэсэн зорилтын хүрээнд дараах ажлууд хийгдээд байна. Үүнд:

2.9.1 Нөөц төвийн үйл ажиллагааг хэвийн горимд оруулж, нөөцлөлийг тогтмол хийж эхлэх

Монголбанк нь төлбөр тооцооны системд оролцогчдын банк хоорондын гүйлгээний мэдээллийг хадгалах зориулалт бүхий нөөц төвийг байгуулж, өгөгдлийн нөөцлөлийг тогтмол хийж байгаа бөгөөд нөөц төвтэй холбогдсон шугамын хурдыг нэмэгдүүлж, илүү өндөр хурдаар холбогдох боломжтой болгов.

Эдгээр нөөц төвүүд нь үндсэн төвтэй адил тоног төхөөрөмжтэй бөгөөд банк хоорондын төлбөр тооцооны системд техник, програм хангамжийн гэнэтийн саатал

гараах, байгалийн давагдашгүй хүчин зүйлээс хамаарч үндсэн төв ажиллах боломжгүй болсон тохиолдолд нөөц тевд шууд шилжин ажиллах боломжтой.

Мөн санхүүгийн дундын нэгдсэн сүлжээ болон “Банксүлжээ” системийн програм хангамжууд харилцан орлож ажиллах бүрэн боломжтой бөгөөд төлбөр тооцооны системд оролцогч байгууллагуудыг холбосон шилэн кабель, нөөц кабель, диал-ап зэрэг нөөц холболтуудын үйл ажиллагаанд өдөр тутам хяналт тавьж байна.

Монголбанкнаас Сангийн яамны Төрийн сангийн газар болон банкуудын банк хоорондын гүйлгээний мэдээллийн сангийн нөөцлөлт, нөөц төвийн үйл ажиллагаанд шалгалт хийх ажлын хүрээнд Хаан банк, Монгол шуудан банкинд тус тус шалгалт хийсэн. Бусад банкуудыг энэ онд багтаан шалгахаар төлөвлөж байна.

2.10. Хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн хадгаламжийн даатгалын болон банкны хяналт, шалгалтын нэгдсэн тогтолцооны эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Монголбанк, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яамны хамтарсан ажлын хэсгээс хадгаламжийн даатгалын шууд тогтолцооны хуулийн төслийг эцэслэн боловсруулж, Засгийн газраар дамжуулан УИХ-д өргөн барихад бэлэн болгоод байна.

Сүүлийн жилүүдэд банк, банк бус санхүүгийн байгууллага, даатгал болон үнэт цаасны компаниуд нэгдэн нийлэх, хамтран үйл ажиллагаа эрхлэх тохиолдол олон гарч байна. Энэ нь нэг талаас банк, санхүүгийн байгууллагын хоорондын уялдаа, үр ашгийг дээшлүүлэх давуу талтай боловч, нөгөө талаас санхүүгийн салбарын хямралд өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Иймд Монголбанкнаас нэгдсэн хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх, санхүүгийн байгууллагын хүндрэл нөгөөд тархах эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг авч эхлээд байна. Нэгдсэн хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай тул Монголбанкнаас энэ чиглэлээр Төв банк болон Банкны тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулж, Засгийн газраар дамжуулан УИХ-д өргөн бариад байна.

2.11. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор урт хугацаатай зээлийн хэмжээг нэмэгдүүлнэ.

Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан шийдвэрээр 2004 онд чанаргүй зээлд байгуулах эрсдэлийн сангийн хувь хэмжээг нэмэгдүүлэн тогтоож байсан. Энэхүү арга хэмжээний гол зорилго нь банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг хаах зохих хэмжээний эх үүсвэрийг эдийн засгийн өсөлт болон банкны ашигт ажиллагаа өндөр байсан үед бүрдүүлэхэд оршиж байсан. Өмнөх

жилүүдэд бий болгосон дээрх эх үүсвэрийг эдийн засгийн өсөлт саарч байгаа өнөө үед түлхүү ашиглаж банкны зээлжүүлэх чадварыг дээшлүүлэх зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2009 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн хамтарсан тушаалаар эрсдэлийн сангийн хувь хэмжээг бууруулан тогтоосон. Үүнд:

Зээлийн төлөгдөх хугацааг “1 удаа” сунгаж болно гэснийг “2 удаа” гэж өөрчлөн, хэвийн бус зээлийн эрсдэлийн санг байгуулахдаа “40 хувь”-ийг “25 хувь”, эргэлзээтэй зээлийн эрсдэлийн санг байгуулахдаа “75 хувь”-ийг “25 хувь” болгож бууруулсан бөгөөд зээл болон хүлээж болзошгүй үүргийн хугацааны үзүүлэлтийг дүгнэхдээ эргэлзээтэй зээлийн хугацаа хэтэрсэн “181-270 хоног”-ийг “181-360 хоног”, муу зээлийн хугацаа хэтэрсэн “271-ээс дээш хоног”-ийг “361-ээс дээш хоног” гэж тус тус өөрчилсөн. Мөн зээлийн гэрээний хугацаа 1 удаа сунгагдсан бол зээлийн ангиллыг хэвээр үлдээж, харин 2 дахь удаагаа сунгаж байгаа тохиолдолд зээлийн ангиллыг нэг шатлалаар бууруулахаар шийдвэрлэсэн.

Иргэд, аж ахуйн нэгжид жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар 2009 оны эхний хагас жилд нийт 151.2 тэрбум төгрөгийн зээл олгож, 211.1 тэрбум төгрөгийн зээл төлөгдсөн байна. Олгосон зээлийн хамгийн өндөр хүү жилийн 48 хувь, хамгийн бага хүү 3.9 хувь байгаа бөгөөд тайлант хугацаанд зээлийн өрийн үлдэгдэл 453.4 тэрбум төгрөгт хүрчээ. Үүнээс 54.5 хувь буюу 247.3 тэрбум төгрөг нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэдийн, 45.5 хувь буюу 206.1 тэрбум төгрөг нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжийн зээлийн өрийн үлдэгдэл байна. 2009 оны эхний хагас жилийн байдлаар цалин, тэтгэвэр, орон сууц худалдан авахад зориулж 250.4 тэрбум төгрөгийн зээл олгоод байна.

2.12. Банкны салбарын шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах, сумдад банкны үйлчилгээний өрсөлдөөнийг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

Монголбанк нь Японы олон улсын хамтын ажиллагааны банк (“JBIC”)-ны ЖДҮ-ийг хөгжүүлэх, түүнчлэн Дэлхийн банкны Хувийн хэвшлийг дэмжих төслүүдийг хэрэгжүүлэх талаар Сангийн яамтай хамтран ажиллаж байна. Одоогоор банкууд ЖДҮ-ийг хөгжүүлэх төслийн 30 орчим сая ам.доллар, Хувийн хэвшлийг хөгжүүлэх төслийн 7 сая ам.долларын зээлийн өрийн үлдэгдэлтэй байна.

2.13. Гадаад зах зээлээс урт хугацаатай, бага хүйтэй эх үүсвэрийг арилжааны банкуудад байршуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

ДБ, АХБ, ЕСБХБ, ОУСК, Жайка, Голландын хамтын ажиллагааны байгууллага зэрэг олон улсын банк, санхүүгийн байгууллага, дэлхийд нэр хүнд бүхий хөрөнгө оруулалтын банк, компаниудад Монголын эдийн засаг, банк, санхүүгийн салбарт

хөрөнгө оруулалт хийх хүсэлтүүдийг уламжлан, банкны салбарт шинэчлэлт өөрчлөлт хийх хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар харилцан тохиролцож байна.

Монгол Улсын хөрөнгө оруулсан ОУХОБ, ОУЭЗХАБанкуудаас дотоодын арилжааны банкуудад байршуулсан хадгаламж 2009 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар 11.8 сая ам доллартай тэнцэх хэмжээний евро, Монголын аж ахуйн нэгж, байгууллагуудад олгосон зээл 52.5 сая ам долларын үлдэгдэлтэй байна.

3. ТӨВ БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД

3.1. Монголбанкны үйл ажиллагааны бие даасан, ил тод байдлыг бэхжүүлж, олон нийтийн дунд инфляцийн буруу хүлээлт үүсэхээс урьдчилан сэргийлэхэд анхаарч ажиллана.

Монголбанк бодлогын арга хэмжээг авсан даруйд холбогдох мэдээллийг өдөр тутмын томоохон сонин хэвлэлд нийтлүүлэхийн сацуу өөрийн цахим хуудсандaa шуурхай байршуулах, хэвлэлийн бага хурал хийх, ярилцлага өгөх, мэдэгдэл нийтэлж олон нийтийн хүртээл болгох ажлыг Монголбанкнаас зохиосоор ирлээ.

Тухайлбал, бодлогын хүүг нэмэгдүүлэх, хүүний бүтцээ шинэчлэх, гадаад валютын дуудлага худалдааг зохион байгуулах үед хэвлэлийн бага хурал хийж холбогдох тайлбар, мэдээллийг хүргүүлж байсан билээ. Мөн Төв банкны үнэт цаасны арилжаа, валютын дуудлага худалдааны үр дүнг тухайн өдөрт нь цахим хуудсанд байршуулж байна. Монголбанк гадаад валютын арилжаагаа дуудлага худалдаа хэлбэрээр зохион байгуулах болсон нь өмнө нь мөрдөж байсан захиргааны хязгаарлалтыг бодвол илүү ил тод, гадаад валютын бодит эрэлт, нийлүүлэлтийг илүү үнэн зөв харуулах боломжийг бүрдүүлсэн. Инфляцийн хүлээлтийн судалгааг МУИС-ийн социологийн тэнхим болон МЕК судалгааны компанийтай хамтран анх удаа явууллаа. Уг судалгааг иргэд, аж ахуйн нэгжүүд болон эдийн засгийн шинжээчдийн дунд түүвэр судалгааны аргаар хийсэн бөгөөд судалгаанд 1046 иргэд, 392 аж ахуйн нэгжүүд, 13 эдийн засгийн шинжээчид оролцсон. Санал асуулгад инфляцийн хүлээлтийг тооцоолох болон Монголын нийгэм, эдийн засгийн талаарх асуултуудыг багтаасан.

Санал асуулгын нэгдсэн дүнгээр иргэдийн инфляцийн хүлээлт 2009 оны эцэст жилийн 19.7 хувь, аж ахуйн нэгж байгууллагуудын инфляцийн хүлээлт 2009 оны 3 дугаар сараас 2010 оны 3 дугаар сар хүртэл 14.2 хувь, шинжээчдийн инфляцийн хүлээлт мөн 2009 оны 3 дугаар сараас 2010 оны 3 дугаар сар хүртэл 19.7 хувь гарлаа. Инфляцийн хүлээлтийн судалгааны үр дүнг нэгтгэн үзвэл 2008 оны дунд үеэс өсч эхэлсэн үнийн өндөр өсөлтийн үр дагавар 2009 онд иргэд, аж ахуйн нэгж байгууллага, шинжээчдийн

дунд инфляцийн өндөр хүлээлтийг бий болгосныг харуулж байна. Түүнчлэн 2009 онд хөрөнгө оруулалт хийх боломж муу, бизнесийн орчин тааламжгүй, банк санхүүгийн байгууллагуудад хадгаламж төвлөрөх боломж багатай байхын зэрэгцээ үйлдвэрлэл багасч, худалдан авалт буурч эдийн засгийн өсөлт саарах, инфляцийн өндөр түвшин хадгалагдана гэсэн хүлээлт иргэд, аж ахуйн нэгжүүдийн дийлэнх хувьд байгаа нь судалгаанаас харагдаж байна.

3.2. Банкны салбарын ил тод, найдартай байдлыг хангах, хөрөнгө оруулагч, харилцагч нарын итгэлийг нэмэгдүүлэх, санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

Тагнуулын ерөнхий газар, Эрүүгийн цагдаагийн газартай мэдээлэл солилцож байна. Банкуудад Ази-номхон далайн мөнгө угаахтай тэмцэх байгууллага, Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагаас гаргасан гэмт хэргийн төрлийн судалгаануудыг тогтмол хүргүүлж байна. Эрүүгийн цагдаагийн газар, Улсын мөрдөн байцаах газраас Монгол Улсад гарч байгаа санхүүгийн гэмт хэргийн тоо, статистик, арга хэлбэрийн талаар лавлагaa авч, үйл ажиллагаандaa ашиглаж байна.

Дэлхийн Банк, Монголбанк хамтран Санхүүгийн зохицуулах хороо болон банк бус санхүүгийн байгууллагуудад зориулсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд мэдээлэх үүрэгтэй этгээдийн оролцоо” сэдэвт сургалт семинарыг 2009 оны 1 дүгээр сард зохион байгуулсан. Мөн хууль хяналтын байгууллагын ажилтнуудтай уулзалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа. НҮБ-ын Мансууруулах бодис, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх албаны терроризмоос урьдчилан сэргийлэх хэсгийн Улаанбаатар хотод зохион байгуулсан “Терроризмын эсрэг олон улсын хамтын ажиллагаа” сэдэвт сургалтанд идэвхтэй оролцов.

3.3. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажлыг идэвхжүүлэн энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг олон улсын байгууллага, бусад улсын ижил төрлийн албадтай хамтарч ажиллана.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкуудад хяналт шалгалт хийх журам батлуулан түүний дагуу банкуудад хяналт шалгалт хийж байгаагийн зэрэгцээ санхүүгийн бусад байгууллагаас тайлан авах талаар Санхүүгийн зохицуулах хороотой санал солилцож хэрэгжүүлэх арга замыг судлан, Тагнуулын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар зэрэг төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Санхүүгийн мэдээллийн алба нь Эгмонт бүлэгт элсэх шалгуурыг хангаж, 2009 оны 5 дугаар сард албан ёсоор элссэн. Ингэснээр гадаадын 110 орны Санхүүгийн мэдээллийн албадтай шууд харилцах, мэдээлэл солилцох бололцоотой болж гадаад харилцаагаа өргөжүүлэв.

Тагнуулын өрөнхий газар, Эрүүгийн цагдаагийн газар болон Гаалийн өрөнхий газартай хамтран ажиллах санамж бичиг, журам батлуулан мэдээлэл солилцож байна. Санхүүгийн мэдээллийн албаны дэргэдэх хамтын ажиллагааны зөвлөлийн хурлыг тогтмол хийдэг бөгөөд Гадаад харилцааны яамны төлөөллийг зөвлөлд нэмж оруулах шаардлагатай гэж үзсэний дагуу тус яамны төлөөллийг оруулах талаар Гадаад харилцааны сайдтай санал солилцож байна.

3.4. Монголбанкнаас олон нийт, зах зээлтэй харилцах харилцааг улам эрчимжүүлж, Төв банкны үйл ажиллагааны талаархи олон нийтийн боловсролыг дээшлүүлэх ажлыг үргэлжлүүлэн явуулна.

Банк санхүүгийн зуучлалын талаар олон нийтэд нэн ялангуяа хүүхэд залуучуудад анхан шатны мэдлэг олгох чиглэлээр ажлын хэсэг байгуулагдсан. Энэ ажлын хүрээнд эдийн засаг, банк санхүүгийн суурь ойлголтуудыг олон нийтэд ойлгомжтой, энгийнээр тайлбарласан товхимол хэвлүүлэхээр төлөвлөсөн бөгөөд арилжааны банкууд, банкны сургалтын төв, бусад холбогдох байгууллагуудтай хамтран мөнгө, төв банкны үйл ажиллагааны талаар ойлголт өгч, хөгжүүлэх зорилгоор гадаад орнуудын төв банкуудын ижил чиглэлийн үйл ажиллагаа, туршлагыг судалж байна. Монголбанкны цахим хуудас [/www.mongolbank.mn/-нд](http://www.mongolbank.mn) төв банкны үйл ажиллагаа, банк санхүүгийн зуучлал, мөнгөний бодлогын талаарх анхан шатны ойлголтуудыг тайлбарласан “олон нийтийн боловсрол” танин мэдэхүйн булан ажиллуулж байна.

3.5. Банкны мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагааг боловсронгуй болгож, төрийн мэдээллийн санд холбогдох мэдээллийг шуурхай дамжуулах нөхцлийг бүрдүүлнэ.

Энэхүү зорилтын хүрээнд Монголбанкинд ажлын хэсэг байгуулагдан ажиллаж буй бөгөөд Монголбанкинд ашиглагдаж буй мэдээллийн сангуудыг нэгдсэн стандартад оруулах, үйл ажиллагааг боловсронгуй, шуурхай болгох үүднээс шинээр мэдээллийн сангийн системүүдийг боловсруулах талаар шат дараалсан ажлууд хийгдэж байна. Тухайлбал: Зээлийн мэдээллийн сангийн системийг шинэчлэх ажил бүрэн хийгдэж дуусаад 2009 оны 6 дугаар сарын 15-ны өдөр ашиглалтанд ороод үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байна. Банкны системийг хамарсан Банкны тайлан бүртгэлийн нэгдсэн систем, Санхүүгийн мэдээллийн систем зэрэг системүүдийг шинээр боловсруулах ажил хийгдэж байна. Мөн Монголбанкны дотоод үйл ажиллагаатай холбоотой Гэрээний мэдээллийн сан, Дотоод аудитын мэдээллийн сан зэрэг системүүдийг шинээр боловсруулан ашиглаж байна.

Төрийн мэдээллийн санд холбогдох бэлтгэл ажлын хүрээнд Төрийн холбооны газар, Харилцаа холбооны зохицуулах хороо болон Бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог

бий болгох хөтөлбөрийн зөвлөх үйлчилгээний “Интерактив түншлэл” байгууллагатай хамтран ажиллаж байна.

3.6. Улсын Их Хурлаас Төв банкинд тавих хяналтыг тогтмолжуулж, Монголбанкны Хяналтын зөвлөлийн бие даасан байдал, эрх зүйн орчныг сайжруулна.

Монголбанкны үйл ажиллагаанд УИХ-аас тавих хяналтыг сайжруулах, Монголбанкны хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжийг олон нийтэд ил тод болгох чиглэлээр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн “30.3 Монголбанк санхүүгийн тайлангаа жил бүр Улсын Их Хуралд танилцуулна” гэснийг “30.3 Монголбанк санхүүгийн тайлангаа хөндлөнгийн аудитын санал, дүгнэлт болон Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжийн хамт жил бүр Улсын Их Хуралд танилцуулна” гэж өөрчлөлт оруулахаар хуулийн төсөлд тусгасан. Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулж, Засгийн газраар дамжуулан УИХ-д өргөн барьсан. Уг хууль батлагдсанаар Монголбанкны Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжийн биелэлтийг хянах эрх зүйн орчин бүрдэнэ. Мөн “Монголбанкны Хяналтын зөвлөлийн ажиллах журам”-д дээрх чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулах УИХ-ын тогтоолын төсөл бэлтгэж байна.

III. ТӨСЛИЙН ТООЦОО СУДАЛГАА

1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

1.1. Эдийн засгийн өсөлт

ДНБ-ий бодит өсөлт 2004-2007 онуудад дунджаар 9.2%, 2008 онд 8.9% байлаа. Энэ өсөлтөд худалдаа, тээвэр холбоо, бусад үйлчилгээний салбар болон бүтээгдэхүүний татварын цэвэр өсөлт голчлон нөлөөлсөн байна. 2008 онд барилгын салбарын үйлдвэрлэл 8.7% буурч, бусад салбарууд өссөн байна. Харьцуулах үнээр тооцсон ДНБ 2008 оны эхний хагас жилд 11.9% өсч байсан бол сүүлийн хагас жилд 6.5% өсч өсөлтийн хурд буурсан юм. Үүний шалтгаан нь 2008 оны 9 дүгээр сараас зэсийн үнэ буурсан, түүнээс уламжлан гадаад худалдаа, төсвийн алдагдал нэмэгдсэн, эдгээртэй зэрэгцэн олон улсын санхүүгийн хямрал бий болж гүнзгийрэн гадаадын хөрөнгө оруулалт буурсан зэрэг байлаа.

Хүснэгт 3.1. ДНБ салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр (тэрбум төгрөгөөр)

	2004	2005	2006	2007	2008*	2009*		
						I улирал	II улирал	I хагас жил
ДНБ	2,591.6	2,779.6	3,017.4	3,325.9	3,620.5	617.1	991.8	1,608.9
өсөлт, %	10.6	7.3	8.6	10.2	8.9	-4.2	0.7	-1.3
Хөдөө аж ахуй	549.4	608.3	654.1	757.5	795.5	43.9	317.2	361.1
өсөлт, %	15.8	10.7	7.5	15.8	5	3	3.2	3.2
Үүл уурхай	550.1	608.2	646.3	665.0	665.8	131.4	166.1	297.5
өсөлт, %	31.1	10.6	6.3	2.9	0.1	-6.5	2	-2
Боловсруулах	126.7	102.0	115.6	149.1	156.1	23.1	29.3	52.3
өсөлт, %	-3.7	-19.5	13.4	29	4.7	-17.4	-24.8	-21.7
Цахилгаан, эрчим хүч	79.6	80.0	83.6	89.9	95.8	29.8	20.2	50.0
өсөлт, %	3.8	0.5	4.5	7.5	6.6	3.9	-1.4	1.7
Барилга	50.9	58.8	61.8	67.1	61.2	3.1	6.9	10.0
өсөлт, %	-6.6	15.6	5.1	8.5	-8.7	-8.7	-55.1	-46.7
Худалдаа	221.4	227.0	261.8	279.4	333.9	48.0	39.6	87.6
өсөлт, %	-4.9	2.5	15.3	6.7	19.5	-13.9	-32.8	-23.6
Тээвэр, холбоо	252.2	309.1	346.4	438.6	524.3	118.8	131.8	250.6
өсөлт, %	8.1	22.5	12.1	26.6	19.5	9.6	-1.8	3.3
Бусад үйлчилгээ	453.1	474.4	464.4	469.9	518.7	149.1	149.2	298.3
өсөлт, %	0.4	4.7	-2.1	1.2	10.4	11.1	13.3	12.2
Бүтээгдэхүүний цэвэр татвар	308.2	311.7	383.4	409.5	469.1	69.9	131.5	201.4
өсөлт, %	14.9	1.2	23	6.8	14.6	-32.1	14.4	-7.5

*-урьдчилсан гүйцэтгэл

Эдийн засгийн өсөлт буурсаар 2009 оны 1 дүгээр улиралд -4.2% гарч эдийн засаг уналтын доод цэгтээ хүрч, оны эхний хагас жилийн дүнгээр -1.3% боллоо. Үүний дотор барилгын салбарын уналт -46.1% байна. Үүнд:

- ◆ Өмнөх жилүүдэд үл хөдлөх хөрөнгийн үнийн хурдан өсөлтийн улмаас барилгын салбарын хөрөнгө оруулалт, зээлийн хэмжээ хэт өссөн нь орон сууцны зах зээл дээр эрэлтээс давсан нийлүүлэлтийг бий болгосон;
- ◆ Хямралтай холбоотойгоор хэрэглэгчдийн худалдан авах чадвар эрс муудсан;
- ◆ Орон сууцны борлуулалт буурснаар зарим барилгын компаниуд өмнө нь авсан зээлээ эргэн төлөх боломжгүй болсон;
- ◆ “Зээлийн тасалдал”-ын улмаас банкнаас зээл аван үйлдвэрлэлээ үргэлжлүүлэх боломж хязгаарлагдмал болсон зэрэг нь сөргөөр нөлөөлөв.

1.2. Инфляци, түүний өөрчлөлтийн шалтгаан

Үндэсний статистикийн хороо (YCX)-ны мэдээгээр 2009 оны 8 дугаар сарын байдлаар Улаанбаатар хотын хэмжээнд тооцсон хэрэглээний үнийн индекс (ХҮИ) оны эхнээс 3.9%-аар өсч, өмнөх сартай харьцуулахад 0.6%-аар буурсан байна. Харин улсын хэмжээгээр тооцсон хэрэглээний үнийн индекс оны эхнээс 2.2% өсч, өмнөх сараас 0.6%-иар буурав. Жилийн инфляци Улаанбаатар хотын хэмжээнд -0.9%, улсын дүнгээр 0.6%-д хүрсэн нь оны эхнээс 23 нэгж хувиар тус тус буурчээ.

Улаанбаатар хотын жилийн инфляци буурч байсан хэдий ч хүнсний бараа, ундаа, усны үнэ эхний 4 сард өмнөх оны мөн үтэй харьцуулахад сард дунджаар 14.4%-аар өсч хоёр оронтой тоогоор илэрхийлэгдсэн хэвээр байв. Харин 5 дугаар сараас жилийн инфляци эрчтэй буурч нэг оронтойгоор хэмжигдэх болсон нь өргөн хэрэглээний зарим бүтээгдэхүүн (талх, гурил, будаа, мах, жимс, хүнсний ногоо)-ий үнэ буурч, хүнсний бүлгийн үнэ өмнөх оныхоос сард дунджаар 5%-иар буурсан нь голлон нөлөөлжээ. Тээвэр, орон сууц, ус, цахилгаан, түлш, хувцас, бөс бараа, гутал, боловсролын үйлчилгээ зэрэг бусад бүлгүүдийн үнийн өсөлт харьцангуй тогтвортой байв.

Жилийн инфляцийг 2009 оны 8 дугаар сарын дүнгээр бүтцээр нь задлан авч үзвэл хүнсний бараа, ундаа, усны үнэ 2.9 нэгж, орон сууц, ус, цахилгаан, түлшний үнэ 0.1 нэгж, тээврийн бүлгийн үнэ 0.6 нэгжээр тус тус буурч, хувцас, бөс бараа, гутлын үнэ 1.2 нэгжээр, бусад бүлгүүдийн үнэ 0.3-0.5 нэгжээр тус тус өссөн байна (Хүснэгт 3.2, 3.3).

Хүснэгт 3.2. Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс (8 дугаар сарын байдлаар)

Хувийн жин	Өөрчлөлт		
	2009-08 2008-08	2009-08 2008-12	
Хүнсний бараа, ундаа, ус	41.08	99.1	106
Согтууруулах ундаа, тамхи	2.26	122.4	121.5
Хувцас, бөс бараа, гутал	12.38	109.5	99.3
Орон сууц, ус, цахилгаан, түлш	13.4	99	95.6
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	4.3	108.9	106.6
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	1.62	115.4	110
Тээвэр	8.71	93.4	97.8
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.05	107.2	107.1
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.33	107.4	103.5
Боловсролын үйлчилгээ	4.15	109	109
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлч.	1.72	113.8	110.7
Бусад бараа үйлчилгээ	3	114.9	112.2
Ерөнхий индекс	100	99.1	103.9

Эх сурвалж: YCX, (Улаанбаатар хотын индекс)


Хүснэгт 3.3. Хэрэглээний зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт (өөрөөр заагаагүй бол жилийн өсөлт, хувиар)

Огноо	Барааны нэрс (Хэрэглээний сагсанд эзлэх хувийн жин), үнийн өсөлтийн хувь	Тайлбар
2008 III улирал	Шатахуун (8.7): 79.61%	Засгийн газраас шатахуун импортлогч компаниудад олгох татаас, НӨАТ-аас чөлөөлөхтэй холбоотой маргаан үүссэн, ОХУ-ын экспортын татвар нэмэгдсэн гэх тайлбарыг импортлогчид гаргасан. Үүнтэй зэрэгцээд тээврийн үнэ дунджаар 48.7%-иар өсөв.
	Орон сууц, ус, цахилгаан, түлш (13.4) : 29.41%	Улирлын шинж чанартай орон сууцны түрээсийн хөлс 26.9%, орон сууцны 1 м ² талбайн халаалтын хөлс 38.7%, 1 шуудай түлшний мод болон нүүрсний үнэ дунджаар 55% нэмэгдэв.
	Боловсролын үйлчилгээ (5.4): 37.6%	Эдийн засаг дахь инфляцийн түвшинтэй уялдуулан их, дээд сургуулиуд сургалтын төлбөрөө нэмэв.
2008 IV улирал	Хүнсний бараа, ундаа, ус (41.0): 24.45%	Улирлын нөлөөлөл болон махны нийлүүлэлтийн өсөлттэй холбоотойгоор мах, махан бүтээгдэхүүний үнэ буурсан (өмнөх улиралтай харьцуулахад үхрийн махны үнэ 20.4%, хонины махны үнэ 21.8%-иар буурав).
	Тээвэр (8.7): 33.8%	Атрын 3 дугаар аянтай холбоотой үр тариа, хүнсний ногооны тариалалтын хэмжээ нэмэгдэж, гурилын үндсэн түүхий эд болох улаан буудайн ахиу ургац хураалттай холбоотойгоор гурил, талхны үнэ өмнөх улиралтай харьцуулахад 7.5 хувь буурав. Дэлхийн зах зээл дээр түүхий нефтийн үнэ буурч байгаа болон ОХУ нь нефтийн бүтээгдэхүүнд ногдуулах экспортын татвараа бууруулсантай холбоотойгоор энэ улиралд шатахууны үнэ 25% буурав.

2009 I Улирал	Тээвэр (8.7): 27.23% Хүнсний бараа, ундаа, ус (42.2): 14.91%	Шатахууны үнэ эхний хоёр сарын байдлаар үргэлжлэн буурч, 3 дугаар сард эргэн өссөн. Улиралын дүнгээр бензиний үнэ 4%, дизелийн түлшний үнэ 6.25%, микроавтобусны билетийн үнэ 3.6%, хот доторх таксины хөлс 20.0% тус тус буурав. Мах, махан бүтээгдэхүүн дэд бүлгийн үнэ 10.0%, жимс жимсгэнийх 5.1%, сахар, жимсний чанамал, чихэр, шоколадных 10.3% тус тус өссөв.
2009 II Улирал	Мах, махан бүтээгдэхүүн (16.5): -15.12% Сүү, сүүн бүтээгдэхүүн (3.5): 6.8%	Улирлын нөлөөгөөр өмнөх улиралтай харьцуулахад хонины махны үнийн 16.3%, үхэр, адууны махны үнэ 10.6% тус тус өссөн нь голлох нөлөөг үзүүлэв. Мөн, сүү, сүүн бүтээгдэхүүний дэд бүлгийн дүн 10.9% буурав. Үүнд, задгай нэг литр сүүний үнэ 35% буурсан нь голлох нөлөөг үзүүлэв.
	Орон сууц, ус, цахилгаан, түлш (13.4): 11.68% Шатахуун (1.8): -21.24%	Халаалтын бус улиралд орон сууцны халуун усны төлбөр 50.0% өссөв. 1 шуудай нүүрсны үнэ 16.4%, 1 шуудай түлшний модны үнэ 12.1%-н үнийн бууралт зэргээс голлон нөлөөлөв. Автобензиний үнэ 22%, дизелийн түлшний үнэ 19.7%-иар буурав.
2009 III Улирал (8 дугаар сарын байдлаар)	Хүнсний бараа, ундаа, ус (42.2): -7.18% Тээвэр (8.71): -6.6% Боловсролын Үйлчилгээ (4.15): 9.0%	Мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 20.6%, сүү, сүүн бүтээгдэхүүнийх 14.7%-ийн бууралт нь голлох нөлөөг үзүүлэв. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад А-80 автобензиний үнэ 26.5%, А-92 автобензиний үнэ 22.8%, дизелийн түлшний үнэ 34.9%-иар тус тус буурав. Улсын их, дээд сургуулийн жилийн төлбөр 7.9%, хувийн их, дээд сургуулийн жилийн сургалтын төлбөр 10.3% өсчээ.


ҮСХ 2008 оноос инфляцийг Улаанбаатар хотын болон улсын хэмжээний ХҮИ-үүдийг ашиглан тооцоолдог болсон билээ. Инфляцийн судалгаа, шинжилгээг нилээд урт хугацааны динамик өгөгдлийг ашиглан гүйцэтгэдэг учир Монголбанкны тоон шинжилгээний дүгнэлтүүд Улаанбаатар хотын өгөгдөл дээр суурилдаг юм. Үүний учир Монголбанк ойрын жилүүдэд Улаанбаатарын ХҮИ-ийн ашиглан шинжилгээ хийж дүгнэлт гаргасан хэвээр байх болно. Эдгээрийг хооронд нь харьцуулж үзэхэд өөрчлөгдөх хандлага нь ижил боловч, хурд нь харилцан адилгүй байна. Тухайлбал, 2009 оны эхний 4 сард улсын хэмжээний ХҮИ Улаанбаатарынхаас хурдан өсч байсан бол 5 дугаар сараас хойш илүү хурдан буурчээ. Эхний 5 сард инфляци оны эхнээс улсын хэмжээгээр өсч бараг 6%-д хүрч байсан бол 6 дугаар сараас эхлэн буурч 8 дугаар сард 3.9%-д хүрээд байна (Зураг 3.1, 3.2).

*Зураг 3.1. Улсын ба Улаанбаатар хотын сарын инфляци/дефляци болон ХҮИ-н динамик
(2008 оны 12 дугаар сарыг суурь болгосноор)*




Эх сурвалж: YCX-ны 2009 оны 8 дугаар сарын мэдээ

Зураг 3.2. Улсын ба Улаанбаатар хотын хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлт



Энэ оны эхний 8 сард инфляци 3.9%-аар өссөний 64%-ийг хүнсний бараа, ундаа, ус, 13%-ийг согтууруулах ундаа, тамхи, 10%-ийг боловсролын үйлчилгээ, 9%-ийг бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнийн өсөлт тус тус бүрдүүлжээ. Харин орон сууц, ус, цахилгаан, түлшний үнэ 0.6 нэгж, тээврийн бүлгийн үнэ 0.2 нэгжээр, хувцас, бөс бараа, гутлын үнэ 0.1 нэгжээр тус тус буурсан нь бусад бүлгийн үнийн өсөлтийг оны эхнээс 22%-иар саармагжуулсан (Зураг 3.3).

Зураг 3.3. Улаанбаатар хотын хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлт, түүний бүтэц




Эх сурвалж: YCH-ны 2009 оны 8 дугаар сарын мэдээ, Монголбанкны тооцоолол

Инфляцийн хүлээлт, эрэлтийн хүчин зүйлсийг илүү бодитой илэрхийлэх, нийлүүлэлтийн огцом цочролоос ялгаж шинжлэх үднээс улирлын хэлбэлзэл ихтэй мах, сүү, хүнсний ногоо эсвэл түр зуурын нөлөөлөлд автан хэт их хэлбэлздэг нийт 29 төрлийн барааг хэрэглээний сагснаас хасч “суурь инфляци”-ийг тооцлоо. 2009 оны эхний 8 сарын байдлаар суурь инфляци оны эхнээс 3.1%, өмнөх оны мөн үеэс 4.9%-иар тус тус өссөн байна (Зураг 3.4). Үүнд хэрэглээний сагсны бүх бүлгүүдийн үнийн тогтвортой өсөлт жигд байдлаар нөлөөлсөн бөгөөд тэр дундаас тээвэр болон боловсролын үйчилгээний үнийн өсөлт нь харьцангуй өндөр нөлөөг үзүүлэв. Суурь инфляцийн 2009 оны эхний найман сарын хандлага инфляцийн ерөнхий хандлагаас

харьцангуй тогтвортой байна. Харин суурь инфляци болон Улаанбаатар хотын инфляцийн зөрүү 3 дугаар сараас эхлэн нэмэгдэж, 5 дугаар сарын байдлаар хамгийн их буюу 5%-д хүрсэн нь хүнсний бараа, ундаа, усны үнийн өсөлт энэ саруудад харьцангуй өндөр байсантай холбоотой байна.

Зураг 3.4. Суурь инфляци



Эх сурвалж: УСХ-ны 2009 оны 8 дугаар сарын мэдээ, Монголбанкны тооцоолол


1.3. Гадаад худалдаа

Гадаад худалдааны тэнцэл


Гадаад худалдааны алдагдал 2009 оны 8 дугаар сарын байдлаар 186.3 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 73.6 хувь буюу 519.8 сая ам.доллараар буурчээ. Экспортын гол нэрийн 10 бүтээгдэхүүний хилийн үнэ дунджаар 41.0 хувиар буурсан, мөнгөжөөгүй алтны экспорт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад биет хэмжээгээрээ 5.5 тонноор бага байгаа учраас экспорт 154.9 сая ам.доллараар буурчээ. Харин импортын нефтийн бүтээгдэхүүний дундаж үнэ 33.0 хувиар, хүнсний бүтээгдэхүүний дундаж үнэ 9.4 хувиар буурч, импортын бусад бараа бүтээгдэхүүний⁵ үнэ дунджаар 5.1 хувиар өссөн боловч импортын биет хэмжээ нь 41.6 хувиар багассан байна. Импортын хэмжээ буурсан учраас гадаад худалдааны алдагдал буурлаа.

⁵ Нийт импортоос нефтийн болон хүнсний бүтээгдэхүүнийг хассан дун.

Зураг 3.5. Гадаад худалдааны тэнцэл, сараар



Зураг 3.6. Монгол Улсын гадаад худалдаа, сараар /сая ам.доллар/



Бараа бүтээгдэхүүний худалдаа

Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт 2009 оны эхний 8 сарын байдлаар⁶ 2351.8 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 42.2 хувиар буурчээ. Экспорт 1082.7 сая, импорт 1269.1 сая ам.доллар, гадаад худалдааны тэнцэл 186.3 сая ам.долларын алдагдалтай гарчээ. Худалдааны тэнцлийн алдагдал өнгөрсөн оны

⁶ Монголбанк урсгал дансны тэнцлийг улирлын дүнгээр нэгтгэдэг боловч гадаад худалдааны гүйцэтгэлийг сарын дунгээр нэгтгэдэг тул 2009 оны 8 дугаар сарын гүйцэтгэлийг үзүүлэв.

мөн үетэй харьцуулахад 73.6 хувиар буурсан байна. Нийт 1082.7 сая ам.долларын экспортын 99.4 хувь нь валютын төлбөртэй байжээ

Хүснэгт 3.4. Экспортын гол нэрийн бүтээгдэхүүнүүд

Нэр төрөл	Эхний 8 сар			Жилийн өөрчлөлт (2008.8- 2009.8; мянян. ам. доллар)	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлтийн нөлөө (мян. ам. доллар)		
	2009				Тоо /ти, баррель/	Мөнгөн дун /мянган ам.доллар/			
	Тоо /ти, баррель/	Мөнгөн дун /мянган ам.доллар/	Экспор- тод эзлэх хувийн жин						
1 Зэсийн баяжмал	384,536.9	272,825.4	25.2%	-330,802.8	-161.9 ↓	-254.0	-330,548.76 ↓		
2 Боловсруулаагүй болон хагас боловсруулсан алт	6.8	186,126.4	17.2%	-160,266.9	-5.5 ↓	-154,945.0	-5,321.86 ↓		
3 Чулуун нүүрс	3,938,043.5	178,222.5	16.5%	64,349.5	1,442,495.2 ↑	65,821.7	-1,472.21 ↓		
4 Цайрын хүдэр ба баяжмал	95,449.3	67,872.1	6.3%	-52,512.8	-4,272.5 ↓	-5,157.8	-47,354.97 ↓		
5 Боловсруулаагүй нефть	995,697.6	52,173.9	4.8%	-17,842.3	340,078.7 ↑	36,318.4	-54,160.68 ↓		
6 Ямааны самнасан ноолуур	1,037.7	43,221.1	4.0%	-13,817.8	164.0 ↑	10,710.2	-24,527.98 ↓		
7 Төмрийн хүдэр ба баяжмал	911,664.3	44,264.9	4.1%	-8,403.7	292,285.9 ↓	24,854.4	-33,258.12 ↓		
8 Молибдений хүдэр ба баяжмал	4,272.8	25,794.3	2.4%	-22,526.7	2,182.8 ↑	50,466.7	-72,993.40 ↓		
9 Ямааны угаасан ноолуур	3,417.8	87,493.6	8.1%	21,975.9	1,789.5 ↑	72,008.1	-50,032.16 ↓		
10 Жонш, лейцит, нефелин ба нефелинит сиенит	172,124.6	27,187.9	2.5%	-10,173.5	-53,673.8 ↓	-8,881.0	-1,292.44 ↓		
Бусад		97,549.3	9.0%	-69,765.6	↓				
Эхний 8 сарын байдлаар нийт экспорт	1,082,731.4	100.0%		-599,786.7	↓				

Манай улсын нийт экспортын 90 орчим хувийг арван нэр төрлийн эрдсийн болон ХАА-н түүхий эдийн бүтээгдэхүүн бүрдүүлж байна (Хүснэгт 3.4). Экспорт 599.8 сая ам.доллар буюу 35.6 хувиар буурчээ. Экспортын дийлэнх бүтээгдэхүүний бодит хэмжээ өссөн тул экспорт 245.9 сая ам.доллараар өсөх байсан ч алтны экспортын биет хэмжээ буурснаас 154.9 сая ам.доллараар, дэлхийн зах зээл дэх эрдэс түүхий эдийн үнийн уналтаас шалтгаалан 621.0 сая ам.доллараар тус тус буурчээ. Алтны экспортын биет хэмжээ буурсан нь экспортын биет хэмжээ буурахад гол нөлөө үзүүлэв.

Нийт 1269.1 сая ам.долларын импортын 87.9 хувь нь валютын төлбөртэй байв. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад импорт 1119.5 сая ам.доллараар буюу 46.9 хувиар буурсан байна (Хүснэгт 3.5). Импортын 60 орчим хувийг бүрдүүлдэг 136 орчим нэр төрлийн бараа бүтээгдэхүүний импорт 572.6 сая ам.доллараар буюу 40.9 хувиар буурчээ. Үүний 70.7 хувь нь бодит тоо хэмжээний бууралтаас, 29.3 хувь нь зах зээлийн үнийн бууралтаас шалтгаалжээ.

Хүснэгт 3.5. Импорт, гол нэрийн бүтээгдэхүүний ангиллаар (мян. ам.доллар)

Нэр төрөл	Эхний 8 сар		Нийт өөрчлөлт	Тоо хэмжээний өөрчлөлтийн нөлөө	Үнийн өөрчлөлтийн нөлөө			
	2009							
	Мөнгөн дүн	Импортод эзлэх хувийн жин						
1	Нефтийн бүтээгдэхүүн	285,412.4	22.5%	-292,467.9	-101,710.4 ↓			
2	Хүнд механизм, тоног төхөөрөмж сэлбэг хэрэгсэл	165,719.8	13.1%	-111,551.9	-95,925.7 ↓			
3	Хүнсний бүтээгдэхүүн	102,003.7	8.0%	-28,000.3	-15,819.6 ↓			
4	Тээврийн хэрэгсэл	122,810.4	9.7%	-99,255.6	-156,337.7 ↓			
5	Оффисын болон гэр ахуйн тавилга, хэрэгсэл	46,439.9	3.7%	-21,195.6	-15,978.5 ↓			
6	Төмөр хийц, металл бүтээгдэхүүн	28,945.1	2.3%	3,458.1	13,326.1 ↑			
7	Эм болон хими биологийн бүтээгдэхүүн, бордоо	20,910.4	1.6%	-8,179.5	-9,043.0 ↓			
8	Төрөл бүрийн даавуу	827.4	0.1%	-2,712.9	-2,552.3 ↓			
9	Бусад гол нэрийн бүтээгдэхүүн	53,826.0	4.2%	-12,705.7	-20,863.2 ↓			
Бусад		442,184.6	34.8%	-546,878.6				
Эхний 8 сарын байдлаар нийт импорт		1,269,079.7	100.0%	-1,119,489.9				

Хүснэгтээс үзэхэд төмөр хийц, металл бүтээгдэхүүнийг эс тооцвол импортын гол нэрийн бүтээгдэхүүн ангилал тус бүрээр буурсан байна. Үүнд нефтийн болон хүнсний бүтээгдэхүүнээс бусад бүтээгдэхүүний биет хэмжээ буурсан нь зонхицж байна.

1.4. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн хөдөлгөөн, гадаад төлбөр тооцоо

Төгрөгийн ханшийн хөдөлгөөн

Манай улсын экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээлд унаж, гадаад худалдааны алдагдал нэмэгдсэн, гадаад валютын орох урсгал багасч, гарах урсгал давамгайлсаар валютын эрэлт эрс өссөн, улсын төсөв, төлбөрийн тэнцлийн

алдагдал нэмэгдсэн үед ам.доллартай харьцах төгрөгийн ханш 2009 оны эхний улирлыг дуусталх хугацаанд сулрах хандлагатай, нийгмийн сэтгэлзүй төгрөгийн ханш суларна гэсэн хүлээлттэй байсан. Эдгээрийн үр дагавраар долларжилтын түвшин өсч, 2008 оны сүүлийн улирлаас 2009 оны эхний улиралд гадаад валютаар олгосон зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувь 33.5%-иас 36%-д, гадаад валютын хадгаламжийн нийт хадгаламжид эзлэх хувь 30.6%-иас 36.6%-д тус тус хүрч огцом өссөн юм. Түүнчлэн гадаад валютын зохиомол эрэлт нэмэгдсэн нь валютын зах тогтвортгүйжихэд нөлөөлж байв. Ханшийн хүлээлт өөрчлөгдсөний уршгаар ханш цаашид үргэлжлэн сулрах нь иргэдийн худалдан авах чадвар, бодит орлогыг бууруулах, банкны системийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх, инфляцийн дарамтыг нэмэгдүүлэх эрсдэлийг дагуулж байсан.

2008 оны 11 дүгээр сараас огцом бөгөөд үргэлжлэн суларсан төгрөгийн ханш 3 дугаар сарын гурав дахь долоо хоногт хамгийн оргил түвшиндээ хүрч⁷, 4 дүгээр сарын хоёр дахь долоо хоногоос эхлэн 1420-ийн түвшинд тогтвортожоод байна. 2009 оны 2 дугаар сард Монголбанкны албан ханш, банкуудын арилжааны ханш хоорондын зөрүү 97.32, Монголбанкны албан ханш, валютын албан бус захын ханш хоорондын зөрүү 160.47 болж тус тус өсөөд байсан бол 5 дугаар сарын 1-нээс эхлэн 8 дугаар сарыг дуусталх хугацаанд дунджаар 0.41 төгрөг, 2.04 төгрөг болж тус тус буураад байна. Төгрөгийн ханшийн хөдөлгөөнийг дараах хүчин зүйлсээр тайлбарлаж болох юм. Үүнд:

◆ *Төлбөрийн тэнцэл*

Төлбөрийн тэнцлийн алдагдал 2008 оны эхний турван улирлын дунджаар 52.6 сая ам.доллар байсан бол 2008 оны дөрөвдүгээр улирал, энэ оны нэгдүгээр улиралд тус тус 222.0, 129.8 сая ам.долларт хүрч огцом өссөн нь төгрөгийн ханш сулрахад нөлөөлсөн эдийн засгийн суурь хүчин зүйл байв. Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2009 оны хоёрдугаар улиралд 136.6 сая ам.долларын ашигтай гарсан нь төгрөгийн ханш буцаж чангараа, улмаар тогтвортжиход эерэгээр нөлөөлсөн байна.

◆ *Гадаад валютын урсгал*

2008 оны сүүлээр гадаад валютын урсгалд гарах урсгал зонхилсон нь валютын орох урсгал багассанаас шалтгаалсан байна. Энэ нь эрдэс түүхий эдийн үнэ буурсан, эдийн засгийн хямралаас шалтгаалан ажилчдын гүйвуулга, гадаадын шууд хөрөнгө оруулалтын өсөлт буурсан, Засгийн газрын шугамаар гадаадаас орж ирж буй зээлийн эргэн төлөлт ашиглалтаас давсан зэрэгтэй холбоотой. Энэ оны 1 дүгээр сард гадаад валютын цэвэр урсгал 23.0 сая ам.долларын сөрөг үлдэгдэлтэй байв. Гэвч 2009 оны 2 дугаар улирлаас эхлэн банкуудын гадаад гүйлгээгээр валютын орох урсгал давамгайлж, оны эхний 8 сарын байдлаар нийт гадаад

⁷ Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкны албан ханш 3 дугаар сарын 19-ний өдөр 1590.70, банкуудын дундаж ханш 3 дугаар сарын 17-ны өдөр 1663.71, албан бус захын дундаж ханш 3 дугаар сарын 13-ны өдөр 1730.00 түвшинд тус тус хүрч суларсан.

валютын цэвэр урсгалын ам.доллараар илэрхийлэгдсэн дүн 143 сая, ам.долларын цэвэр урсгал 67.7 сая, юанийн цэвэр урсгалын ам.доллараар илэрхийлэгдсэн дүн 130.8 сая ам.долларын эерэг үлдэгдэлтэй байгаа нь төгрөгийн ханш тогтворжиход нөлөөлсөн чухал хүчин зүйл юм. Юанийн нийлүүлэлт ихсэж, ам.долларын эрэлтийн зарим хэсгийг нөхөж байгаа нь төгрөгийн ханш тогтворжиход тодорхой хэмжээгээр нөлөөлжээ. Гадаад валютын орох урсгал ийнхүү нэмэгдсэн нь зэсийн үнэ 3000 ам.доллар/тонн-ын түвшнээс 6000 ам.доллар/тонн түвшинд хүрч өссөн, ажилчдын гүйвуулга энэ оны эхний хоёр улирлын дунджаар 22.8 сая ам.доллар болж 2008 оны сүүлийн хоёр улирлын дунджаас 51 хувиар өссөн, гадаад зээлийн ашиглалт цэвэр дүнгээрээ 2008 оны сүүлийн улиралд -8.3 сая ам.доллар байсан бол энэ оны 1, 2 дугаар улиралд 17.4 сая ам.доллар, 71.6 сая ам.доллар болж тус тус өссөнтэй холбоотой байна.

- ◆ Валютын зохицуулалт

Аж ахуйн нэгж байгууллага, иргэд нь үнийн санал, тариф, зар сурталчилгааг гадаад валютаар илэрхийлж, төлбөр тооцоог гүйцэтгэдэг, Эрдэнэт зэрэг УҮГ-үүд төсөвтэй хийх тооцоог ам.доллараар гүйцэтгэдэг, татвар, гаалийн хураамж, шимтгэл ам.доллараар илэрхийлэгдэж төлөгддөг нь гадаад валютын зохиомол эрэлт, долларжилтын түвшинг нэмэгдүүлж байв. Түүнчлэн Гаалийн ерөнхий газрын эмхэтгэдэг “Гадаад худалдааны тайлан” алдаатай гарсны улмаас 2008 оны эхний хагас жилийн гадаад худалдааны тэнцлийн алдагдал огцом өссөн мэтээр олон нийтэд мэдээлэгдсэн нь зах зээлийн хүлээлтийг өөрчилсөн юм. Эдгээр нь ханшийн суралтад нөлөөлж байсан хүчин зүйлс мөн.

- ◆ Монголбанкнаас хэрэгжүүлсэн арга хэмжээ

Гадаад валютын дотоодын захыг тогтворжуулах, төгрөгийн ханш зах зээлийн нөхцлөөр бодитой, чөлөөтэй тогтох байх зарчмыг хангах, Монголбанкны албан ханш, банкуудын арилжааны ханш, валютын албан бус захын ханш хоорондын зөрүүг бууруулан тогтворжуулах зорилгоор Монголбанк гадаад валютын арилжааг зөвхөн дуудлага худалдаагаар хийхээр шийдвэрлэж анхны дуудлага худалдааг 3 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан. Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах ханш дуудлага худалдаа эхлэх өдөр 1576 төгрөг 75 мөнгө болж оны эхнээс 24 хувиар суларч байсан бол дуудлага худалдааны үр дүнд Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2009 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар 1415 төгрөг 20 мөнгө болсон нь 3 дугаар сарын 24-ний өдрийн түвшингээс 10.3%-иар, 2009 оны хамгийн өндөр түвшингээс 11.0%-иар тус тус чангартсан байна. Энэхүү арга хэмжээг авч хэрэгжүүлснээр гадаад валютын дотоодын захад байсан Монголбанкны өдөр тутмын оролцоог халж, Төв банк зөвхөн шаардлагатай үед хөндлөнгөөс оролцох тогтолцоонд шилжсэн бөгөөд төгрөгийн ханш бодитой, чөлөөтэй тогтох байх зарчмыг ханган, ханшийг тогтворжуулахад бодитой нөлөөлсөн.

- ◆ Хүлээлт


Оны эхний улирлыг дуусталх хугацаанд төгрөгийн ханш сулрах хүлээлт нийгмийн сэтгэлзүйд маш хүчтэй байсан билээ. Гэвч Монголбанкнаас хэрэгжүүлсэн дээрх арга хэмжээний үр дүнд энэ оны 2 дугаар улиралд төгрөгийн ханш чангартсан нь зах зээл дэх ханшийн хүлээлтийг эрс өөрчилж, төгрөгийн ханш тогтворжиход нөлөөлсөн. Цаашилбал, зах зээлд төгрөгийн ханш чангараах хүлээлт бий болсон.

Дээр дурьдсан хүчин зүйлсийн нөлөөгөөр төгрөгийн ханш энэ оны 4 дүгээр сараас эхлэн зургаан сарын турш тогтворгүй байна. Төгрөгийн ханшийн хөдөлгөөнийг (зураг 3.7-д), ханш хоорондын зөрүүг (зураг 3.8-д) тус тус үзүүлэв.

Зураг 3.7. Ам.доллартай харьцах төгрөгийн ханшийн хөдөлгөөн



Зураг 3.8. Ам.доллартай харьцах төгрөгийн ханш хоорондын зөрүүнүүд



Гадаад төлбөр тооцоо

Монголбанк гадаад гүйлгээний тайланг валют тус бүрээр 2008 оны 1 дүгээр сараас эхлэн нэгтгэж эхэлснээр гадаад төлбөр тооцооны урсгалыг валют тус бүрээр нь тооцон гаргаж байна. Ийнхүү хэдий хэмжээний валют банкны системээр дамжин эдийн засагт орж, гарч байгааг мэдсэнээр ханшийн талаарх бодлогын шийдвэр гаргалтад энэхүү мэдээлэл нь чухал ач холбогдолтой болсон юм.

Гадаад гүйлгээний мэдээгээр энэ оны эхний хагас жилийн байдлаар нийт валютын орох урсгал 1494.5 сая ам.доллар, гарах урсгал 1450.2 сая ам.доллар, цэвэр урсгал 44.3 сая ам.доллар гарав. Ам.долларын урсгал энэ оны 1, 2 дугаар саруудад буурсан ч 3-6 дугаар саруудад нэмэгдэж, эхний хагас жилийн байдлаар орох урсгал 1037.0 сая, гарах урсгал 1018.8 сая, цэвэр урсгал 18.2 сая ам.долларын эерэг үлдэгдэлтэй байна. Энэ нь төгрөгийн ханшийн тогтворжилтод эерэгээр нөлөөлжээ.

Хүснэгт 3.6. Гадаад төлбөр тооцооны зарим үзүүлэлтүүд, 2009 оны эхний хагас жилийн байдлаар (мянган ам.доллараар)

	Гүйлгээний эргэлтэнд эзлэх % (Эхний хагас жилээр)		2008			2009		
	2008	2009	Дүн	1-р улирал	2-р улирал	Дүн	1-р улирал	2-р улирал
USD	74%	70%	231.6	50.1	181.5	18.2	(26.6)	44.8
CNY	17%	19%	218.5	55.6	162.9	75.4	-	75.4
EUR	4%	5%	(41.2)	(17.9)	(23.3)	(13.2)	0.1	(13.2)
JPY	3%	1%	13.6	18.5	(4.8)	(13.7)	(7.9)	(5.8)
Бусад	2%	5%	(61.5)	(15.7)	(45.8)	(22.3)	7.2	(29.5)
Нийт	100%	100%	361.0	90.4	270.6	44.3	(27.3)	71.6

Эх сурвалж: Монголбанк

Гадаад төлбөр тооцоог үндсэн валютуудаар, гүйлгээний төрлөөр авч үзвэл ам.доллараар хийгдэж буй гадаад худалдаа 39.0 сая ам.долларын алдагдалтай байхад юаниар хийгдэж буй гадаад худалдаа 105.5 сая ам.долларын ашигтай байна.

1.5. Гадаад эдийн засгийн орчин

Гадаад худалдааны түнш орнуудын инфляци, эдийн засгийн төлөв байдал

Манай улсын БНХАУ-тай хийсэн худалдаа 2009 оны эхний 8 сарын байдлаар экспортын худалдааны 74.3%, импортын худалдааны 24.9%-ийг эзлэв. Энэ оны хоёрдугаар улиралд БНХАУ-ын дотоодын нийт бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 7.9%-иар өссөн байна. Дэлхийн банкны 6 дугаар сард гаргасан тайлангаас үзвэл 2009 онд БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 7.2%, 2010 онд 7.7% байх төлөвтэй байна. Дэлхийн эдийн засгийн хямрал БНХАУ-д нөлөөлсөн боловч сангийн болон мөнгөний

хүчтэй тэлэх бодлогын үр дүнд эдийн засгийн өсөлт дахин буурсангүй. Сангийн тэлэх бодлого буюу дэд бүтцийн “Дөрвөн их наяд юань” төслийн тусламжтайгаар зээл олголт болон Засгийн газрын хөрөнгө оруулалт огцом өсчээ. 2 дугаар улиралд экспортын худалдаа нэлээд бага байгаа нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж, харин импортын худалдаа эргэн өссөн нь түүхий эдийн импорттой холбоотой байна.

БНХАУ-д энэ оны эхний зургаан сард үнийн түвшин буурсан ч эдийн засгийн эрэлт болон түүхий эдийн үнэ өсч буйтай холбогдуулан 2009 оны инфляци 2% байх таамаглалыг засгийн газар нь гаргажээ. Хятадын Төв Банк үнийн түвшин энэ оны 3 дугаар улиралд доод цэгтээ хүрч 4 дүгээр улиралд эргэн өсөх магадлалтай гэж мэдэгдсэн байна. Энэ оны 7 дугаар сарын үнийн түвшин өмнөх оны мөн үеэс 1.8%-иар буурсан байгаа нь 1999 оноос хойши хамгийн доод түвшин нь юм. ЖП Морган (JPMorgan Chase & Co) болон Дойче банк (Deutsche Bank)-ны эдийн засагчдын таамаглалаар бол оны сүүлийн хагаст БНХАУ-ын инфляци 2% хүртлээ өсөх боломжгүй бөгөөд жилийн инфляци сөрөг 0.5% гарах таамаг дэвшүүлжээ.

2009 оны эхний 5 сард ОХУ-ын эдийн засгийн өсөлт сөрөг 10.2% гарсан нь хөрөнгө оруулалт болон экспортын худалдааны эрэлт буурч, зээл олголт чангарсан болон хэрэглээ багассантай холбоотой. Иймээс энэ оны 6 дугаар сард Дэлхийн банк ОХУ-ын эдийн засаг 2009 онд 7.6%-иар хумигдана гэлээ. Харин 2010 онд дэлхийн эдийн засгийн өсөлтийг даган ОХУ-ын эдийн засаг ч сэргэх төлөвтэй байна. 2010 онд эдийн засгийн өсөлт сөрөг 0.5%-иас эерэг 0.5%-ийн хооронд байх таамаглалыг ОХУ-ын засгийн газар гаргаж байгаа бол Дэлхийн банкны таамаглалаар 2.5%, Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын (OECD) таамаглалаар 3.5% хүрнэ гэв. Энэхүү эерэг хүлээлт нь түүхий эдийн үнэ буурахгүй байх, засгийн газрын эдийн засгийн хөшүүргүүд үр дүнтэй байх гэсэн хоёр нөхцөлд үндэслэжээ.


2008 онд ОХУ-ын инфляци 13.3% байсан бол 2009 онд энэ нь буурч 8%, 2010 онд 6.5% хүрнэ хэмээн Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын эдийн засагчид таамаглаж байна. Харин Дэлхийн банкныхан ОХУ-ын инфляцийг 2009 онд 11-13%-д хүрнэ гэжээ. Газрын тосны үнэ өндөр хэвээр байх тохиолдолд төсвийн алдагдал ДНБ-ий 7.2% хүрэх төлөвтэй байна ОХУ-ын эдийн засаг ирэх онд сэргэх хүлээлт байгаа ч эдийн засгийн хямралаас үүдсэн нийгмийн үр дагавар бүрмөсөн арилаагүй байна. Ядуурлын түвшин хямралын өмнөх 13.2%-иас энэ жил 17.4%, ажилгүйдэл 13% хүрэх таамаглалыг Дэлхийн банк гаргав.

Экспортын болон импортын гол нэрийн бараа, бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн тойм

Түүхий нефтийн үнэ сүүлийн улиралд маш хэлбэлзэлтэй байгаа ба цаашид ч энэ хэлбэлзэл үргэлжлэх төлөвтэй байна. 2009 оны 4 дүгээр улиралд нэг баррель нефтийн үнэ 70 ам.доллар орчимд байх бөгөөд эхний улиралтай харьцуулахад 27 орчим ам.доллараар өндөр байхаар байна. 2010 онд нэг баррель нефтийн үнэ дунджаар


72 ам.доллар байх прогнозтой байна. Хэдийгээр ОPEC-ийн гишүүн орнуудаас нийлүүлэлтээ нэмэгдүүлж байгаа хэдий ч дэлхийн зах зээл дээрх түүхий нефтийн үнэ аажмаар өссөн хэвээр байна. Эдийн засгийн хямралаас шалтгаалан буурсан түүхий нефтийн эрэлттэй холбоотойгоор ОPEC-ийн гишүүн орнуудаас нийлүүлэлтээ бага зэрэг бууруулаад байсан юм. Дэлхийн эдийн засаг сэргэхийн хэрээр нефтийн болон хүнсний бүтээгдэхүүний үнэ өсч магадгүй гэсэн таамаглал ч байна.

Зураг 3.9. Түүхий эдийн үнийн индекс (2008 он = 100)



Эх сурвалж: OVBС


Зураг 3.10. Дэлхийн зах зээл дээрх алтны үнийн таамаг (улирлаар)



Эх сурвалж: Bloomberg цахим хуудас

Энэ оны 2 дугаар улиралд алтны нэг унцын үнэ 876-960 ам долларын хооронд хэлбэлзэж байсан бөгөөд дунджаар 930 ам.доллар орчим байв. 2008 оны 3 дугаар улирлын байдлаар нэг унц алтны үнэ дунджаар 829.9 ам.долларт байсан ч 10 дугаар сар гарснаас хойш харьцангуй хэлбэлзэлтэй байсан. Bloomberg-ийн тооцоолж байгаагаар алтны үнэ 2010 оны эхний хагаст хамгийн өндөр байх бөгөөд цаашид аажмаар буурах хандлагатай байна.

Зураг 3.11. Дэлхийн зах зээл дээрх зэсийн үнийн таамаг (улирлаар)



Зэсийн үнэ 2009 оны 2 дугаар улиралд хүлээгдэж байсан түвшнээс харьцангуй өндөр гарсан нь зэсийн гол хэрэглэгч БНХАУ болон Энэтхэгийн эдийн засаг сайжрах хандлага байгаатай холбоотой юм. Тухайлбал, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2009 оны эхний хагаст жилийн 7.1% гарч өмнөх улирлаас 1 нэгжээр өссөн байна. 2009 оны эхний улиралд зэсийн үнийн таамаглалыг 4109 ам.доллар байхаар таамаглаж байсан бол гүйцэтгэлээр 4980 ам.доллар гарсан байна. Харин энэ удаагийн Bloomberg -ийн зэсийн таамаглал нь өмнөх таамаглалаас харьцангуй өндрөөр буюу 4900-6040 ам.долларын хооронд байхаар байна.

2. ИНФЛЯЦИ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН 2009-2011 ОНЫ ЧИГ ХАНДЛАГА

2.1 Инфляци, эдийн засгийн өсөлтийн 2009-2011 оны чиг хандлага

Инфляци, эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

Монголбанк бусад төв банкуудын адил инфляци, эдийн засгийн өсөлтийн төсөөллийг олон загварын дундаж таамаглалыг ашиглан тооцоолж байна⁸. Эдгээр загвар нь онол, арга зүйн хувьд харилцан адилгүй, өөр өөрийн давуу ба сул талтай. Тухайлбал, онол, арга зүйн хувьд SARIMA загвар богино, SIMOM хэлбэрийн загвар дунд, SVAR загвар урт хугацааны таамаглалыг илүү сайн гаргадаг. Монголбанк мөнгөний бодлогын шийдвэр гаргалтанд эдгээр загваруудын тус бүрийн болон жигнэсэн дундаж таамаглалыг ашиглаж байна. Энэ хэсэгт 2009 оны 9 дүгээр сарын байдлаар хийгдсэн жигнэсэн дундаж таамаглал, түүний итгэх интервалыг танилцуулав. Суурь таамаглалыг гаргахдаа төсөв, мөнгөний бодлогод гарах өөрчлөлт, гадаад зах зээлийн тодорхой бус байдалтай холбоотой бий болж болзошгүй нөлөөг инфляци, эдийн засгийн өсөлтийн интервал таамаглалд оруулан тооцлоо.

Инфляцийн төсөөлөл


Мөнгөний бодлогын арга хэмжээ, бараа үйлчилгээний нийлүүлэлтийн талын хүчин зүйл, макро эдийн засгийн гадаад орчны ээрэг нөлөөллийн дүнд инфляци 2009 оны эхний 9 сарын турш буурч, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тогтворжлоо. Үүний зэрэгцээ жилийн инфляци нь ХҮИ-ийн 12 сарын өөрчлөлтөөр тооцогддог тул өмнөх оны мөн үеүдэд инфляци өндөр байсан нь 2009 оны жилийн инфляци бага гарахад нөлөөлсөн. 2009 оны 7 дугаар сараас шатахууны үнэ өссөн ч нийт эрэлт буурсан тул инфляцийн “хоёрдахь үеийн нөлөө” үүсэхгүй байх боломж олголоо. Инфляци 8 дугаар сард -0.9% байна.

Гадаад болон дотоод эдийн засгийн тодорхой бус байдал өндөр хэвээр байгаа өнөөгийн нөхцөлд хийгдсэн цэгэн таамаглалаар жилийн инфляци 2009 оны эхний 3 улирлын туршид буурсан хандлагатай, оны эцэст 3.4 хувийн голчтой, 60 болон 90 хувийн магадлалын итгэх түвшинд харгалзан 2.3-5.2, 1.0-6.8 хувийн хооронд байхаар байна. Харин 2010 оны 2 дугаар улирлын эцэст 7.2 хувийн голчтой, 90 хувийн магадлалын итгэх түвшинд 4.2-12.5 хувийн хооронд, 2010 оны эцэст 7.9 хувийн голчтой, 4.1-14.9 хувийн хооронд, 2011 оны эцэст 6.3 хувийн голчтой 0.2-16.7 хувийн хооронд гарахаар байна. Гэхдээ инфляцийн цэгэн таамаглал нь дээр дурьдсан 3 загвараар тодорхойлогдож байгаа тул загварын таамаглалын алдаа, загварт ашиглагдаж буй гадаад болон дотоод зах зээлийн талаарх мэдээллийн экзоген хүчин

⁸ Эдгээр тооцоолтыг хувьсагчийн загвар (SARIMA), макро хувьсагчдын динамик хамаарлын бүтцийн загвар (SVAR), макро эдийн засгийн бүтцийн хураангуй загвар (SIMOM) гэсэн загваруудын ашиглаж байна.

зүйлсийн тодорхой бус байдлыг өөртөө агуулж байна. Иймд инфляцийн цэгэн таамаглал, түүний итгэх интервалыг загварын таамаглалын алдаа болон магадлалын тархалтыг ашиглан тооцож үзүүлэв (Зураг 3.12).

Зураг 3.12. Жилийн инфляцийн цэгэн таамаглал, түүний итгэх интервал⁹



Хүнс, шатахууны үнэ дэлхийн эдийн засаг сэргэхэд даган өсөх, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш өнгөрсөн хугацаанд хүчтэй суларсан, эдийн засгийн уналтыг зогсооход чиглэсэн арга хэмжээнээс тус тус шалтгаалан мөнгөний нийлүүлэлт нэмэгдэж, хэрэглээний өсөлт гарч дунд хугацаанд инфляци өсөх дарамт өндөр буюу цэгэн таамаглалаас өндөр гарах боломжтой байна.

2009 оны 9-10 дугаар сард хүнсний ногоо, гурилын үнэ буурч, махны үнэ тогтвортой байх төлөвтэй байгаа, мөн цалин тогтвортой, зээлийн тасалдал үргэлжилж, эдийн засгийн өсөлт сөрөг түвшинд хэвээр байгаа зэрэг инфляци цаашид богино хугацаанд өсөхгүй байх нөхцлүүд байсаар байна. Гэхдээ эдийн засгийн сэргэлт, төсвийн тэлэлттэй холбоотойгоор нийт эрэлт өсөх, түүнтэй давхцан дэлхийн зах зээл дээрх шатахуун, хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт нь “хоёрдахь үеийн нөлөө”-гөөр дамжин 2010 оны эхнээс инфляцийг нэмэгдүүлэхээр байна. Одоо байгаа мэдээлэлд үндэслэлсэн таамаглалаар эдийн засгийн сэргэлт, 2009 оны 3 дугаар улирлын шатахууны үнийн өсөлт, түүний хоёр дахь үеийн нөлөөгөөр бий болох цэвэр инфляцийн¹⁰ өсөлтийн улмаас 2010 оны 1 дүгээр улиралд жилийн инфляци 4.0% болохоор байна. Харин 2-р улиралд өмнөх оны үнийн уналт тооцоноос хасагдаж, инфляцийн инерци үргэлжлэн нөлөө үзүүлэх учраас инфляци өмнөхөөсөө бараг 2 дахин өсч 7.2% болно.

⁹ Таамаглалын эхний утгаас эхлэн салбарлан өнгөөр ялгарч гарсан хэсэг нь тодорхой бус байдлын зэрэг буюу тухайн магадлалын түвшинд инфляци ямар утгын хооронд гарахаар байгааг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл, цэгэн таамаглалын дээд, доод мужид ижил өнгөөр дүрслэгдсэн хэсэг нь ижил магадлалын түвшинд инфляцийн илрэх мужийг илэрхийлнэ.

¹⁰ ХҮИ-ээс хүнс, шатахууны бүлгийг хассан дэд бүлгээс тооцсон инфляци.

Харин 2010 оны сүүлийн хагаст инфляци өсөхөд шатахуун, хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт, эдийн засгийн сэргэлтээс үүдэлтэй цэвэр инфляци нөлөө үзүүлнэ. Тухайлбал, гадаад эдийн засгийн нөхцөл, тэр дундаа дэлхийн зах зээл дээрх алт, зэсийн үнэ болон БНХАУ-ын эдийн засгийн өсөлтөөс шалтгаалан ДНБ потенциал хэмжээгээ давж, эдийн засгийн өсөлт нэмэгдэн оны эцэст инфляци 5.4 хувьд хүрэхээр байна. Үүний зэрэгцээ дэлхийн эдийн засаг сэргэхийн хэрээр шатахуун, хүнсний бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэх, “мөнгө хэвлэх” хэлбэрээр эдийн засгаа сэргээж буй орнуудад инфляци өсөх төлөв байгаа нь манай орны импортын үнийг өсгөх магадлалтай.

2011 онд инфляци тогтвожиж 6 орчим хувьд хадгалагдахаар байгаа учир төсөв, мөнгөний мөчлөг сөрсөн уялдаатай бодлого явуулахаар төлөвлөж байгаа, Оюу толгой төсөлтэй холбоотой хөрөнгийн дотогшлох урсгал нэмэгдэж төгрөгийн гадаад валюттай харьцах ханш чангараах, дэлхийн зах зээл дээрх нефтийн үнэ тогтвожих зэрэг суурь таамаглуудыг авч тооцоолсон болно. Гэвч бодит байдал дээрх тодорхой бус байдал өндөр хэвээр байгаа тул 2011 оны инфляцийн интервал таамаглал харьцангуй өргөн тооцогдов.

Эцэст нь, таамаглалын хугацаа (2009-2011 он)-нд инфляцийн чиг хандлага ямар байх нь олон нийтийн инфляци болон санхүүгийн зах зээл, макро эдийн засгийн тогтвортой байдлын талаарх хүлээлт ямар байхаас ихээхэн хамаарна. Иймд макро эдийн засгийн бодлого, түүний хүрэх үр дүн, хэрэгжилтийн талаарх мэдээллийг олон нийтэд шуурхай хүргэх нь эдийн засгийн бодлогын зорилтоо хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй.


2.2. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

Дэлхийн эдийн засгийн хямрал голчлон нөлөөлснөөр манай эдийн засаг өсөлт 2008 оны 4 дүгээр улирлаас саарч, 2009 оны 1 дүгээр улиралд -4.2 хувь, эхний хагас жилийн байдлаар -1.3 хувь болж уналттай гарав. Энэ хямралын нөлөө аж үйлдвэрийн салбарт илүү хүндээр туслаа. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 2009 оны эхний хагас жилийн байдлаар 7.9 хувиар, үүний дотор уул уурхай, олборлох салбар 1.6 хувиар, боловсруулах салбар 22.6 хувиар тус тус буурав. Эдийн засгийн уналтыг даган ажил идэвхтэй хайж байгаа ажилгүйчүүдийн тоо 2009 оны эхний хагаст өмнөх оны мөн үеээс 22.3 хувиар, шинээр бүртгүүлсэн ажилгүй хүний тоо өмнөх оны мөн үеийнхээс 39.8 хувиар өсчээ. Шинээр бүртгүүлсэн ажилгүйчүүдийн 78 хувь нь ажлаасаа халагдсан хүмүүс байна. Үйлдвэрлэл буурч, ажилгүйдэл өсөхийн хэрээр аж ахуйн нэгж, өрх гэрийн орлого багасч, хэрэглээ хумигдсан нь дотоодын нийт эрэлтийг буурахад хүргэж байна.

Эдийн засгийн өсөлтийг энэ 9 дүгээр сарын мэдээлэлд үндэслэн таамаглавал 2009 оны эцэст 1.5 хувь, 2010 оны 2 дугаар улирлын эцэст 5.3 хувь, 2010 оны эцэст 5.4

хувь, 2011 оны 2 дугаар улиралд 5.9 хувь, 2011 оны эцэст 8.4 хувь байх дүн гарч байна¹¹. Загварын таамаглалын алдаа, экзоген хүчин зүйлсийн тодорхой бус байдлыг тусгасан эдийн засгийн өсөлтийн интервал таамаглалыг Зураг 3.13-т үзүүлэв. Эдгээр таамаглалуудын интервал нь оны эцэст 1.5 хувийн голчтой, 60 болон 90 хувийн магадлалын итгэх түвшинд харгалзан 0.8-2.9, 0-4.1 хувь, 2010 оны 2 дугаар улирлын эцэст 5.3 хувийн голчтой, 90 хувийн магадлалын итгэх түвшинд 3.0-9.2 хувийн хооронд, 2010 оны эцэст 5.4 хувийн голчтой 2.3-10.6 хувийн хооронд, 2011 оны эцэст 8.4 хувийн голчтой 3.7-15.2 хувийн хооронд гарахаар байна. Оюу толгой, Таван толгой төслийн урьдчилгаа төлбөр болон Мянганы сорилтын сангийн хөрөнгө орж ирэх тохиолдолд эдийн засгийн потенциаль нэмэгдэх тул эдийн засгийн бодит өсөлт цэгэн таамаглалаас өндөр гарч 2010 онд Засгийн газрын зорилтот түвшин болох 7.4 хувьд хүрэх боломжтой юм.

Зураг 3.13. ДНБ-ий жилийн өсөлтийн цэгэн таамаглал, түүний итгэх интервал



Эдийн засаг 2009 оны 3 дугаар улирлаас сэргэж, 2010 оны эхний улирлаас эхлэн өсөх нөхцөл бүрдүүлэх зарим хүчин зүйлсийг тооцоонд авсан. Тухайлбал, 2008 оны сүүл 2009 оны эхээр төгрөгийн ам.доллартай харьцах ханш суларснаар гадаад худалдааны эргэлт буурсан хэдий ч худалдааны алдагдал өмнөх оноос үлэмж багассан, Засгийн газраас хөдөө аж ахуй, алтны салбарыг дэмжих чиглэлээр санхүүжилт олгосон зэрэг нь богино хугацаанд эдийн засгийн өсөлт бий болоход эерэгээр нөлөөлнө. Харин дэлхийн эдийн засгийн сэргэлтийг даган зэсийн үнэ цаашид өсөх, инфляцийг нам түвшинд тогтвортой байлгах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, дотоодын эрэлтийг өсгөх бодлогын арга хэмжээ, Оюу толгой төсөл хэрэгжиж эхлэх зэрэг

¹¹ Энд тооцоолсон ДНБ өсөлт нь өмнөх 4 улирлын үйлдвэрлэлийн нийлүүлэлтүүдийг ашиглан тооцсон үзүүлэлт юм. Жишээ нь: 2010 оны 2-р улирлын эцэст байх ДНБ-ны өсөлт нь 2009 оны 3-р улирлаас эхлэн улирал бүрийн үйлдвэрлэлийг нийтуулж тооцсон үйлдвэрлэл 2009 оны 2-р улирлын эцэст мөн ижил аргаар тооцсон үйлдвэрлэлээс хэдэн хувь өссөнийг илтгэнэ.

нь дунд хугацаанд эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ. Гэхдээ Засгийн газар, Монголбанкнаас авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй дээрх арга хэмжээний мөнгөний агрегат, хэрэглээний өсөлт болон инфляцид үзүүлэх нөлөөг урьдчилан тооцоход эдийн засгийн тодорхой бус байдал өндөртэй одоогийн орчин хүндрэл учруулж байна.

Дээрх таамаглалаас үзэхэд эдийн засаг сэргэж, ирэх жилүүдэд өсөлттэй байх хэдий ч зээлийн тасалдал үргэлжилж, зээлийн чанар муудаж байгаагаас санхүүгийн зуучлалын үзүүлэлт өсөхгүй байх, хэрэглээний багасалтаас улбаалсан нийт эрэлт буурч эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад сөргөөр нөлөөлөх хүчин зүйлс байсаар байна.

2.3. Инфляци, эдийн засгийн өсөлтийн төсөөллийн тодорхой бус байдал

Эдийн засгийн өсөлт, инфляцийн таамаглалд нөлөөлөх макро эдийн засгийн бодлогын шийдвэр, дэлхийн эдийн засгийн хямрал, олон нийтийн хүлээлтийн өөрчлөлтийн тодорхой бус байдлыг тус бүрд нь товч тайлбарлай:

Эдийн засгийн сэргэлтэд зээлийн тасалдал нөлөөлөх тодорхой бус байдал: Банкууд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдээ хангахын тулд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх эсвэл зээлээ хязгаарлах гэсэн сонголттой байна. Өөрийн хөрөнгөө богино хугацаанд нэмэгдүүлэх боломжгүй, чанаргүй зээл хурдан өсч байгаа тул зээлийн өсөлтийг хязгаарлаж байна. Нийтдээ зээлийн эргэн төлөлт муудсаны улмаас зээлийн эрсдэлийн үнэлгээ нэмэгдсэн тул хүү өсч, зээлдэгчдэд тавих шаардлага чангачээ. Ийнхүү зээлийн шаардлагууд чангартсан нь иргэдийн хэрэглээ болон орон сууц худалдан авах чадварыг бууруулсан бол зээлийн нийлүүлэлт буурч, үнэ нь өссөн учраас компаниуд үйл ажиллагаагаа өргөжүүлэх сонирхолгүй болжээ. Банкны алдагдлыг зогсоох, өрхийн хэрэглээг урамшуулах бодлогын арга хэмжээ төлөвлөгджэх байгаа ч хэрэгжих хэлбэр хугацааны хувьд тодорхой бус байна.

Өрх санхүүд гарах өөрчлөлтийн тодорхой бус байдал: Иргэд эдийн засаг унаж, ажилгүйдэл өсч, хөдөлмөрийн орлого буурсан, ирээдүйд ажилгүй болох эсвэл орлого буурах хүлээлт бий болсонтой холбоотой хуримтлалаа нэмэгдүүлэх, хэмнэлттэй амьдрахыг зорьж байгаа бөгөөд энэ нь сүүлийн улирлуудад буураад байгаа өрхийн хэрэглээ цаашид нэмэгдэхгүй байх нөхцөл бүрдүүлэх болно. Иймд зээл авах идэвхийг сэргээх, хэрэглээг дэмжих бодлогыг нэгэн зэрэг хэрэгжүүлэх нь эдийн засгийг богино хугацаанд идэвхжүүлэх гол нөхцөл гэж үзэж байна. Одоогоор улсын дундаж цалингийн хөтөч үзүүлэлт болох төсвийн байгууллагын цалин өсөх тухай мэдээлэл байхгүй байгаа, ажил эрхлэлт богино хугацаанд нэмэгдэх боломж хомс байгаа зэргээс үзэхэд өрхийн хэрэглээ цаашид хэрхэн өөрчлөгдөх нь тодорхой бус байна.

Гадаад эдийн засгийн эрэлт Монголын эдийн засгийн өсөлтөнд хэр хурдан нөлөөлөхтэй холбоотой тодорхой бус байдал: Бидний тооцоонд зэс, алт, нефть, хүнсний зарим

барааны олон улсын зах зээлийн үнэ тусгагдаж, Монгол Улсын экспортын эрэлт, худалдааны нөхцлийн нөлөөг оруулсан. Дэлхийн эдийн засгийн сэргэлт түргэсч гадаад эрэлт дотоод эрэлтээс илүү хурдан нэмэгдэж, цэвэр экспортыг өsnө гэж тооцсон. Харин нефть, хүнсний зарим бүтээгдэхүүний үнэ хурдан нэмэгдэж инфляци өсөх дарамт үүсгэх шаардлагатай байна. Оюу толгойн төсөл хэрэгжсэнээр гадаадын шууд хөрөнгө оруулалт, санхүүгийн хөрөнгийн дотогшлох урсгал нэмэгдэх тул валютын ханш чангерах, эдийн засгийн өсөлт сайжрах боломжийг бүрдүүлэхээр байна. Гэхдээ эдгээр үйл явдал хугацааны хувьд хэзээ хэрэгжих, гадаад зах зээлийн таатай орчныг үр ашигтай, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах түвшинд ашиглаж чадах эсэх, үүний тулд төсөв, мөнгөний уялдаатай бодлогыг хэр амжилттай хэрэгжүүлэх вэ? гэдэг нь тодорхой бус байна.

Нийт эрэлтийн сэргэлт инфляцийг өсгөх тодорхой бус байдал: Эдийн засгийн өсөлт саарч, үйлдвэрлэл потенциал түвшнээс буурч, эдийн засаг дахь бодит мөнгөний зөрүү сөрөг болсон учраас инфляци эрэлтийн хучин зүйлсээр өдөөгдөхгүй байна. Эдийн засгийг сэргээх макро эдийн засгийн бодлогын үр дүн нийт эрэлтийг хэт хүчтэй тэлэхээс бусад нөхцөлд инфляци өсөх дарамт үүсэхгүй байх боломжтой байна.

Импортын барааны үнийн өсөлт инфляци өсгөх тодорхой бус байдал: Энэ оны эхний 3 улирлын туршид дэлхийн зах зээл дээрх импортын бүтээгдэхүүний үнэ буурсан, дотоод эрэлт сайнгүй байсан нь импортын бүтээгдэхүүний дотоодын зах зээл дээрх үнэ өсөхгүй байхад нөлөөлөв. Ойрын үед дэлхийн эдийн засаг сэргэж, дэлхийн зах зээл дээрх бараа, бүтээгдэхүүний үнэ өсч байгаа нь импортын эцсийн бүтээгдэхүүн, импортын түүхий эд, завсрын бүтээгдэхүүн хэрэглэдэг дотоодын компанийн эцсийн бүтээгдэхүүний үнэ өсөхөд хүргэхээр байна.

Инфляцийн хүлээлттэй холбоотой тодорхой бус байдал: Төгрөгийн ам.доллартай харьцах ханш сулрах, шатахууны үнэ нэмэгдэх нь инфляци өсөх хүлээлт үүсч макро эдийн засгийн нөхцөл хэвийн байхад үнэ өсөх дарамт бий болгох гол хучин зүйлс болж байна.


Засгийн газар “Эх орны хишиг” тараасны үр дагаврын тодорхой бус байдал: УИХ-ын 2008 оны сонгуулийн амлалт болох “Эх орны хишиг”, “Эрдэнийн хувь”-ийг хэзээнээс эхлэн ямар хэмжээтэй олгох нь тодорхой бус хэвээр байна. Хэрвээ 2009 оны 4 дүгээр улиралд иргэн бүрт 50-100.0 мянган төгрөг олгох тохиолдолд нийт эрэлт буурч буй өнөө үед инфляцийн дарамт багатайгаар бодит эдийн засагт шингэж, эдийн засгийн сэргэлтэнд эерэгээр нөлөөлөх боломжтой. Харин цаашид үргэлжлүүлэн бэлэн мөнгө гаргавал асар их сөрөг нөлөө дагуулах дүр зурагтай байна.

3. МӨНГӨНИЙ БОДЛОГО


3.1. Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2009 оны 8 дугаар сарын байдлаар 2564.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.5 хувиар буурсан боловч, оны эхнээс 13.0 хувиар өслөө. M2 мөнгөний бүрэлдэхүүн хэсгүүд болох M1 мөнгө, бараг мөнгөний өсөлт буурсантай холбоотойг M2 мөнгөний жилийн өсөлтийн хувь 2007 оны 12 дугаар сараас буурсаар өнгөрсөн оны эцэст хамгийн доод түвшиндээ буюу -5.5 хувьд хүрсэн. Банкны системээс мөнгөн хөрөнгө гадагшилж, зээлийн өсөлт зогссондоо шалтгаалан төгрөгийн хадгаламж, гадаад валютын харилцах, хадгаламж өнгөрсөн оны сүүлийн хагаст буурсан юм.

Зураг 3.14. Мөнгөний нийлүүлэлт, түүний бүрэлдэхүүн хэсэг



Зураг 3.15. Мөнгөний нийлүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн жилийн өөрчлөлт



Зээлийн өрийн үлдэгдэл. Банкны системийн зээлийн өрийн нийт үлдэгдэл 2009 оны 8 дугаар сарын байдлаар 2588.8 тэрбум төгрөгт хүрч оны эхнээс 2.9 хувиар буурлаа. Зээлийн жилийн өсөлтийн хувь 2007 оны 10 дугаар сараас эхлэн буурсаар 2009 оны эхний хагас жилийн байдлаар 4.7 хувьд хүрээд байна. Зээлийн хэмжээ буурсан хэдий ч 2009 оны 6 дугаар сараас эхлэн өсөх хандлагатай боллоо. Өмнөх жилүүдийн зээлийн өсөлт тогтвортой бус, хэт хурдацтай байсан нь чанаргүй зээлийн хэмжээ 13.7 хувьд хүрэхэд нөлөөлөв. Эдийн засгийн мөчлөг дагасан, хэт тэлэх макро эдийн засгийн бодлогод банкны салбар хамгийн ихээр нэрвэгддэг зүй тогтол Монгол Улсын хувьд ч ийнхүү давтагдаж байна.

Бараг мөнгө. Бараг мөнгө 2008 оны сүүлийн хагаст 348.9 тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч энэ оны эхнээс эргэн өсч 344.2 тэрбум төгрөг буюу 16.5 хувиар нэмэгдлээ. Энэхүү өсөлтийн 45.9 хувь нь гадаад валютын харилцах, хадгаламжийн, 37.5 хувь нь төгрөгийн хадгаламжийн өсөлт, 16.5 хувь нь ханшийн суларсантай холбоотой өсөлт байна.

Зураг 3.16. Бараг мөнгө, түүний бүрэлдэхүүн хэсэг



Гадаад болон дотоод цэвэр актив. Гадаад худалдааны урсгал тэнцлийн алдагдлыг санхүүжүүлэх, капиталын гадагшлах, банкны системийн өглөгийн гадаад валют руу хөрвөх зэрэг эрэлтийг санхүүжүүлснээр гадаад цэвэр актив өнгөрсөн 2008 оны сүүлийн хагаст огцом буурсан. Үүний дүнд мөнгөний нийлүүлэлт ихээхэн буураад байв. Гадаад цэвэр актив 2009 оны 2 дугаар сар хүртэл буурч, 442.2 сая ам.доллар хүрээд эргэж өссөөр 8 дугаар сарын байдлаар 822.1 сая ам.доллар боллоо. 2009 оны 3 дугаар сарын байдлаар 504.1 сая ам.доллар болж буурсан Төв банкны гадаад валютын цэвэр албан нөөц 8 дугаар сарын байдлаар 827.6 сая ам.доллар болж 2009 оны 3 дугаар сараас 64.2 хувиар өсөөд байна.

Банкны системийн дотоод цэвэр актив 8 дугаар сарын байдлаар 1389.2 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 6.2 хувиар, оны эхэнтэй харьцуулахад 15.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь Засгийн газрын цэвэр зээл, зээлийн өрийн үлдэгдлийн буурснаас шалтгаалжээ.

Зураг 3.17. Мөнгөний нийлүүлэлтийн актив талын бүтэц




M1 мөнгө. *M1* мөнгө 2009 оны 8 дугаар сарын байдлаар 597.1 тэрбум төгрөг болж оны эхнээс 7.8 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 7.0 хувиар буураад байна. Банкнаас гадуурх мөнгөний хэмжээ тогтвортой байна. Харин төгрөгийн харилцах дансдын үлдэгдэл өнгөрсөн оны 8 дугаар сараас эхлэн буурсан нь *M1* мөнгөний хэмжээг бууруулав.

Зураг 3.18. M1 мөнгө, түүний бүрэлдэхүүн хэсэг



Нөөц мөнгө. Нөөц мөнгө 2009 оны 8 дугаар сарын байдлаар 695.0 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 31.4 хувиар, оны эхнээс 9.7 хувиар өсөөд байна¹². Нөөц мөнгөний бүрэлдэхүүн хэсэг болох гүйлгээнд байгаа мөнгөний хэмжээ тогтвортой байна. Банкуудын Төв банкин дахь харилцах, хадгаламж өссөнөөр нөөц мөнгө өсөв. Эдийн засгийн бодит секторын өсөлт нь бэлэн мөнгөний эрэлтийг бууруулж байна. Гүйлгээнд байгаа мөнгө 8 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 2.9 хувиар, оны эхнээс 5.7 хувиар буурч, 384.1 тэрбум төгрөгт боллоо. Монголбанкны зүгээс банкуудын зээл олголтыг нэмэгдүүлэх зорилгоор банк хоорондын захын илүүдэл нөөцийг өсгөх бодлого баримталсаны үр дүнд, хөрөнгийн гадагшлах урсгал зогсонтой холбоотой банкуудын Төв банк дахь нөөц нэмэгдэж, 8 дугаар сарын байдлаар 311.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 177.6 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 84.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 3.19. Мөнгөний нийлүүлэлт, түүний бүрэлдэхүүн хэсэг




Мөнгөний үзүүлэлтүүдийн төлөвлөлт. Монголбанк зээлийн тасалдлыг зогсох бодлого баримталснаар 2010 оны 2 дугаар улирлаас зээлийн өрийн үлдэгдлийн бууралтыг зогсоож, 2010, 2011, 2012 онуудад зээлийн өрийн үлдэгдлийг жилд 12.8%, 14.1%, 17.1%-аар тус тус өсгөх нөхцөл бүрдүүлж ажиллахаар төлөвлөж байна. Ингэснээр мөнгөний нийлүүлэлт 2010 онд 24.0%, 2011 онд 21.8%, 2012 онд 20.2% өсөх юм. Мөнгөний нийлүүлэлтийн энэхүү өсөлтийг хангахын тулд нөөц мөнгийг 2010, 2011 онуудад жилд дунджаар 15.0 хувийн өсөлттэй байхаар, 2012 онд 18.0 хувийн өсөлттэй байхаар төлөвлөлөө. Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг бэхжүүлж, тодорхой бус байдлыг бууруулснаар мөнгөний үргжүүлэгч өсч 2012 оны эцэст 4.1 болж, 2009 оны 2 дугаар улирлын түвшнээс 0.9 нэгжээр нэмэгдэх юм. Мөнгөний үргжүүлэгч


¹² Нөөц мөнгөний өөрчлөлтийг валютын ханшны өөрчлөлтөөр цэвэрлэж тооцвол өнгөрсөн оны мөн үеэс 30.4 хувиар, оны эхнээс 6.5 хувиар өссөн байна.

өсч, зээл олголт, зээлийн өрийн үлдэгдэл нэмэгдсэнээр банкны систем дэх нийт харилцах, хадгаламжийн хэмжээ 2010 оны эцэст ойролцоогоор 25.4%, 2011 оны эцэст 23.7%, 2012 оны эцэст 20.2%-ийн өсөлттэй байхаар байна.

Зураг 3.20. Мөнгөний үзүүлэлтүүдийн таамаглал



Зураг 3.21. Мөнгөний үзүүлэлтүүдийн жилийн өөрчлөлтийн таамаглал



3.2 Зээлийн хүү.


Энэ оны 7 сарын байдлаар банкуудын төгрөгийн зээлийн жилийн дундаж хүү 21.8 хувь, валютын зээлийн жилийн дундаж хүү 17.9 хувь байлаа.

Xүснэгт 3.7. Зээлийн жилийн дундаж нэрлэсэн хүү

	2005	2006	2007	2008	2009*
Төгрөгийн зээлийн хүү	30.6	26.9	21.8	20.6	21.8
Валютын зээлийн хүү	16.5	16	14.2	15.4	17.9

(*) – 2009 оны 7 дугаар сарын байдалаар

Төгрөгийн зээлийн хүү 2005 оноос 2007 оны эцэс хүртэл ерөнхийдөө буурах төлөвтэй байсан ч инфляцийг даган өсч хүүний түвшин 21 хувь орчимд тогтвортых байдалтай байна. Мөн хугацаанд валютын зээлийн нэрлэсэн хүү нэлээд тогтвортой 14-16 орчим хувь байсан ч 2008 оноос эхлэн өсөх төлөв ажиглагдаж байна. Жилийн инфляцийн 6 сарын шаталсан дунджийг төгрөгийн болон валютын зээлийн нэрлэсэн хүүтэй харьцуулан дор харуулав.

Зураг 3.22. Зээлийн хүү болон инфляци

2007 оны сүүлээр жилийн инфляци 10 хувийг давахтай зэрэгцэн зээлийн хүүний буурах хандлага өөрчлөгдөж эхэлсэн байна. Нэрлэсэн хүүгийн түвшингээс инфляцийг хасч тооцдог бодит хүү төгрөгийн зээлийн хүүний хувьд нэлээд хугацааны турш сөрөг утгатай байсан. Ялангуяа, 2008 оны 2 дугаар хагасаас эхлэн 2009 оны эхний улирал хүртэл инфляци хэт хурдацтай өсч байснаас шалтгаалан зээлийн бодит хүүний түвшин сөрөг утгатай байв. Энэхүү байдал нь зээлдэгчдэд ашигтай мэт харагдаж байгаа боловч угтаа харилцах, хадгаламжинд хөрөнгөө байршуулсан харилцагчдад хүндээр тусан, улмаар банк санхүүгийн системийн үйл ажиллагааг доголдуулж, санхүүгийн зуучлалыг тасалдуулах эрсдэлийг үүсгэн банкны хямралын хөрсийг бэлтгэсэн билээ.

Харилцах, хадгаламжинд хөрөнгөө байршуулсан иргэд, аж ахуйн нэгжүүд хүүний болон ханшийн өөрчлөлтөд хэт мэдрэмтгий болсноор санхүүгийн захын тогтвортой байдал алдагдах эрсдэл бодитой болсон юм.

Зураг 3.23. Төгрөгийн зээлийн хүү



Ер нь шилжилтийн үе эхэлснээс хойш Монгол Улсын хадгаламж, зээлийн хүү Төв болон Зүүн Европ, Балтын 3 улс, ТУХН-ийн гишүүн орнууд болон Азийн зарим хөгжиж буй улс орнуудтай харьцуулахад хавьгүй өндөр түвшинд байна. Инфляци 2006-2007 онд нэг оронтой тоогоор илэрхийлэгдэж байсан ч зээлийн хүү дорвitoй буухгүй хэд хэдэн хүчин зүйлтэй холбоотой. Үүнд:


- ◆ Банкуудын эх үүсвэр талын хүүг харилцагчид хадгаламж зээлийн хоршоо (ХЗХ)-дын хүйтэй харьцуулах болов. ХЗХ-нууд нэг үе хяналт шалгалтаас гадуур оршиж өндөр хүү амлан хязгаарлалтгүй эрсдэлд орох боломжтой байв. Ийм нөхцөлд банкуудын хүүгээр өрсөлдөх стратеги ажиллахгүй болсон билээ.
- ◆ Хөрөнгийн зах зээлийн өнөөдрийн дорой байдал эрсдэлээс айхгүй өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалт хийж чаддаг этгээдүүдийн хэрэгцээг хангаж чадахгүй байна. Их хэмжээний хадгаламж эзэмшигч этгээдүүд банкуудын хадгаламжийн хүүг нэмэгдүүлэх хэлцлүүдийг анхлан хийж байна. Хадгаламжийн дүн том, олон банкууд хоорондоо өрсөлдөн хэлцлийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүйд хүрч байна.
- ◆ ХЗХ-д дампуурч иргэд хадгаламжийн үйлчилгээг хүүгээр нь сонгох нь багаслаа. Инфляци хурдацтай нэмэгдэж, төгрөгийн харьцангуй өгөөж ихээхэн тогтвортгүй өөрчлөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор хадгаламжийн хүү дахин өслөө.

Өмнөх тайлбарууд бүгд хадгаламжийн хүүтэй холбоотой байна. Учир нь аль ч орны банк эх үүсвэрийн зардал дээр зээлдүүлэх хүүгийн суурийг тооцдог билээ. Тийм учраас банкуудын тоог цөөрүүлж хадгаламжийн төлөөх өрсөлдөөнийг багасгах нь зээлийн хүүг бууруулах нэг үндсэн нөхцөл болоод байна. Хадгаламжийн хүүн дээр нэмэгдэх зүйлс нь үйл ажиллагааны зардал, эрсдэлийн зардал, хэвийн ашиг юм. Сүүлийн 10 жилийн туршид эрсдэлийн зардал буурч байсан нь зээлийн хүү буурах үндсэн нөхцөл болж байсан. Энэ талаарх судалгааг Монголбанкны цахим хуудаснаас үзэж болно. Мөн манай улсын банкуудын үйл ажиллагаа нь Азийн бус нутгийн орнуудын банкуудынхтай ижил бөгөөд хүү бууруулах, зээлийн хугацаа сунгах бодлогын шийдвэрүүд нь бусад орнуудтай бас адил байх тухай судалгааг Зүүн өмнөд Азийн төв банкуудын холбооны цахим хуудаснаас үзэж болно. Үүнээс гадна манай онцлог бол зах зээлийн харилцааны соёл хэвшээгүй явдал юм. Тухайлбал, зээл эргэн төлөгдөхөөргүй нөхцөлд барьцаа хөрөнгийг зарж борлуулах асуудал шүүхээр маш шуурхай шийдвэрлэгддэг байх ёстой. Гэтэл энэ хугацаа Зүүн Европод 2 хүртэл жил, Монгол Улсад 5 хүртэл жил сунжирдаг байна. Түүнчлэн зээлийн мэдээллийн сан, зээлийн түүх бүрдүүлэх соёл төдийлөн төлөвшөөгүй байгаа нь эрсдэлийг, улмаар зээлийн хүү өндөр байхад хүргэж байна.

3.3. Мөнгөний зах

Мөнгөний бодлогын арга хэмжээнүүдийг тогтмол авч хэрэгжүүлсний дүнд банкуудын илүүдэл нөөцийн хэмжээ өсч, зарим нааштай үр дагавар гарав. Тухайлбал, 2008 оны 2 дугаар улирлын эцэст -16.4 тэрбум төгрөг байсан илүүдэл нөөцийн хэмжээ 2009 оны 8 дугаар сарын байдлаар 59.2 тэрбум төгрөг (Зураг 3.24) болж өссөн бол заавал байлгах нөөцийн хэмжээ 80.7 тэрбум болсон байна. Жил бүрийн хаврын саруудад зээлийн эрэлт өсдөгөөс шалтгаалан банкуудын илүүдэл нөөц буурдаг бөгөөд 2009 оны 3, 4, 5 дугаар саруудад ч банкуудын илүүдэл нөөцийн хэмжээ харьцангуй буурсан. Нөөц эргэн өсч сүүлийн 3 жилийн хамгийн өндөр түвшинд хүрээнд байна. Манай санхүүгийн зах зээл хөгжөөгүй учир банк өөрийн илүүдэл хөрөнгийг зээл болгон гаргах, валют болгож хадгалах, ТБҮЦ-нд байршуулахаас өөр аргагүй байна. Өнөөдрийн нөхцлөөр банкны илүүдэл нөөцийг зээл болгон гаргах нь хэт эрсдэлтэй байгаа учир Төв банк бодлогын хүүгээ бууруулж үнэт цаасныхаа хэмжээг багасган хэт шахвал банкууд доллар худалдаж авахаас өөр сонголтгүй болж байна.


Зураг 3.24. Банкуудын илүүдэл нөөцийн хэмжээ (сарын дундаж)



Банк хоорондын захын арилжааны хэмжээ. Банкуудын илүүдэл нөөцийн хэмжээ буурах тусам банк хоорондын захын арилжааны тоо өсдөг. Банк хоорондын захаас эх үүсвэр татахад хадгаламж, зээлийн бүтээгдэхүүнээс гадна репо санхүүжилт болон ТБҮЦ-ны хоёрдогч захын арилжааг ашиглаж байна. 2009 оны эхний хагас жилийн байдлаар банкууд түр хугацааны нөөцийн дутагдлыг овернайт зээлээр хангах сонирхол өндөр байсан боловч сүүлийн хоёр сард банк хоорондын хадгаламжийн хүү өсч, банкуудын илүүдэл нөөцийн нэмэгдсэн тул банк хоорондын хадгаламж байршуулах сонирхол нэмэгдсээр байна. Тухайлбал, 2008 оны эхний 8 дугаар сарын байдлаар нийт арилжааны 58.5 хувийг овернайт зээл дангаараа, 10.9 хувийг банк хоорондын хадгаламж, 6.1 хувийг банк хоорондын зээл эзэлж байсан бол 2009 оны эхний 8 сарын байдлаар (Зураг 3.25) нийт арилжааны 23.1 хувийг овернайт зээл, 58.8 хувийг банк хоорондын хадгаламж, 5.4 хувийг банк хоорондын зээл, 12.6 хувийг нь репо нөхцлөөр хийгдсэн арилжаа эзэлж байна. Харин нийт арилжааны дүн 2009 оны 2 дугаар улирлын эцэст оны эхнээс 13.9 хувиар өссөн бол 8 дугаар сард оны эхнээс 43.6 хувиар буурсан байна. Банкуудын цэвэр бэлэн нөөцийн¹³ хомсдол өндөр байсан 1 болон 3 дугаар саруудад овернайт зээлийн хэмжээ огцом өссөн бөгөөд 2009 оны 3 сард 282.2 тэрбум төгрөгийн арилжаа зөвхөн овернайт зээлээр хийгджээ. Харин 8 сар хүртэл овернайт зээлийн хэмжээ болоод хоёрдогч зах зээл дээрх ТБҮЦ-ны арилжаа эрчимтэй буурч, банк хоорондын хадгаламж болон репо санхүүжилтийн хэмжээ харьцангуй өссөн байна.

¹³ Банкуудын илүүдэл нөөц болон ТБҮЦ-ны нийлбэрээс төв банкны санхүүжилтийг хасч тооцсон үзүүлэлт.


Зураг 3.25. Банк хоорондын захын арилжааны хэмжээ (сая.төгрөг)



Банк хоорондын захын арилжааны хүү. Монголбанк бодлогын хүүгээр дамжуулан банк хоорондын захын хүүг удирдах замаар банкуудын зээл, хадгаламжийн хүүнд нөлөөлөх зорилт тавьдаг. Өөрөөр хэлбэл, банкуудын хувьд илүүдэл нөөцөө Төв банк болон бусад банкууд гэсэн боломжуудаас аль өндөр хүү зарласанд нь байршуулах шийдвэр гаргах бөгөөд Төв банкны бодлогын хүү өсөх тохиолдолд банкуудын ТБҮЦ-ны эрэлт өсдөг. Иймд банк хоорондын захын хүү бодлогын хүүний чиглэлийг дагаж хөдөлнө. 2009 оны 1 дүгээр улирлаас хойш Монголбанк 14.0 хувь байсан бодлогын хүүг гадаад валютын дотоодын захын тогтвортойтой уялдуулан 1.25 нэгж хувиар 2 удаа 11.5 хувьд хүргэн бууруулсан бөгөөд үүнийг даган банк хоорондын захын хүү буурлаа.

Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү 2009 оны 8 дугаар сард 11.2 хувь болж оны эхнээс 7.1 нэгж хувиар буурлаа. Төв банкны санхүүжилтийн хэрэгслүүдийн хүү бодлогын хүүний өсөлт, бууралтыг даган өөрчлөгддөг болсон тул 2009 оны эхний хагас жилийн эцэст репо санхүүжилтийн хүү 17.5 хувь, барьцаат зээлийн хүү 20.5 хувь, овернайт зээлийн хүү 21.5 хувь болж буурлаа. Харин банк хоорондын захын хүүнүүд 2009 оны 8 дугаар сарын байдлаар зээл болон хадгаламжийн хүү харгалзан 11.00 болон 12.06 хувь, репо санхүүжилтийн хүү 12.49 хувь, овернайт зээлийн хүү 8.37 хувь болж мөн адил буураад байна.


Зураг 3.26. Банк хоорондын захын арилжсааны хэмжээ (баруун тэнхлэг), бодлогын хүү, банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү (зүүн тэнхлэг)



3.4. Ургал дансны 2009 оны 2 дугаар улирлын гүйцэтгэл

Төлбөрийн тэнцлийн ургал данс 2009 оны эхний хагас жилд 151.5 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 1.5 хувиар буюу 2.3 сая ам.доллараар багасчээ.

Зураг 3.27. Ургал дансны тэнцэл (эхний хагас жилийн байдлаар)



Урсгал дансны алдагдал 2009 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 5.5 дахин буюу 62.0 сая ам.доллараар өссөн хэдий ч 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 1.9 дахин буюу 64.3 сая буурсан нь эхний хагас жилийн байдлаарх урсгал дансны тэнцлийг өмнөх оны түвшинд байхад хүргэжээ.

Хүснэгт 3.8. Урсгал дансны 2008, 2009 оны хагас жилийн гүйцэтгэл (сая ам.доллараар)


Данс	2008			2009			Жилийн өөрчлөлт					
	Улирлаар			Эхний хагас жил	Улирлаар			Эхний хагас жил	Улирлаар			Эхний хагас жил
	Q1	Q2	өөрчлөлт		Q1	Q2	өөрчлөлт		Q1	Q2	өөрчлөлт	
Бараа, ажил үйлчилгээний худалдаа	-32.9	-187.7	-154.8	-220.6	-102.7	-108.9	-6.2	-211.5	-69.8	78.8	148.6	9.1
Цэвэр орлого	-37.3	-17.0	20.3	-54.2	-22.0	-38.3	-16.3	-60.3	15.3	-21.3	-36.6	-6.0
Урсгал шилжүүлэг /Цэвэр/	56.4	64.7	8.3	121.0	48.8	71.5	22.7	120.3	-7.6	6.8	14.4	-0.7
Дүн	-13.8	-140.0	-126.2	-153.8	-75.8	-75.7	0.2	-151.5	-62.0	64.3	126.4	2.3

Урсгал дансны алдагдал 2009 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс буурахад дараах хүчин зүйлс нөлөөлжээ. Үүнд:

1. Дотоодын эрэлт буурсан учраас дотоодын хэрэглээ, тэр дундаа импортын эрэлт хумигдлаа.
 - Бодит ДНБ 2008 оны 1 дүгээр улиралд 15.0 хувиар, 2 дугаар улиралд 10.0 хувиар тус тус өсч байсан бол 2009 оны эхний улиралд 4.2 хувиар буурч, 2 дугаар улиралд 0.7 хувиар өссөн байна. Үүнд импортын бараа, бүтээгдэхүүний гол хэрэглэгч болох аж үйлдвэр, барилгын салбарын үйлдвэрлэлт 2009 оны 1 дүгээр улиралд 6.6 хувиар, 2 дугаар улиралд 6.4 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.
2. Хувийн секторын хадгаламж, хөрөнгө оруулалтын тэнцэл сайжирчээ.
 - Иргэд, аж ахуйн нэгжийн хадгаламж 2009 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 1.1 тэрбум төгрөгөөр өслөө. Банкуудын олгосон зээлийн үлдэгдэл 2009 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 503.2 сая төгрөгөөр буурлаа. Ийнхүү өрхийн хэрэглээ буурч, аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалт буурснаар импорт буурах нөхцөл бүрдүүллээ.
3. Гадаад худалдааны нөхцөл сайжирч байна.
 - Зэсийн дэлхийн зах зээл дээрх үнэ 2009 оны 5 дугаар сараас эхлэн нефтийн бүтээгдэхүүний импортын үнээс илүү хурдацтай өсч эхэлснээр гадаад

худалдааны нөхцлийн индекс¹⁴ 2 дугаар улирлын эцэст 94.3-д хүрч, өмнөх улирлаас 14.5 нэгжээр сайжирлаа.

Зураг 3.28. Худалдааны нөхцөл (2005/01=100).



Гэхдээ Засгийн газрын зардал импортыг нэмэгдүүлж урсгал тэнцэл сайжирахад сөргөөр нөлөөлсөн хүчин зүйлс хэвээр байна. Тухайлбал:

- ◆ Улсын төсвийн урсгал тэнцэл 2009 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 181.7 хувиар буюу 161.9 тэрбум төгрөгөөр буурч, 72.8 тэрбум төгрөгийн алдагдалтай болсон бол 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 63.5 хувиар буюу 65.1 тэрбум төгрөгөөр буурч, 37.3 тэрбум төгрөгийн ашигтай байна.
- ◆ Төсвийн хөрөнгө оруулалт, эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүн 2009 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 261.4 сая төгрөгөөр нэмэгдэж, 34.6 тэрбум төгрөг байсан бол 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 27.1 тэрбум төгрөгөөр өсч, 192.6 тэрбум төгрөгт хүрчээ.

Үйлчилгээний худалдаа

Эхний хагас жилийн байдлаар үйлчилгээний худалдааны дансны орлого 159.9 сая, зарлага 283.3 сая, цэвэр дүнгээр 123.4 сая ам.долларын алдагдалтай гарав. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 62.8 хувиар буюу 47.6 сая ам.доллараар алдагдал өссөн байна.

¹⁴ Экспортод дунджаар 80.6 хувийг эзэлдэг 14, импортод дунджаар 66.0 хувийг эзэлдэг 40 барааны хувьд худалдааны нөхцлийн индексийг 2005 оны 1-р сарыг суурь болгон тооцов.

Xүснэгт 3.9. Үйлчилгээний худалдаа

Үзүүлэлт	Эхний хагас жил		Өөрчлөлт	
	2008	2009	Дүн	Хувь
Үйлчилгээний худалдааны тэнцэл	-75.8	-123.4	-47.6	62.8 ↓
Тээвэр (цэвэр)	-40.2	-41.6	-1.4	3.4 ↓
Аялал (цэвэр)	16.5	-6.1	-22.6	-137.2 ↑
Харилцаа холбоо (цэвэр)	-3.5	-7.5	-4	113.9 ↓
Барилгын ажил (цэвэр)	-2	-0.6	1.4	-69.5 ↑
Даатгалын үйлчилгээ (цэвэр)	-7.5	-2.6	4.9	-65.3 ↑
Бусад үйлчилгээ (цэвэр)	-39.1	-65	-25.9	66.2 ↓

Үйлчилгээний худалдааны орлогын 40.0 хувийг бүрдүүлсэн аялал жуулчлалын салбарыг үзвэл 2009 оны эхний хагаст Монгол Улсад нийт 96.3 мянган гадаадын жуулчин¹⁵ зочилж, жуулчны орлого 64.0 сая ам. долларт хүрэв. Харин Монгол Улсын 113.7 мянган иргэд¹⁶ (давхардсан тоогоор) гадаадад зорчиж, гадаадад 62.7 сая ам. доллар зарцуулсан байна.

Xүснэгт 3.10. Аялал жуулчлалын үйлчилгээний дансны тэнцэл

Үзүүлэлт	Эхний хагас жил		Өөрчлөлт	
	2008	2009	Дүн	Хувь
Жуулчлалын салбарын нийт орлого (сая ам.доллараар)	94.8	64	-30.8	-32.51%
Гадаадын жуулчдын тоо	143,691.00	96,290.00	-47,401.00	-32.99%
Жуулчлалын салбарын нийт зардал (сая ам.доллараар)	70.3	62.7	-7.6	-10.79%
Гадаадад жуулчилсан Монгол иргэдийн тоо	137,812.00	113,708.20	-24,103.90	-17.49%
Жуулчлалын цэвэр орлого (сая ам.доллараар)	24.4	1.2	-23.22	-95.03%

Гадаадад сурч, ажиллаж байгаа Монгол иргэдийн эх орон руугаа гүйвуулсан шилжүүлгийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 31 хувиар буюу 31.6 сая ам.доллараар буурсан ч Засгийн газрын шилжүүлгийн дүн урьдчилсан мэдээгээр 44 хувиар буюу 19.3 сая ам.доллараар нэмэгдсэнээр урсгал шилжүүлгийн нийт дүн (цэвэр) 120.3 сая ам.доллар болов. Энэ нийт дүн бараг өнгөрсөн оны мөн үеэтэй адил түвшинд байна.

Барилгын салбарын ажилчдын тоо буурсан учраас гадаадын ажилчдын гадагшлах шилжүүлэг буурчээ. АХБ-наас энэ оны 5 дугаар сараас ашиглаж байгаа “Хүнс, тэжээлийн хөтөлбөр”-ийн 9.0 сая ам.доллар Засгийн газрын шилжүүлгийн дүнг өсгөв.

¹⁵ Монгол Улсад ирсэн гадаадын жуулчдын тоог Хил хамгаалах ерөнхий газраас авсан.

¹⁶ Гадаадад зорчсон нийт Монгол иргэдийн тоог Зам, тээвэр, аялал жуулчлалын яамнаас хүлээн авсан.

3.4. Төлбөрийн тэнцлийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2009				Жилээр	
	I улирал	II улирал	Төсөөлөл			
			III улирал	IV улирал		
I. Ургал тэнцэл (A+B+B)	-75.8	-75.7	-48.3	-47.3	-247.1	
А. Бараа ба үйлчилгээний худалдаа (а+б)	-102.7	-108.9	-73.0	-47.1	-331.6	
а. Бараа (1-2)	-49.0	-39.1	-47.8	-1.6	-137.7	
1. Экспорт Ф.О.Б	322.3	440.6	521.7	540.2	1824.8	
1.1. Зэсийн баяжмал	81.5	108.5	131.3	119.5	440.8	
1.2. Мөнгөжөөгүй алт	126.4	42.7	79.6	120.1	368.8	
1.3. Бусад	114.4	289.5	310.9	300.5	1015.3	
2. Импорт Ф.О.Б	-371.4	-479.7	-569.6	-541.8	-1962.5	
6. Үйлчилгээ (1+2+3+4+5+6)	-53.6	-69.7	-25.2	45.4	-194.0	
1. Тээвэр /цэвэр/	-11.2	-30.4	-24.7	-20.4	-86.6	
2. Аялал /цэвэр/	-7.5	1.4	36.5	11.2	41.5	
3. Харилцан холбооны үйлчилгээ /цэвэр/	-2.1	-5.3	-4.3	-4.4	-16.2	
4. Барилгын ажил /цэвэр/	-0.3	-0.3	-0.8	-0.4	-1.8	
5. Даатгалын үйлчилгээ /цэвэр/	-1.5	-1.1	-2.1	-1.9	-6.7	
6. бусад үйлчилгээ /цэвэр/	-31.0	-34.0	-29.8	-29.4	-124.2	
Б. Цэвэр орлого (а+б)	22.0	38.3	-34.3	-67.1	-161.7	
а. Ажиллагсдын цалин хөлс /цэвэр/	0.5	0.5	0.5	0.5	2.1	
б. Хөрөнгө оруулалтын хөрөнгө /цэвэр/	-22.5	-38.8	-34.8	-67.6	-163.7	
В. Ургал шилжүүлэг (а+б+в)	48.8	71.5	59.0	66.8	246.2	
а. Засгийн газрын шилжүүлэг /цэвэр/	21.8	41.0	41.0	41.0	144.8	
б. Ажилчдын шилжүүлэг	22.5	23.0	9.0	16.3	70.9	
1. Хүлээн авсан	33.9	37.4	36.4	36.1	143.8	
2. Шилжүүлсэн	11.4	14.4	27.4	19.7	72.9	
в. Бусад шилжүүлэг /цэвэр/	4.6	7.4	9.0	9.5	30.5	
II. Хөрөнгө ба Санхүүгийн тэнцэл	-48.5	131.1	113.3	105.3	301.3	
А. Хөрөнгийн данс	0.0	0.0	0.0	0.0	0.0	
Б. Санхүүгийн данс	-48.5	131.1	113.3	105.3	301.3	
а. Шууд хөрөнгө оруулалт /цэвэр/	70.8	61.6	82.3	78.3	293.0	
б. Санхүүгийн хөрөнгө оруулалт	-47.5	59.5	-0.6	-2.2	9.2	
1. Актив	-49.3	52.8	-5.8	-7.0	-9.3	
2. Пассив	1.8	6.7	5.2	48.8	18.5	
в. Бусад хөрөнгө оруулалт	-71.8	10.0	31.6	29.2	-0.9	
1. Худалдааны зээл /цэвэр/	-36.6	21.1	-6.4	36.8	14.8	
2. Зээл /цэвэр/	17.4	71.6	131.3	7.1	227.4	
2.1. Урт хугацааны зээл	9.9	71.2	128.7	4.5	214.3	
2.1.1. Актив	0.0	-1.1	-0.6	-0.6	-2.2	
2.1.1.1. Засгийн газар	0.0	0.0	0.0	0.0	0.0	
2.1.1.2. Бусад сектор	0.0	-1.1	-0.6	-0.6	-2.2	
2.1.2. Пассив	9.9	72.3	129.3	5.0	216.2	
2.1.2.1. Ашиглалт	62.6	126.0	186.1	67.7	442.4	
2.1.2.1.1. засгийн газар	10.2	81.6	142.5	20.9	255.2	
2.1.2.1.2. Бусад сектор	52.4	44.4	43.6	46.8	187.2	
2.1.2.2. Үндсэн өрийн төлбөр	52.6	53.7	56.8	62.7	225.9	
2.1.2.2.1. Засгийн газар	7.7	6.8	11.6	16.6	42.1	
2.1.2.2.2. Бусад сектор	44.9	46.9	45.2	46.7	183.8	
2.2. Богино хугацааны сектор	7.4	0.5	2.6	2.6	13.1	
2.2.1. Актив	5.0	-1.0	0.7	1.0	5.4	
2.2.2. Пассив	2.4	1.4	1.9	1.6	7.4	
2.2.2.1. Ашиглалт	8.3	6.6	6.4	6.5	27.7	
2.2.2.2. Үндсэн өрийн төлбөр	5.9	5.2	4.5	4.8	20.3	
3. Бэлэн мөнгө ба харилцах /цэвэр/	-52.6	-82.8	-93.2	-14.6	-243.1	
4. Бусад цэвэр актив	0.0	0.0	0.0	0.0	0.0	
III. Алдаа болон орхигдуулга	0.3	81.2	0.0	0.0	81.5	
IV. Нийт төлбөрийн тэнцэл	-124.0	136.6	65.0	58.0	136.6	
V. Цэвэр нөөцийн өөрчлөлт	124.0	-136.6	-65.0	-58.0	-135.6	

Эх сурвалж: Монголбанк

Тайлбар: ОУВС-тай хэрэгжүүлж буй Стэнд-Бай хөтөлбөрийн дагуу Монголбанк гадаад валютын цэвэр албан нөөцийн хэмжээг нэмэгдүүлэх зорилттой ажиллаж байгаатай, нөгөө талаар экспортын голлох бүтээгдэхүүн болох алт, зэсийн үнэ энэ оныг дуусталх хугацаанд харьцангуй өндөр байх, тухайлбал 2009 оны 3-р улиралд алтны үнэ дунджаар 920 ам.доллар/уни, зэсийн үнэ дунджаар 5335 ам.доллар/тонн, 4-р улиралд алтны үнэ дунджаар 906 ам.доллар/уни, зэсийн үнэ дунджаар 4602 ам.доллар/тонн байхаар төсөөлөгдөж байгаатай уялан манай улсын төлбөрийн тэнцэл 2009 оны 3-4 дүгээр улиралд нийтдээ 120 гаруй мянган ам.долларын ашигтай байх урьдчилсан төсөөлөлтэй байна. Ингэснээр 2009 оны эцсийн байдлаар нийт төлбөрийн тэнцэл 135 гаруй мянган ам.долларын ашигтай гарах хандлагатай байна (Жич: Төлбөрийн тэнцлийн төсөөллийг 2009 оны 8 дугаар сарын байдлаарх тоон мэдээлэл дээр үндэслэн боловсруулав.)

3.5. Гадаад валютын улсын албан нөөцийн эрсдлийн удирдлага

Монголбанк гадаад валютын улсын нөөцийг найдвартай байдлыг хангах, хөрвөх чадварыг алдагдуулахгүй байх, үр өгөөжийг нэмэгдүүлэх зарчмын дагуу удирдаж байна. Дэлхийн эдийн засгийн хямрал үргэлжилж, санхүүгийн тогтвортгүй байдал арилаагүй байгаа өнөө үед гадаад валютын нөөцийн удирдлага, гадаад валютын үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлох, түүнээс сэргийлэх асуудал чухал хэвээр байна. Гадаад валютын нөөцийн удирдлагын стратегийн чиглэлийг тодорхойлон, хөрөнгө оруулалтуудын зах зээлийн үнэлгээг хийх, зах зээлийн болон зээлийн эрсдэлүүдийг тооцох, холбогдох лимитүүдийг тогтоох, хяналт тавих, дэлхийн зах зээлийн байдлыг байнга ажиглан холбогдох мэдээ тайлангуудыг бэлтгэх ажлуудыг тогтмолжууллаа.

Гадаад зах зээлд валютын ханшны хэлбэлзэл их, дотоодын зах зээлд ам.долларын хэрэгцээ өндөр байсан зэргээс хамаарч гадаад валютын улсын нөөцийн голлох хэсгийг богино хугацааны өндөр хөрвөх чадвар бүхий ам доллараар илэрхийлэгдсэн хөрөнгө оруулалтуудад байршуулсан болно. Сүүлийн үед дэлхийн эдийн засгийн уналт зогсох хандлага ажиглагдаж эхэллээ. Хятад, Энэтхэгийн эдийн засгийн өсөлт нэмэгдэж, Япон, Герман, Францад эдийн засаг өсч, АНУ-ын эдийн засгийн уналт саарчээ. Дэлхийн эдийн засгийн уналт саарах хандлагатай байгаа ч санхүүгийн системийн тогтвортгүй байдал хэвээрээ байна. Бизнесийн орчин хүнд, банкуудын тэнцэл дэх эрсдэлтэй активуудыг цэвэрлэх шаардлага байгаагийн улмаас, банк санхүүгийн системд бүтцийн өөрчлөлт хийх асуудал тулгараад байна. Санхүүгийн хямрал эхэлснээс хойш дэлхийн голлох банк, санхүүгийн байгууллагууд 2009 оны 8 дугаар сарын дүнгээр нийт 1612.6 тэрбум ам долларын алдагдалтай ажиллалаа.

Хүснэгт 3.11. Банк, санхүүгийн байгууллагуудын хүлээсэн алдагдал болон нэмэгдүүлсэн өөрийн хөрөнгийн хэмжээ, тивээр (тэрбум ам доллар)

	Хүлээсэн алдагдал	Шинээр нэмэгдүүлсэн өөрийн хөрөнгө
Америк	1075.6	751.4
Европ	495.3	460.8
Ази	41.7	102.8
Нийт	1612.6	1315

Гадаад валютын улсын нөөцийн удирдлагын эрсдэлийг бууруулах зорилгоор хөрөнгө байршуулах байгууллагын жагсаалтын улирал бүр шинэчлэх, хөрөнгө оруулалтын эрсдэлийг бууруулах үүднээс АНУ-ын засгийн газрын үнэт цаас, АНУ, Герман, Япон, Их Британи зэрэг орнуудын төв банкуудын харилцах, хадгаламж, Олон улсын төлбөр тооцооны банкны үнэт цаас, хадгаламж зэрэг хөрөнгө оруулалтуудыг дийлэнхдээ ашиглав. Мөн харилцагчийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор Засгийн газар, Төв банк, Олон улсын төлбөр тооцооны банк, олон улс санхүүгийн зах зээл дээр АА зэрэглэлээс дээш зэрэглэлтэй банк, санхүүгийн байгууллагуудтай харилцаж байна.

Олон улсын санхүүгийн зах зээл тогтвортгүй, системийн эрсдэл өндөр хэвээр байгаа тул гадаадын банкууд, санхүүгийн байгууллагуудад хөрөнгө байршуулах ажиллагааг түр хугацаанд зогсоох, алтыг биет хэлбэрт шилжүүлэн зөвхөн Английн төв банкинд байршуулах арга үргэлжлүүлэн хэрэгжүүллээ. Цаашид гадаад валютын улсын нөөцийн удирдаагын төлбөр тооцооны эрсдэлийг бууруулахад олон улсын туршлагыг ашиглан шинэчлэл хийх чиглэлтэй ажиллаж байна.

4. САНХҮҮГИЙН САЛБАР, БАНКНЫ ЗУУЧЛАЛЫН ТОЙМ

4.1 Банкны салбарын өнөөгийн байдал, учирч буй бэрхшээл

Банкны салбарын нийт актив 2009 оны 8 дугаар сард 3.9 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд сүүлийн 12 сард 1.5%-иар өслөө. 2008 оны сүүлийн улиралд олон улсын санхүүгийн зах зээлд хүндрэл бий болж хөрөнгийн урсгал гадагшилснаас зарим банкуудын төлбөрийн чадвар муудсан. Анод банк төлбөрийн чадвараа алдаж, иргэдийн банкинд итгэх итгэл буурч, бусад банкууд төлбөр түргэн гүйцэтгэх чадвар муудах шалтгаан боллоо. Үүнээс гадна, төгрөгийн ханш 2008 оны 4 дүгээр улирлаас 2009 оны 1 дүгээр улирал дуустал хугацаанд огцом суларч гадаад валютаар олгосон зээлийн чанар муудах, банкууд ханшийн тэгшитгэлийн алдагдал хүлээх хүндрэл үүссэн.

Тухайлбал, Анод банк төлбөрийн чадвараа алдсан тухай мэдээллээс үүдэн 2008 оны сүүлээр иргэд харилцах, хадгаламжаа татах нь ихэсч харилцах, хадгаламжийн гарах урсгал 2008 оны 10 дугаар сард 123.8 тэрбум төгрөг, 11 дүгээр сард нь 109.3 тэрбум төгрөгт хүрсэн. Үүнийг зогсоохын тулд УИХ-аас “Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хууль”-ийг 2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр батлан гаргасан. Энэ нь банкуудын төлбөрийн чадварт учирч байсан дарамтыг багасгасан. Мөн энэ хугацаанд Монголбанкнаас банкуудын хөрвөх чадварыг дэмжих үүднээс банк хоорондын зах зээл дээр урвуу репо, барьцаат зээл, гадаад валютын своп зэрэг хэд хэдэн бүтээгдэхүүнийг бий болгосон бөгөөд эдгээрээр дамжуулан 2008 оны 10 дугаар сараас 2009 оны 6 дугаар сарын эцэс хүртэлх хугацаанд банкуудад нийт 259.6 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна. Дээрх арга хэмжээнүүдийн үр дүнд банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт¹⁷ 2008 оны 11 дүгээр сарын эцэст хамгийн бага түвшиндээ буюу 21.5 хувь хүртэлээ буурч байсан бол 2009 оны 6 дугаар сарын эцэст 31.6 хувь болов. 2009 оны 6 дугаар сар гэхэд хадгаламжийн хэмжээ өсч хямралын өмнөх үетэй эргэн тэнцэж 2.5 их наяд төгрөг боллоо.


Банкин дахь хувийн хэвшлийн болон иргэдийн харилцах, хадгаламжийн гадагшлах урсгал зогссон боловч дээр дурьдсан хууль 2012 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд банкинд байршуулсан харилцах, хадгаламжинд төрөөс 100 хувь баталгаа гаргасан нь татвар төлөгчдийн нуруун дээрх ачааг нэмэгдүүлж болзошгүй юм. Тайлант үеийн байдлаар төрөөс гаргасан мөнгөн хадгаламжийн баталгаанд хамрагдаж буй харилцах, хадгаламжийн дун 2.1 их наяд төгрөг байгаа нь дотоодын нийт бүтээгдэхүүний 41 хувьтай тэнцэж байна.

Эдийн засгийн өсөлт саарч, бодит салбарын үйл ажиллагаа зогсонги байдалд орсноос зээлдэгчдийн төлбөрийн чадвар буурч зээлийн эрсдэл өслөө. Иймээс банкуудын зээлийн багцын чанар түргэн муудаж байна. Жишээлбэл, энэ оны 2 дугаар улирлын байдлаар уул уурхайн салбарын чанаргүй зээл тухайн салбарын нийт зээлийн 19.9%, барилгын салбарынх 17.3%, боловсруулах үйлдвэрлэлийнх 12.5%, худалдааных 10.9% хүртэл өсчээ. Банкны системийн хэмжээнд нийт чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 2009 оны 8 дугаар сарын дүнгээр сүүлийн 12 сарын түршид 4.8 дахин буюу 323 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 405.8¹⁸ тэрбум төгрөг боллоо. Чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувийн жинг 12.2 нэгжээр нэмэгдүүлж 15.2 хувьд хүргэжээ. Иймээс банкууд шинээр зээл олгохоосоо илүүтэйгээр хуучин олгосон зээлийнхээ эргэн төлөлтөнд анхаарахад хүрсэн байна. Хувийн салбарт олгох зээлийн хэмжээ буурч, банкны салбарын нийт зээлдэгчдийн тоо өмнөх оны 8 дугаар сараас 5.7 хувиар хорогдон 514 мянгад хүрчээ.


¹⁷ Хөрвөх чадвартай активыг нийт пассивт харьцуулсан харьцаа болно.

¹⁸ Хяналт шалгалтын газрын тооцсон дүнгээр

Зураг 3.29. Банкны салбарын нийт зээл ба чанаргүй зээлийн үзүүлэлтүүд




Зураг 3.30. Банкны салбарын зээлийн багцын эдийн засгийн ангиалал



Банкууд шинээр зээл олгохгүй, олгогдсон зээлийн чанар муудаж байгаагаас зээлийн хүүгийн орлого буурч, зээл төлөгдхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сангийн зардал өсч байна. Энэ оны эхний 8 сарын дүнгээр банкууд 87.7 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллалаа. Зээлийн хүүгийн орлого өмнөх оны мөн үеийн түвшинтэй харьцуулахад 5.5 хувиар буюу 17.3 тэрбум төгрөгөөр буурч, эрсдэлийн сангийн зардал 5 дахин буюу 104.1 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Банкны салбарын зээлийн чанар муудсанаар банкуудын ашигт ажиллагаа буурч, зарим банкууд өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийн байвал зохих доод хэмжээг хангаж ажиллахгүйд хүрээд байна.

Нийт өөрийн хөрөнгийн дүн нь 2008 оны 8 дугаар сартай харьцуулахад 178.5 тэрбум төгрөг буюу 41.7 хувиар буурсан байна. Зээлийн өсөлт саарснаар эрсдэлээр жигнэсэн активын хэмжээ өөрийн хөрөнгийнхтэй харьцуулахад ихээхэн (326.4 тэрбум төгрөг буюу 10 хувь) буурлаа. Тайлант үед өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлт 13.1 хувьд хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 0.2 нэгжээр буурсан байна. Банкны салбарын хэмжээнд өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг хангахгүй байгаа банкуудад нийтдээ 198.4 тэрбум төгрөгийн нэмэлт өөрийн хөрөнгө шаардлагатай байгаа юм. Цаашид зээлийн чанар улам муудах хандлагатай байгаа тул нэмэлт шаардлагатай өөрийн хөрөнгийн хэмжээ нэмэгдэнэ.

Зураг 3.31. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ



Банкны салбарыг эрүүл, хэвийн үйл ажиллагаатай болгохын тулд цогц бүтцийн өөрчлөлтийг хийх, салбарын чанаргүй активыг бууруулах, хадгаламжийн даатгалын сонгодог тогтолцоог нэвтрүүлэх, үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа банкуудад өөрийн хөрөнгийн дутагдлын хэмжээнд нь дахин санхүүжилт хийх, харилцагчдад шинээр зээл олгохыг дэмжих шаардлага үүсээд байна. Банкуудын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэхийн тулд Монголбанкны зүгээс 2009 оны 3 дугаар сард өөрийн хөрөнгийн зохистой харьцааг 12 хувь болгон нэмэгдүүллээ. Мөн эдийн засаг тогтвортой, банкны ашигт ажиллагаа харьцангуй өндөр байсан үед бүрдүүлсэн эрсдэлийн сангийн хөрөнгөө ашиглах бололцоог банкуудад олгон эрсдэлийн сан байгуулах хувь хэмжээг хямралтай байгаа энэ үед бууруулсан болно. Үйл ажиллагаанд нь түр хугацааны хүндрэл үүссэн аж ахуйн нэгжийн хувьд зээлээ банктай дахин

тохиролцох уян хатан нөхцлийг бүрдүүлэх үүднээс зээлийн эргэн төлөгдөх хугацааг 2 удаа сунгахыг Төв банкнаас зөвшөөрсөн. Түр зуурын учир шалтгаанаар эргэн төлөлт нь saatсан зээлдэгчдэд уян хатан хандан зээлийн нөхцлийг тухайн орчинтой уялдуулан өөрчлөх чиглэлийг Монголбанкнаас банкуудад өглөө.

Монголбанкны зүгээс орон сууцны санхүүжилтийн анхдагч болон хоёрдогч захыг хөгжүүлэхэд идэвх санаачлагатай ажиллаж ирлээ. Банкуудад мөрдөх ипотекийн анхдагч зээлийн нэгдсэн журмыг батлан мөрдүүлсэн нь ипотекийн анхдагч зээлийг банк бүр ижил төстэй шаардлагын дагуу олгон хоёрдогч захад зориулан зээлүүдийг багцлах ажлыг хөнгөвчилж нэг жишигт оруулсан. Ипотекийн зээлийн харьцааг зохицуулах гол үндсэн хууль болох “Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай” хууль УИХ-ын 2009 оны хаврын чуулганаар батлагдан гарах бэлтгэл ажилд Монголбанкны төлөөлөл орж ажиллалаа. Германы Сэргээн босголт, хөгжлийн банкны 4.8 сая еврогийн эх үүсвэрийг орон сууцны зээлийн эх үүсвэрт ашиглах асуудал УИХ дээр эцэслэх шатандаа байна. Мөн Монголын ипотекийн корпорацийн бондоор дамжуулан орон сууцны санхүүжилтийн нэмэлт 25 тэрбум төгрөгийн эх үүсвэр гаргаад байна.

4.2 Банкны хяналт шалгалт

Монголбанкнаас зайнаас тавих дараалсан хяналтад ач холбогдол өгч, газар дээрх шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг цаг хугацаа алдалгүй засч залруулах ажиллагааг чангатгаад байна. Банкинд жил бүр хийгддэг газар дээрх шалгалтаар ноцтой зөрчил дутагдал илэрч түүнийгээ засч барагдуулах чиглэлээр хангалтгүй ажилласан банкинд хууль тогтоомжийн дагуу албадлагын шат дараалсан арга хэмжээг авч, санхүүгийн зах зээлийн сахилгыг өндөржүүлэх арга хэмжээг тухай бүр авлаа. Түүнчлэн, Монголбанкнаас тавих хяналт шалгалтын агуулга, хамрах хүрээ, хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор төв банкны хянан шалгагчдын ур чадварыг дээшлүүлэх сургалтыг явуулж, хянан шалгагчдын тоог нэмэгдүүлж байна.

Монголбанкнаас эдийн засгийн хямралын орчинд банкны салбарын тогтвортой байдлыг хэвээр хадгалан харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийн тууштай хамгаалахад чиглэсэн дараах багц арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр донорын хамтын нийгэмлэгтэй тохиролцоод байна. Үүнд: 2009 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар хямралын үеийн банкны салбарын чанаргүй зээлийн багцын бодит хэмжээ, тэнцлийн гадуур хүлээж болзошгүй үүргүүд зэргийг үнэн зөв, бүрэн гүйцэд, хараат бус байдлаар бүртгэж байгаа эсэхийг тодруулах зорилгоор банкуудад нэр хүнд бүхий гадаадын аудитын компаниар аудитын цогц шалгалтыг Дэлхийн банкны санхүүжилтээр хийлгэхээр боллоо. Аудитын шалгалтын дүнгээр чанаргүй зээлийн асуудлын цар хүрээг тодорхойлон өөрийн хөрөнгийн дутагдлыг тооцож гаргаснаар системийн ач холбогдол бүхий банкуудын дүрмийн санд олон улсын байгууллагуудаас шууд хөрөнгө оруулалт хийх асуудлыг Монголбанк тохиролцооор төлөвлөж байна.

Монголбанкнаас санал болгоод буй банкны бүтцийн өөрчлөлтийн дараагийн зарчмын санал бол банкуудын зээлийн багцад буй хүндрэлтэй зээлийг нь худалдан авах тусгай агентлагийг байгуулах асуудал юм. Санхүү банкны хямралын орчинд хүндрэлтэй зээлийг худалдан авч барагдуулдаг тусгай агентлагийг байгуулан ажиллуулдаг шилдэг туршлага бусад улс орнуудад байдаг. Манай орны хувьд тусгай агентлагийг байгуулан чанааргүй зээлийг засгийн газрын өрийн бичгээр сольж аажмаар мөнгөжүүлэх нь бодит эдийн засагт зээл нийлүүлэх, зээлийн тасалдлыг шийдэх арга зам болно.

Банкуудаас татсан хадгаламжийнхаа хэмжээгээр шимтгэл төлж эх үүсвэр хуримтлуулдаг банкны хадгаламжийн даатгалын сонгодог тогтолцооны үндсийг тавих нь төрөөс хадгаламжийн баталгаагаар үүрч болзошгүй зардлын хэмжээг бууруулах бололцоог олгоно. Монголбанкнаас хадгаламжийн даатгалын байгууллагатай холбоотой судалгааг эхлүүлэн, Хадгаламжийн даатгалын тухай хуулийн төслийг боловсруулан өргөн бариад байна.

Бизнесийн байгууллагуудын дотор банк, даатгал, үнэт цаасны ажиллагааг зэрэг явуулдаг бие даасан нэгжүүд бий болсноор нэгдсэн хяналт шалгалтыг Монголбанк, СЗХ, зарим тохиолдолд Сангийн яамнаас хамтран явуулах шаардлага амьдралаас урган гарах болсон. Нэгдсэн хяналт шалгалт нь даатгал, үнэт цаасны үйл ажиллагааны эрсдлийн хэмжээ, агуулга бизнесийн группын нэгж болох банкны санхүү төлбөрийн чадварт хэрхэн нөлөөлөхийг олж тогтоон, банк санхүүгийн салбарын найдвартай тогтвортой байдлыг хангуулахад чиглэгддэг. УИХ-ын 2009 оны намрын чуулганд өргөн барьсан Банкны хуулийн шинэчилсэн найруулганд нэгдсэн хяналт шалгалтыг явуулах хууль эрх зүйн орчныг анх удаа тусгасан бөгөөд үүний дагуу анхны шалгалтыг Монголбанк, СЗХ-оос хамтран явуулахаар төлөвлөж байна.

Ул уурхайн төслүүд хэрэгжиж эхэлж байгаагаас эдийн засагт эргэлдэх хөрөнгийн урсгал томорсон, шинэ орчинд томоохон зээлийн эрэлтийг хангахуйц банкны цогц үйлчилгээ үзүүлэх, ачаа даах хэмжээний үндэсний банкуудтай болох шаардлага бий болоод байгаа тул цомхон бүтэцтэй банкны салбарыг байгуулах чиглэлээр “Банкны салбарын дунд хугацааны шинэ үзэл баримтлал”-ыг Монголбанкнаас олон улсын банк, санхүүгийн донор байгууллагуудын зөвлөхүүдтэй хамтран боловсруулж байна. Түүнчлэн, зарим донор байгууллагуудтай хамтран компанийн зохистой засаглалын зарчмуудыг Монголын банкуудад хэрэгжүүлэх талаар цогц баримт бичгийг боловсруулан, хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөж байна. Энэ нь банкны удирдлагын зохистой засаглалын дэвшилтэт удирдлагын арга барилыг нэвтрүүлэх талаарх бодит боломжийг Монголбанкинд олгох юм. Банкны өмчлөлийн асуудлыг ил тодоор олон нийтэд зарладаг болно. Улс дамжсан аккредитивыг хууль бусаар нээн будлиантуулдаг урьдын гашуун туршлагаас сургамж авч банкуудын тэнцлийн гадуур хүлээж болзошгүй баталгаа, аккредитив зэрэг үүргүүдийн тухай мэдээг сар тутам банкуудаас авч шалгадаг горимд шилжиж байна.

4.3 Төлбөр тооцооны систем

Банк хоорондын төлбөр тооцоо

Банк хоорондын их дүнтэй гүйлгээний бодит цагийн төлбөр тооцооны систем “Банксүлжээ”-г 2009 оны 5 дугаар сараас эхлэн нэвтрүүллээ. Төлбөр тооцооны бодит цагийн горим нь банк хоорондын гүйлгээ бүрийг тухайн цаг мөчид хүлээн авагч банк руу дамжуулан, үр дүнг бодит цагаар тооцсоноор банкуудад төлбөр тооцооны эрсдэлийг хянах, өөрийн активыг зохистой удирдах боломжийг олгодог. Мөн тухайн орны төлбөрийн бүх системүүдийг (үнэт цаас, валютын арилжаа, бага дүнтэй төлбөр тооцоо гэх мэт) холбох үндсэн систем болдог ач холбогдолтой юм. Банк хоорондын их дүнтэй гүйлгээг “Банксүлжээ”-гээр, харин бага дүнтэй гүйлгээг Төлбөр тооцооны төвөөр дамжуулан гүйцэтгэж байна.


2009 оны эхний хагас жилийн байдлаар нийт 2.4 сая ширхэг 6.3 их наяд төгрөгийн гүйлгээ банк хооронд хийгджээ. Банк хоорондын их дүнтэй гүйлгээ нийт гүйлгээний үнийн дүнгийн 96.1 хувь, бага дүнтэй гүйлгээ 3.9 хувийг эзэлж байгаа бол гүйлгээний тоогоороо бага дүнтэй гүйлгээ нийт гүйлгээний тооны дийлэнх буюу 86 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 3.12. Банк хоорондын гүйлгээний тоо (мянган ширхэг), дүн (тэрбум төгрөг), улирлаар

	2004		2005		2006		2007		2008		6/30/2009	
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
I улирал	586.3	1,086	620.2	1,482	689.7	1,788	758.7	2,359	999.1	3,953	1005.7	3,065
өсөлт(%)	44.3	27.8	5.8	36.4	11.2	20.6	10	31.9	31.7	67.5	0.7	-22.5
II улирал	793.5	1,429	797.5	1,809	851.5	2,743	968.3	3,421	1266.1	4,664	1434.2	3,290
өсөлт(%)	29.7	42.9	0.5	26.6	6.8	51.6	13.7	24.7	30.8	36.3	11.7	-29.5
III улирал	617.3	1,400	541.6	2,057	762.8	2,145	829.1	3,312	603.4	4,435		
өсөлт(%)	9.9	41.9	-12.3	46.9	40.8	4.3	8.7	54.3	-27.2	33.9		
IV улирал	727.1	1,746	391	2,222	910.6	2,847	1098.5	5,230	746.2	5,300		
өсөлт(%)	14.2	39.8	-46.2	27.3	132.9	28.1	20.6	83.7	-32.1	1.3		
Бүгд	1210.8	5,662	2216.8	7,571	3214.6	9,523	3654.6	14,322	3614.9	18,473		
өсөлт(%)	44.3	38.5	83.1	33.7	36.8	25.8	13.7	50.4	-1.08	29		

Банк хоорондын гүйлгээний тоо, сүүлийн жилүүдэд өсч байсан бол 2008 оны 3 дугаар улирлаас эхлэн гүйлгээний дүнгийн өсөлт саарч 2009 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеийнхээс 29.5 хувиар буурчээ.

Зураг 3.32. Банкуудын гүйлгээний дүн, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар



“Банксүлжээ” системийг шинээр нэвтрүүлсэнтэй холбогдуулан Монголбанкнаас 2009 онд “Төв банкнаас олгох өдрийн зээлийн журам”, “Монголбанкны хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл”, “Банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журам”, “Банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцоог гүйцэтгэх ажлын гэрээ”-нүүдийг шинээр болон шинэчлэн баталж үйл ажиллагаандaa мөрдөж байна. “Банксүлжээ” системийг нэвтрүүлснээр системийн оролцогчдын зээлийн, төлбөрийн, хөрвөх чадварын эрсдэлүүд буурах, эдийн засаг, санхүүгийн салбарт хийгдэж буй их дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны тасралтгүй, найдвартай, шуурхай байдал хангагдаж, нууцлал, аюулгүй байдал сайжирч, манай улсын их дүнтэй гүйлгээний төлбөрийн систем олон улсын жишигт хүрлээ.

Банкны картын хэрэглээ

Монголбанк нь төлбөрийн картын нэгдсэн сүлжээ, үр дүнгийн тооцооны зохицуулалтыг бий болгох зорилгоор “Төлбөрийн картын журам”-ыг 2009 оны 8 дугаар сард баталж, хэрэгжүүлж байна. Хаан, Хадгаламж, Худалдаа хөгжлийн банкууд картын төлбөр тооцоог Монголбанкны Төлбөр тооцооны төвөөр дамжуулан гүйцэтгэх туршилтыг хийж эхэллээ. Энэ арга хэмжээг авснаар карт ашиглагчид аль ч ПОС, ПОБ, ATM-ээр үйлчлүүлэх боломжтой юм. Цаашид бусад банкуудыг энэхүү системд нэгтгэх бодлого баримтлана. Банкуудын карт эзэмшигчдийн тоо (давхардсан тоогоор) 2009 оны эхний хагас жилийн байдлаар 1.4 саяд хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 492 мянгаар буюу 51.5 хувиар өсчээ. Харин карт ашиглагчдын тоо 801 мянга болж, өмнөх оны мөн үеэс 480 мянга буюу 149.3 хувиар нэмэгджээ. Хөдөө орон нутагт карт эзэмшигчид 2009 оны 2 дугаар улирлын байдлаар нийт карт эзэмшигчдийн дөрөвний нэгтэй тэнцэж байна.

Хүснэгт 3.13. Карт эзэмшигчид, карт ашиглагчдын тоо

	2008.06.30	2008.12.31	2009.06.30	Жилийн өөрчлөлт (%)	Өөрчлөлт, оны эхнээс (%)
Эзэмшигчдийн тоо <i>Үүнээс: Орон нутагт</i>	954,690	1,182,526	1,446,745	51.5	22.3
Ашиглагчдын тоо <i>Үүнээс: Орон нутагт</i>	321,686	470,773	801,842	149.3	70.3
	633,004	711,753	644,903	1.9	-9.4

*Орон нутгийн үзүүлэлтийг 2009 оны эхний хагас жилийн байдлаар авав.

Банкууд ПОС, ПОБ, ATM, Импринтер төхөөрөмжүүдийг ашиглан картын төлбөр тооцоог гүйцэтгэж байна. Монгол Улсын хэмжээнд банкуудын картаар 2009 оны хагас жилийн байдлаар нийт 610.1 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгджээ. Үүнээс 131.6 тэрбум төгрөг буюу нийт гүйлгээний 21.6 хувь нь орон нутагт ногдож байна.

Хүснэгт 3.14. ПОС, ПОБ, ATM төхөөрөмжийн тоо, хийгдсэн гүйлгээний дүн (тэрбум төгрөг), тоо (сая ширхэг)

Төхөөрөмж	Төхөөрөмжийн тоо				Гүйлгээний мэдээ	Хийгдсэн гүйлгээ			
	2008.VI	2008.XII	2009.VI	2009.VI 2008.XII		2008.VI	2008.XII	2009.VI	2009.VI 2008.XII
ПОС терминал	3,298	3,060	3,381	10.5%	дүн (тэрбум төг.)	245.1	53.2	49.1	-7.7%
					тоо /сая ширхэг/	1.1	0.7	0.7	0.0%
ПОБ терминал	877	1,299	1,253	-3.5%	дүн (тэрбум төг.)	212.3	261.4	221.1	-15.4%
					тоо /сая ширхэг/	1.8	2.2	1.5	-33.0%
ATM төхөөрөмж	157	189	279	47.6%	дүн (тэрбум төг.)	318.6	170.7	339.9	99.1%
					тоо /сая ширхэг/	3.8	5.3	6.6	24.5%
Импринтер төхөөрөмж	-	470	397	-15.5%	-	-	-	-	
Нийт	4,332	5,018	5,310	5.8%	дүн (тэрбум төг.)	776	485.3	610.1	25.7%

4.4. Банкны эрх зүйн шинэчлэл

Монгол Улсын Их Хурлын 2008 оны 11 дүгээр сарын 13-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2009 онд баримтлах үндсэн чиглэл”-д тусгасан Банкны эрх зүйн асуудалтай холбогдуулж Монголбанкнаас дор дурьдсан хуулиудын төслийг боловсруулах эрх бүхий байгууллагын төлөөллөөс бүрдсэн Ажлын хэсгийн үйл ажиллагаанд оролцож, УИХ-аар батлууллаа. Үүнд:

- ◆ “Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль /2009 оны 3 дугаар сарын 6-ны өдөр батлагдсан/-иар баталгаа нь зөвхөн хадгаламж төдийгүй харилцах дансанд нэгэн адил хамаархаар, түүнчлэн баталгаанд үл хамаарах мөнгөн хадгаламжийн талаар тусгасан.
- ◆ “Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай” хууль /2009 оны 7 дугаар сарын 9-ний өдөр/ батлагдсан. Уг хуулиар үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгож үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг барьцаалах, ипотекийн гэрээ байгуулах, үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбогдсон харилцааг зохицуулжээ. Уг хууль батлагдсантай холбогдуулан “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай” хуулинд нэмэлт, өөрчлөлт орсон болно.
- ◆ 2009 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар “Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай” хууль батлагдсан. Энэ хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэр дээр бараа, ажил, үйлчилгээний үнийг төгрөгөөр илэрхийлж, төлбөр тооцоог төгрөгөөр гүйцэтгэж байх харилцааг зохицуулсан болно. Энэ хууль батлагдсантай холбогдуулан “Валютын зохицуулалтын тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Түүнчлэн дараах хуулийн төслүүдийг боловсруулж, боловсруулахад оролцож байна.

- ◆ Төв банк/Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, Банкны тухай хуулийг шинэчлэн боловсруулсан төслийг УИХ-д 2009 оны 7 дугаар сард өргөн барьсан.
- ◆ Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн төслийг боловсруулах УИХ-аас томилогдсон Ажлын хэсэгт ажиллаж байгаа бөгөөд 2009 оны намрын чуулганаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.
- ◆ Валютын зохицуулалтын тухай хуулийн төслийг боловсруулж, яамдаас санал авч нэгтгэж байгаа бөгөөд 2009 оны намрын чуулганаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна.

5. СТАТИСТИКИЙН ХАВСРАЛТУУД

5.1 МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Мөнгөний нийлүүлэлт

Хугацааны эцест	Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө		Үүнээс		Мөнгө (M1)		Үүнээс	
	дүн	сарын өөрчлөлт	Касст байгаа мөнгө	Банкнаас гадуурх мөнгө	дүн	сарын өөрчлөлт	Төгрөгийн харилцах	
2000 03	102,316.4	30.1	7,282.1	95,034.2	30.4	116,237.0	22.4	21,202.8
06	125,507.4	-2.1	6,618.0	118,889.4	1.2	143,684.2	2.7	24,794.8
09	120,879.8	-1.1	6,405.4	114,474.4	-0.4	143,562.4	2.5	29,088.0
12	107,394.4	7.8	6,461.0	100,933.4	7.3	130,775.0	8.9	29,841.6
